

## Өмнөх үг

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөлд газрын харилцааны эрх зүйн орчны шинэтгэлийн хүрээнд гарсан Газрын тухай багц хуулиудаар газрын харилцааны зохицуулалт улам бүр боловсронгуй болж газрын үр өгөөжийг зөвхөн ашиглах бус, хамгаалах, нөхөн сэргээх, газрын харилцаанд оролцогчдод тэгш шударга байдлыг хангасан эрх, үүргийн харьцааг тэнцвэржүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бүрдсэн.

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон сав шимийн ертөнц учраас түүний ашиглалтын цар хүрээ өөрийнх нь унаган чадавхиар тодорхойлогддог. Энэ практик Монгол Улсад нилээд шинэлэг асуудал боловч дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үндэс юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь газар болоод газраас үндэстэй байгалийн баялгийг зөв зохистой ашиглан нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх зарчимд тулгуурласан байдаг бөгөөд монгол оронд үүнийг хэрэгжүүлэх гол механизм нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан хөгжлийн бодлого юм.

Монгол Улсын Газрын Хуулийн хүрээнд газар зохион байгуулалтыг газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газарзүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилготой цогцолбор арга хэмжээ гэж тодорхойлжээ.

Газрын тухай багц хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Даргын Тамгын Газрын захиалгаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг газрын судалгааны мэргэжлийн байгууллага “Газар сервис” ХХК 2005 онд хийж гүйцэтгэв. Төслийг тус компаний зөвлөх мэргэжилтэн Ц.Бадам удирдаж, газар зохион байгуулагч инженер Д.Мөнхцэцэг, У.Өнөржаргал, Л.Уранбилэг, С.Эрдэнэцогт, хөрс судлагч Б.Мөнхбат, эдийн засагч Д.Баясгалант, бэлчээр судлаач П.Мягмарцэрэн, С.Жигжидсүрэн, геоморфологич-хот суурингийн экологич доктор Ч.Батсайхан, цаг уурын инженер доктор М.Баясгалан, Д.Суран, амьтан судлаач Д.Тэрбиш, туслах ажилтан Ш.Ариунаа, Б.Алтанцэцэг, Б.Алтанчимэг болон бусад хүмүүсийн бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэв.

Өвөрхангай аймгийн өнөөгийн болон хэтийн хөгжлийг газар ашиглалтын бодлогоор дэмжих, түүнийг эдийн засгийн хувьд ашигтай, экологийн сөрөг нөлөөлөлгүй байлгахад газрын менежментийн бодлогыг чиглүүлэхэд энэхүү ерөнхий төлөвлөгөөний зорилго оршино.

## **НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ**

### **1.1. Онол - аргазүйн үндэслэл**

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь газарзүйн болон менежментийн шинжлэх ухааны онолын үндэслэл, нийгэм эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээнд суурилагдсан бөгөөд Өвөрхангай аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн иж бүрэн үнэлгээг доорхи суурь судалгаан тулгуурлан хийсэн явдал юм. Үүнд: Уур амьсгал, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, усзүй ба усан хангам, орчны бохирдол, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн судалгаа, газар ашиглалтын одоогийн байдлын судалгаа г.м

Байгаль-нутаг дэвсгэрийн үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд газарзүйн мэдээллийн системийн ArcGis, ArcView 3.2 , Arc INFO 3.5, имиж боловсруулалтын ERDAS 8.4 болон зураглалын AutoCadmap 2000 зэрэг орчин үеийн дэвшилтэт программуудыг ашиглаж орон зайн хувьд дэлхийн координатын нэгдсэн сүлжээнд байршуулан зурган мэдээллийг тоон хэлбэрт шилжүүлснээрээ онцлог бөгөөд газрын харилцааны өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Тус аймгийн суурь судалгаа болон төлөвлөлтийн судалгааг том масштабын буюу 1:100000 масштабын нарийвчлалаар хийж гүйцэтгэсэн бөгөөд хэвлэлтэнд тохиромжтой байх үүднээс суурь судалгааны зургийг тайланд хавсралт хэлбэрээр 1:1 000 000 масштабаар, төлөвлөлтийн эцсийн зургийг 1: 200 000 масштабаар хэвлэж гаргасан юм.

Аймгийн нийгэм-эдийн засгийн нөхцлийн судалгаанд SWOT харьцуулалт-шинжилгээний аргыг ашиглан хөгжлийн давуутай болон сул талыг гаргаж, хөнгөлийн цаашдын хандлагыг төлөвлөлтийн үе шатуудаар тодорхойллоо.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн зарчим нь байгаль нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөцийн боломжид тулгуурласан газрын менежментийн бодлогын бүсүүдийг тодорхойлж, бүс тус бүрийн ашиглалт-хамгаалалтын горимыг тогтоох, газрын нэгдмэл сангийн шилжилт, үүнээс гарах экологи-эдийн засгийн үр ашгийг илрүүлэхэд чиглэгдсэн болно.

### **1.2. Хууль эрхзүйн үндэслэл**

Монгол улсын газрын багц хууль, Хот байгуулалтын тухай хууль, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Бүсчилсэн хөгжлийн тухай хууль, бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал, Хархорин ба Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Удлсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хот байгуулалт, барилгажилт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн стандарт, норм дүрмүүд

## ХОЁР: АЙМГИЙН БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОРЫН НӨХЦӨЛ , НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үндэс нь тухайн газар нутгийн байгалийн нөхцөл, нөөцөд чадавхийн үнэлгээ өгч түүнд зохицсон экологийн хохиролгүй, эдийн засгийн хувьд ашигтай газар ашиглалтын хэлбэрийг илрүүлэн төлөвлөх явдал юм.


### 2.1. Уур амьсгал

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр нь хойд хэсгээрээ Хангайн бүсэд, төв хэсгээрээ тал хээрийн бүсэд, урд хэсгээрээ говийн бүсэд байрлах ба уур амьсгалийн хувьд дээрх 3 бүсэд өөр өөр нөхцөлтэй байдаг.


Өвөрхангай аймгийн газрын эрс тэс уур амьсгал нь тэгш хэмийн хуулийн хуваарилалттай, жилийн 4 улирлын хэв шинж өнгөтэй байдаг. Цаг уурын ажиглалтын олон жилийн дундажаас харвал жилийн дундаж температур Хангайн сумуудад –0-4 градус, хээрийн бүс нутагт 0-2 градус, өмнө талын говийн нутагт 2...4 градус тус тус байдаг. Нарны цацрагийн, цасан бүрхүүлийн, хур чийгшлийн, салхи, агаар мандлын физик үзэгдэл тэдгээрийн тоо хэмжээ, давтагдлын зохистой хуваарилалттай бүс нутаг юм. Монгол орны өргөрөгийн 47 градус, зүүн уртрагын 104 градусын огтолцлолд буюу Бүрд орчимд Монгол орны төв цэг тохирч байдаг Төв цэгийн агаарын жилийн дундаж температур 0 °С, салхины жилийн дундаж хурд 2м/с, жилийн хур тунадасны нийлбэр 200мм, уур амьсгалын хахиршилыг тооцоход 2 балл орчим болдог нь тэгш хэмийн голомт болдог. Өвөрхангай аймагт сүүлийн 50-60 жилд уур амьсгалын хэлбэлзэл үечлэл, өөрчлөлт дулаарал болж байна.

#### Хүснэгт 1. Сар жилийн агаарын температур / °С, дулаан улиралд/


Сар	Хангайн бүс			Говийн бүс			Тал хээрийн бүс		
	I арав хоног	II арав хоног	III арав хоног	I арав хоног	II арав хоног	III арав хоног	I арав хоног	II арав хоног	III арав хоног
IV	-2.3	1.2	3.1	4.0	7.4	9.6	-1.3	1.9	3.8
V	6.0	8.3	10.4	12.9	15.2	17.3	7.0	9.5	11.2
VI	11.8	13.2	14.2	18.8	20.5	22.0	12.9	14.3	15.2
VII	14.0	14.7	15.0	21.6	22.1	22.7	14.8	15.4	15.9
VIII	14.4	12.9	11.5	22.0	20.4	19.1	15.3	13.9	12.5
IX	9.1	6.9	5.0	16.5	14.1	11.9	10.4	8.3	6.8
X	2.6	-0.7	-3.9	9.1	5.6	2.5	4.4	1.3	-0.9



Диаграмм 1. Хангайн бүсийн агаарын температурын хоногийн явц /дулааны улиралд/



Диаграмм 2. Говийн бүсийн агаарын температурын хоногийн явц /дулааны улиралд/




Диаграмм 3. Тал хээрийн бүсийн агаарын температурын хоногийн явц /дулааны улиралд/

Дээрхи хүснэгт болон графикаас харвал тус аймгийн агаарын температурын хэлбэлзэл бүсээр төдийгүй, улирлын заагаар /4, 9-р саруудад/ их хэлбэлзэж дундаж саруудад харьцангуй тогтвортой байна.

**Хүснэгт 2. Сар жилийн хур тунадасны нийлбэр, мм /дулаан улиралд/**

Сар	Хангайн бүс	Говийн бүс	Тал хээрийн бүс
IV	10.1	7.5	7.8
V	24.9	10.3	14.7
VI	53.5	14.3	34.4
VII	91.7	25.2	84.8
VIII	73.0	25.9	64.5
IX	25.6	12.3	20.0
X	7.5	4.4	6.7
X-IV	10.8	16.4	12.7
жил	299.1	116.3	243.7



Диаграмм 4. Хур тунадасны нийлбэр мм/дулаан улиралд

Чийгийн хангамжаар Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийн хувьд хойд хэсэг нь харьцангуй сайн бол өмнөд хэсгээр бага байдаг. Жилд дундажаар хангайн бүсэд 250-300 мм тунадас унадаг бол тал хээрийн бүсэд 200-250 мм, говийн бүсэд 100-150 мм тунадас унадаг нь харилцан адилгүй байгааг харуулна. Хур тунадасны 50-70 хувь нь дулааны улиралд унадаг. Өвлийн улиралд цасан бүрхүүлийн зузаан хангайн бүсэд 3.9 см, тал хээрийн бүсэд 1.0 см, говийн бүсэд 1.0 см орчим (10 хоногийн эцсийн өдрийн байдлаар) байдаг.

Салхитай өдрийн тоо жилд хангайн бүсэд 24, тал хээрийн бүсэд 34, говийн бүсэд 57 байгаа нь говийн бүсэд салхи ихтэй байдаг нь харагдаж байгаа бөгөөд зонхилох чиглэл нь баруун болон баруун хойт зүг юм. /Хавсралт /

Их халуун байх өдрийн тоо хангайн бүсэд сард 2-оос доошгүй байхад говийн бүсэд 6 орчим, тал хээрийн бүсэд 2 орчим байна. Хамгийн халуун сар нь 7-р сар бөгөөд энэ сард зарим бүсэд 10 хүртэл өдөр их халуун байдаг. /Хавсралт /

Уур амьсгалын дээрхи нөхцлүүдийн илэрцийн хэмжээ газрын гадаргуугийн өндөржилт, зүг зовхис, хөрс ургамлан нөмрөгийн онцлогоосоо шалтгаалан өөр байдаг бөгөөд энэ нь байгаль нутаг дэвсгэрийн 3 бүсэд илүү тод илэрдэг.

## 2.2. Ус зүй ба усан хангамж

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт 294 гол горхи байдаг бөгөөд тэдгээрийн уртын нийлбэр 2789 км байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт нийт 110 нуур, 567 рашаан булаг бий. Эндээс харахад гадаргын уст цэгийн 30.3 хувийг гол горхи, 11.3 хувийг нуур, 58.4 хувийг рашаан булаг тус тус эзэлж байна. 2003 онд явуулсан гадаргын усны тоо бүртгэлээр энэ аймагт урсах нийт гол горхины 51 нь ширгэсэн, бүх рашаан булгийн 97 булаг, 3 рашаан нь ширгэсэн, нуур тойрмын 20 нь тус тус ширгэсэн байв.

Гол мөрний усны нөөц 0,56 шоо км, үүнээс ашиглах боломжит нөөц 0,22 шоо км, газрын доорх усны нөөц 0,10 шоо км, үүнээс ашиглаж болох нөөц 0,05

шоо км тус тус байна. Монгол орны өнөө үед жилдээ хагас шоо км буюу Өвөрхангай аймгийн гадаргын усны нийт нөөцтэй дүйцэх хэмжээний усыг жилд ашиглаж байна. Үүнээс үзвэл усны түргэн хугацаанд нөхөн сэлбэгдэх нөөцийг зохистой ашиглах, хамгаалах үндсэн дээр хөгжлийн өндөр түвшинд хүрэх боломжтой аймаг юм.

Хамгийн том гол нь Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал болох Орхон гол юм. Ус хурах талбай нь 132855 ам км буюу Сэлэнгэ мөрний сав газрын 47% болно. Голын урт 1124 км учир Монголын хамгийн урт гол болно. Сав газрын эх нь Хангайн нурууны зүүн хойт хажуу бөгөөд Монголын хамгийн том Улаанцутгалангийн хүрхрээ тэнд оршино. Орхон гол үерлэхээрээ Хархорин сумаас доош орших Өгий нуурт усаа юулж эргэж гулдрилдаа орох учир хур борооны хамгийн их үер энэ хэсэгтээ 600 шоо м/с-ээс хол давахгүй, голын гулдириллын ёроолд эхэндээ хайрга чулуу адагтаа элс хайрга зонхилно.

Хоёр дахь том гол бол Хангайн нурууны өврөөс эх авч 435 км урсахдаа 52920 ам км талбайгаас усжин Улаан нуурт цутгах Онги гол юм. Эл гол олон жилийн дундаж өнгөрөлт Уянга сумын орчим 1,52, Дундговь аймгийн Сайхан-овоо сумын орчим 1,52 шоо м/с, энэ голын урсац 1988 оны 7 дугаар сард Уянга сумын орчимд 1,20 шоо м/с, Онги, Улаан голын бэлчир, Арвайхээр орчимд нэмэгдэж 3,4 шоо м/с хүрээд Сайхан-Овоо сумын орчимд ширгэсэн байв.

Энэ аймгийн томоохон голуудын нэг нь Хангайн нурууны өвөр хажуугаас усжих Таац гол юм. Голын урт 200км, ус хураах талбай 9190 ам км байна. Энэ голын олон жилийн дундаж өнгөрөлт Нарийнтээл сумын орчим 1,12 шоо м/с хүрээд их устай жилд Таацын Цагаан нуурт цутгаж, гантай жил нуурт хүрэлгүй сэвсгэр хурдсанд шургана. 1988 онд Нарийнтээл сумын орчимд өнгөрөлт 0,67 байснаа уулнаас мултармагц Тариат багийн орчим 0,46 шоо м/с хүртэл буурч цаашид улам багасч нуураас дээш 20 км-т ширгэж байжээ. /Зураг №1/

### 2.3. Хөрс, хөрсөн бүрхэвч

Тус аймгийн хөрсөн бүрхэвч үндсэндээ доор дурьдсан хөрс үүсгэгч эх чулуулаг дээр үүсэн тогтжээ.

Делювийн дунд шавранцар хурдас- Д  
Делювийн хөнгөн шавранцар хурдас- Д  
Элюви-делювийн хөнгөн шаварлаг хурдас- ЭД  
Эртний аллювийн дунд шаварлаг хурдас- А  
Эртний аллювийн хүнд шаварлаг хурдас- А

Нутгийн уулархаг хэсгээр элюви-делювийн хурдас, тэдгээрийн бэл хормой зэрэг газраар делюви, том жижиг голын сав хөндийгөөр аллюви болон өмнө говь цөлөрхөг хэсэгт багтах газраар элюви эоловийн хурдсууд тус тус тархсан байна.

Делювийн хурдас нь уулсын налуу, хажуунууд, тэдгээрийн хоорондох ам хөндийнүүд, голын нуга дэнж, намхан уул толгод гүвээнүүд зэрэг янз бүрийн гадрагаар э тархана. Делювийн хурдас нь байгалийн элдэв хүчин зүйл /салхи, ус газар хөдлөлт/ -ийн нөлөөгөөр үүсэн тогтдог. Делювийн хурдас нь ихэвчлэн хөнгөн шавранцар ба элсэнцэр, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байдаг. Делювийн хурдас ерөнхийдөө сийрэг хөвсгөр, шинж чанартай зарим газартаанилээд нягтарсан бүтэцтэй, гол төлөв цайвардуу бор, шавранцар цагаан өнгөтэй, уулархаг, ам хөндий хэсэгтээ чулуурхаг байдал харьцангуй багасна.

Эх чулуулаг нь голдуу карбонатлаг ихтэй учир ихэвчлэн хөрсний уусмалын орчин нь шүлтлэг чанартай. Шинжилгээний дүнгээс үзэхэд рН 6.0-7.0-той тэнцүү байна. Хөрс үүсгэгч эх чулуулагийн механик бүрэлдэхүүний шинжилгээнээс үзэхэд 0.01мм-ээс бага хэмжээтэй жижиг хэсгийн агууламж хөнгөн шавранцар хурдаст 20-30%-ын хооронд хэлбэлзэж элсэнцэр хурдаст 10-20%-ын хооронд, элсэрхэг хөрсөнд 0-10% хүртэл тус тус агууламжтай байна. Тийнхүү хөрс үүсгэгч эх чулуулагийн механик бүрэлдэхүүн харилцан адилгүй байгаа нь хөрсний ус физикийн шинж чанараар адилгүй болохыг харуулна.

Аймгийн нутаг дэвсгэр нь газар зүйн тархалт байршилд үндэслэсэн хөрсний дараах тойргуудад багтана. Үүнд: Хангайн нурууны зүүн ба зүүн өмнөт уулын хөрсний тойрог, Хангай, Монгол-Алтайн нурууны хамгийн зүүн хэсгийн хоорондох өргөн удам тал хээрийн хүрэн хөрсний тойрог, Монгол-Алтайн нурууны хамгийн зүүн хэсэг Бага богд, Арц богдын нурууны уулын цайвар хүрэн хөрсний тойрог болон Алтайн цаадах зүүн өмнө говьд хамаарагдах цөлөрхөг хээрийн бор хөрсний тойрог.

Хөрсний тархалтын байдлыг зураг /2/, бүтцийг хүснэгт 3-аар тус тус харууллаа.

### Хүснэгт 3. Өвөрхангай аймагт тархсан хөрс

Хөрсний нэршлийн код	Хөрсний нэр	Талбай	
		га	хувь
Уулын хөрс			
1102	Уулын тундрын ширэгт ухаа шороон хөрс	42064.7	0.67
1205	Уулын тайгын цэвдэгт хүлрэнцэр ялзмагт хөрс	2219.8	0.04
1304	Уулын бага зэрэг чулуурхаг үлдмэл карбонаттай хар шороон хөрс	85392.6	1.36
1401	Өндөр уулын нугын бага зэрэг чулуутай үлдмэл карбонатлаг хөрс	9117.7	0.14
1402	Өндөр уулын нугын их чулуутай цэвдэгт хөрс	38801.7	0.62
1501	Уулын их чулуутай сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрс	390208.3	6.20
1502	Уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрс	1458975.9	23.20
1503	Уулын сулавтар хөгжилтэй цайвар хүрэн хөрс	550650.1	8.76
1601	Уулын цөлөрхөг хээрийн дунд зэргийн чулуутай бор хөрс	46636.1	0.74
Тал хөндийн хөрс			
2101	Ердийн хар шороон хөрс	4761.9	0.08
2102	Бага зэрэг чулуутай карбонатлаг хар шороон хөрс	10265.5	0.16
2106	Нугын мараалаг хүрэн хөрс	192901.9	3.07
2202	Хээрийн хар хүрэн хөрс	12923.6	0.21
2203	Нимгэн бага зэрэг чулуутай хүрэн хөрс	845355.8	13.44
2204	Нимгэн цайвар хүрэн хөрс	1219706.5	19.39
2301	Цөлөрхөг хээрийн бор хөрс	632798.4	10.06
2302	Хээржүү цөлийн цайвар бор хөрс	53131.1	0.84
2303	Цөлөрхөг хээрийн мараалаг бор хөрс	54671.2	0.87
2305	Цөлийн бор саарал хөрс	58492.0	0.93
2310	Эоловийн сулавтар хөгжилтэй элсэн хөрс	159521.8	2.54
Бүс дундын хөрс			
3101	Нугын сулавтар хөгжилтэй хужирлаг хөрс	71601.2	1.14
3107	Нугат намгийн лаг шаварт карбонатлаг хөрс	1528.7	0.02
3108	Нугат намгийн цэвдэгт хөрс	10090.8	0.16



3110	Хүлэрт намгийн хжирлаг хөрс	23367.5	0.37
3201	Аллювийн нуга намгийн мараалаг хөрс	4779.1	0.08
3206	Аллювийн нугын бага зэрэг чулуутай мараалаг хөрс	151327.2	2.41
3210	Аллювийн нугын хээршсэн хөрс	17448.2	0.28
Хөрс бус бүрдлүүд			
41	Уулын эх чулуулагийн илэрц	504.2	0.01

Хөрсний төрлийн хувьд 44.3 хувь буюу 2787941.9 га нь ердийн буюу хэвийн, 5.1 хувь буюу 321860.1 га мараалаг, 2.9 хувь буюу 182483.2 га нь хужирлаг, 0.7 хувь буюу 42742.1 га карбонатлаг, 1.4 хувь буюу 86485.7 га үлдмэл карбонатлаг, 43.4 хувь буюу 2727730.5 га нь сулавтар хөгжилтэй байна.

Хөрсний механикийн бүрэлдэхүүний хувьд 0.2 хувь буюу 10438.1 га нь хүнд шавранцар, 38.2 хувь буюу 2402179.4 га хөнгөн шавранцар, 3.1 хувь буюу 193460.1 га дунд шавранцар, 56.3 хувь буюу 3542661.6 га нь элсэнцэр механикийн бүрэлдэхүүнтэй.

Тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн 90 шахам хувь нь ХАА-н газар байдгийг харгалзан хөрсний агроүйлдвэрлэлийн шинж чанарыг газар ашиглалтын зориулалт, хөрсний чанар ба чадавхид тулгуурлан үнэлэв. /Хүснэгт 4/

#### Хүснэгт 4. Хөрсний агроүйлдвэрлэлийн бүлэглэл

Агрогруппийн дугаар	Агроүйлдвэрлэлийн группэд орж буй хөрсний нэр	Агрогруппэд орж буй хөрсний индекс	Талбай /га/	Газар ашиглалтыг сайжруулах арга хэмжээнүүд	
				Аж ахуйн зохион байгуулалт	Агротехникийн ба усжуулалт
Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрс					
I	Зузаан ба дунд зэргийн зузаан, дунд шавранцар, дунд бага зэрэг чулуурхаг, чулуутай хүрэн хөрс, нугын хар хүрэн хөрс /хүнд шавранцар/	2203, 2202	732473.80	30%-ийг уриншилж 70%-ийг 70-100м өргөнтэй зурваслан тариалах, ЭТС хэрэглэх	Тариалангийн талбайн боловсруулалтыг хөрсний эвдрэлтэй тэмцэх иж бүрэн техникээр гүйцэтгэх
				Бэлчээрийн талбайг зөв зохион байгуулж 100га-д 90-100 толгой мал байлгах	Бэлчээрт үндсэн ба өнгөн сайжруулалт хийх
Тариаланд тохиромжтой дунд чанарын хөрс					
II	Нугын карбонатлаг бага зэрэг чулуутай хар шороон хөрс, нугын хар шороон хөрс дунд зэргийн зузаан бага	2102, 2101, 2202, 2203, 2106	228974.4	Зурваслан тариалалтын зурвасын өргөн 75-100м. ЭТС-ийг хийх	Хагалгааны гүнийг 22см-ийн гүнд хавж хагална.

	зэрэг чулуурхаг, хар хүрэн, дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг хүрэн, нугын хүрэн ба мөн хөрсний төрлүүд			Бэлчээрийн сэлгээг зөв зохион байгуулж 100га-д 70-80 толгой мал байлгах	Хувиартай ашиглах ба өнгөн сайжруулалт хийх
Тариаланд тохиромжтой доод чанарын хөрс					
III	Нимгэн хүрэн, зузаан цайвар бага зэрэг чулуутай хүрэн хөрс, мөн цөлөрхөг хээрийн мараалаг, нугархаг бор хөрс	2204, 2303	1105724.41	2 талбайтай сэлгээг хэрэглэх хөрсний эвдрэлтэй тэмцэх	Химийн янз бүрийн хорт бодисын илүүдэл болохоос хамгаалах органик ба эрдэс бордоогоор бордох
				Хадлангийн сэлгээг зөв зохион байгуулах	Өнгөн сайжруулалт хийх
				Бэлчээр ашиглалтыг 100га-д 50-60 толгой мал байлгахаар з/б-лах	Өнгөн сайжруулалт хийх
Хадланд тохиромжтой дээд чанарын хөрс /тариаланд ашиглаж болох боловч төдийлөн тохиромжтой бус хөрс/					
V	Алювийн сулавтар хөгжилтэй ба намгийн бүрдэл хөрс	3206	167525.57	Тэжээлийн тариаланг сэлгээтэйгээр ашиглах	20-25см гүн эргүүлж хагалах
				Хадлангийн сэлгээг зөв зохион байгуулах	Өнгөн сайжруулалт хийх
				Бэлчээр ашиглалтыг 100га-д 100 толгой мал байлгахаар бэлчээрлүүлэх	Үндсэн ба өнгөн сайжруулалт хийх
Хадланд тохиромжтой доод чанарын хөрс					
VII	Уулын намгийн-цэвдэгт ялзмагт хөрс. Нуга намгийн цэвдэгт намагт, нуга намгийн карбонатлаг, хүхэрлэг намгийн хужирлаг нугын мараалаг бүрдэл хөрс. Алювийн нуга-намгийн давсархаг бүрдэл хөрс	3108, 3201,	111367.18	Хадлангийн сэлгээг зөв зохион байгуулах	Хадлангийн тохиромжтой газрыг нь сонгон хадах
				Бэлчээрт бүрэн бус ашиглагддаг	Улирлын байдалтайгаар сонгож ашиглах
Бэлчээрт тохиромжтой сайн чанарын хөрс					

VIII	Уулын тундрийн ширэгт, уулын хар шороон уулын нугын уулын хар хүрэн хөрс, зузаан ба нимгэн бага зэрэг чулуурхаг, чулуутай хүрэн хөрсний төрлүүд	1102, 1304, 1409, 1501, 502,202,203, 204,106,69,303, 210,101	514624.65	Бэлчээр ашиглалтыг 100га-д 60-80 толгой мал байлгах аар зохион байгуулах	Хувиартай ашиглах өнгөн ба үндсэн сайжруулалт хийх
IX	Уулын хүрэн цайвар хүрэн хөрсний бүрдэл, цөлөрхөг хээрийн дунд зэргийн чулуутай, чулуурхаг бор хөрс	502,503,601	2741004.19	100га бэлчээрт 90-100 толгой мал байлгах аар тооцох	Хувиартай ашиглах үндсэн сайжруулалт хийх
Бэлчээрт тохиромжтой доод чанарын хөрс					
X	Сулавтар хөгжилтэй хүрэн хөрс нимгэн хүрэн хөрсний бүрдэл дов толгодын хүрэн нимгэн хүрэн хөрсний бүрдэл, зузаан цайвар, хүрэн хөрсний хэв шинж дүрс төрлүүд	203,204,51,301, 302,305,83	337655.05	Бэлчээрийн сэлгээг зөв зохион байгуулах 100га бэлчээрт 20-40 толгой мал байлгах аар тооцох	Бэлчээрийг хэсэг, суурь, бригадуудад хувиартайгаар эзэмшүүлэх
XI	Өндөр уулын нуга, нугархаг хөрс	401,4,	49868.19	100га-д 50-иас илүүгүй толгой мал байлгах аар зохион байгуулах	Зөвхөн зуны бэлчээрт ашиглах
Ашиглах боломжгүй газрын хөрс					
XIII	Сул бэхжсэн элсэн хөрс ба уулын эх чулуулгийн илэрц	310,99	160026.1	-	-

## 2.4. Ургамал- ургамлан бүрхэвчийн онцлог

Хангай нурууны чийглэг сэрүүн уур амьсгал, өндрийн бүс бүслүүрийн ялгаа, мөн говь, тал хээрийн бүс бүслүүрийн ялгааны нөлөөгөөр Өвөрхангай аймгийн ургамлан бүрхэвч өндөр уулнаас дундаж уулс нам хотос хүртэл нилээд ялгавартайгаар бүрэлдсэн. Ургамлын бүтэц бүрэлдэхүүн нь хангайн бүсэд баялаг байхад тал хээр болон говийн бүс шилжих тусам сийрэгжиж байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ургамлан нөмрөгийн судалгаагаар тус аймгийн нутаг дэвсгэрийн ургамалжилт, төрх байдлыг улсын хэмжээнд мөрдөж буй бэлчээр хадлангийн ангилгаагаар ангилгахад өндөр уулын бэлчээр - Ө, дундаж өндөр болон нам бэсрэг уулын бэлчээр - У, уул хоорондын нарийн хөндийн - УХ, тал хээрийн -Х, голын хөндий, нам хотосын нугын -Н гэсэн бэлчээр 5 ерөнхий хэв шинжид хамруулж 7 анги, 14 бүлэг төрөл, 61 төрөлд хуваажээ. Мөн ашиглалтын улмаас талхлагдсан 25 үндсэн төрлийн өөрчлөлтийг 32 хувилбараар ангилж зурагт харуулав. / зураг 3/ .

**Өндөр уулын бэлчээр нь** нийт нутгийн 3.23 хувийг эзлэх ба уулын царам, өндөр уулын нуга, өндөр уулын нугат хээр болон хээр, чулуурхаг хээрийн ургамалжилттай байна. Нутгийн хойд хэсгийн Хангайн нурууны өмнөд хэсэг болон зүүн өмнө үзүүрийн өндөр ууланд тархсан.

**Уулын бэлчээр нь** нийт газрын 37.02 %ийг эзлэх ба нугархаг хээр, хуурай хээрийн, цөлөрхөг хээрийн ургамалжилттай байна. Нутгийн хойт хэсгийн өндөр болон нам уулсын орой, энгэр хажуугаар хялгана-алаг өвст, зүр өвс-алаг өвст, биелэг өвс-алаг өвст, ботууль-улалж--алаг өвст уулын нугархаг хээрийн бэлчээр тархах ба уулын энгэрээр нь ботууль-алаг өвст, сөөг бүхий алаг өвс-үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст төрлүүд голлоно.

*Хялгана-алаг өвст* төрөл нь харьцангуй хуурайвтар газраар нилээд түгээмэл тархах бөгөөд ургамлын ерөнхий бүрхэц 60-65 %, крыловын хялгана 30-35%-ийн бүрхэцтэй ургах ба үетэнээс дааган сүүл, улаан ботууль, туужууны биелэг оролцож алаг өвснөөс хоёр ишт бэриш, түмэн навчит ортууз, яргуй, сибирийн дурсгал цэцэг зэрэг алаг өвс 15-20 %-ийн бүрхэцтэйгээр тус тус ургана. Ургамлын дундаж өндөр 15-20см, зуны дундаж ургац 5.7ц\га, 100кг тэжээлд нь 52.9 тэжээлийн нэгж агуулагдана. Энэ төрөл нь улирлын чанартай бэлчээрт ашиглагдана.

*Зүр өвс-алаг өвст* бэлчээр нь чулуурхаг бэсрэг уулс тэдгээрийн хажуугаар тохиолдоно. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд сибирийн зүр өвс, шивээт хялгана, дааган сүүл, улаан ботууль, туужууны биелэг алаг өвснөөс хоёр ишт бэриш, марал навчит гичгэнэ, яргуй, хонгор зул зэрэг ургамал ургана. Ургамлын дундаж өндөр 25-30 см, зуны дундаж ургац 5.0ц\га, 100кг тэжээлд нь 49.5 тэжээлийн нэгж агуулагдана. Энэ ангийн бэлчээр нь бүх төрлийн малд тохиромжтой боловч өвлийн улиралд цас хунгарлаж голдуу хүйтэн салхитай байх тул хүрч ашиглахад бэрхшээлтэй байдаг.

*Ботууль-алаг өвс-үетэн-улалжит* төрөл уулын нилээд чийгтэй, нугархаг хэсгээр хааяа тохиолдож байсан бөгөөд хялгана-алаг өвст бэлчээрийг бодвол улалжийн оролцоо ихэсч ирсэн байв. Энд ургамлан нөмрөгийн ерөнхий бүрхэц 70-75%, ботууль 20-25% хүртэл бүрхэцтэйгээр зонхилж хөх яргуй, хэвлэг гиш, түмэн навчит ортууз, хоёр ишт бэриш, өрөмтүүл, бэр цэцэг, уул өвс, хурдан цагаан, туужууны биелэг, шивээт хялгана, шеллийн бутнуур, өлөнгө ургах бөгөөд зогдор улалж зарим хэсэгт толболон үзэгдэнэ. Ургамлын дундаж өндөр 20-25 см, зуны дундаж ургац 6.0 ц\га байгаа нь өмнөх судалгааны \1974\ үеэс төдийлэн буураагүй байна. Өвсний шимт чанараар дунд зэрэг үхэр адуунд тохиромжтой бэлчээр юм. Уулын бэлчээр нь улирлын чанартай бэлчээрт ашиглагдана.

**Өндөр уул хоорондын болон нам уулсын хоорондох нуга хөндийн бэлчээр /УХ/** нь нутаг дэвсгэрийн 1.36 % тархах ба ургамалжилтын байдлаар авч үзвэл бушилз-үетэнт /ӨХ-I-1-1/, бушилз-улалжит /ӨХ-I-1-2/, үетэн-алаг өвст \УХ-II-1-1\, үетэн-улалж-алаг өвст \УХ-II-2-1\, алаг өвс-улалж-үетэнт\УХ-II-3-3\, улалж--үетэнт \УХ-II-4-1\, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээржсэн нуга \УХ-II-2-4\, ботууль-алаг өвст хээржсэн нуга \УХ-II-2-5\ бүлгэмдэл зонхилжээ. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нугын дурваалаг, нугын биелэг, шеллийн бутнуур, соргүй согоовор, хиаглай түнх, монгол туйпланцар, улаан толгойт, сөд өвс, марал навчит гичгэнэ, галуун гичгэнэ, коржинскийн улалж голлон бүрдүүлнэ. Ургамлын ерөнхий бүрхэц 70-80 %, дундаж өндөр 28-40 см, зуны дундаж ургац нь төрлөөсөө шалтгаалан 9.3-12.3ц\га, шимт чанар нь 39.8-50.7 тэжээлийн нэгж байдаг. Бэлчээр болон хадланд ашиглагдана.

**Тал хээрийн бэлчээр /Х/ нь** нийт нутгийн 9.73 %-ийг эзлэнэ. Ургамалжилтийн хувьд ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст, хялгана биелэгт болон түүний талхлагдсан хувилбарууд болох ботууль-жижиг дэгнүүлт үетэн-агьт, агь-ботуульт, хялгана-агьт, агь-хялганат, хялгана-агь-биелэгт, агь-хялгана-биелэгт төрлүүд зонхилохын дээр хиаг-агь-алаг өвст, агь-хиагт, хялгана-үетэн-агьт, хялгана-зүр өвст төрлүүд ч тохиолдоно.

*Хялганат бүлгэмдлүүд /Х-I-2/ нь* хамгийн их тархалттай бөгөөд ургамлын ерөнхий бүрхэц 45-50%, ургамлын зүйлийн тоо 4-6, ургамлын өндөр 12-15 см байдаг, зүйлийн бүрэлдэхүүнд хялгана зонхилж ишгүй навтуул, хөх яргуй, цайвар шар цагаан түрүү, бор цоохор цахилдаг, шүдлэг сонгино, хоёр ишт бэриш зэрэг элдэв өвс ургахын зэрэгцээ үетэнээс дагуурын биелэг өвс, туяхан дааган сүүл, хиаглай түнх, саман ерхөг оролцон ургана. Шимт чанар сайтай 100 кг тэжээлд нь 48.6 тэжээлийн нэгж агуулагдана. Ямар ч улиралд бүх төрлийн малд тохиромжтой. Жилийн 4 улиралд сэлгээгүй ашигласанаас талхлагдсан бэлчээрт ургамлын ерөнхий бүрхэц сийрэгжиж 35-40%, зүйлийн 3-4 болсон байна. Мөн зүйлийн бүрэлдэхүүнд агь өндөр бүрхэцтэйгээр түрэн орж иржээ.

*Жижиг дэгнүүлт үетэнт /Х-II-2/ бүлгэмдлийн* хэвшинжид хялгана, туужууны биелэг, дааган сүүл, ленийн ботууль, дэрвээн хазаар өвс, алаг өвснөөс: буурал гандбадраа, нумраа хунчир, хянгар царгас, ишгүй гичгэнэ, хавчиг гичгэнэ, жинхэнэ өрөмтүүл, арзгар согсоолж, алаг цэцэгт башир, фишерийн бэр цэцэг зэрэг ургамлууд оролцох ба тусгагийн бүрхэц 50-55%, ургамлын өндөр 12-20 см. Жилийн турш адуу, үхэр, хонь, ямаа бэлчээрлүүлэхэд тохиромжтой. Үүний улмаас өөрчлөлт орсон хувилбарт зонхилох ургамал нь үетнээс: ширэг улалж, нангиад хиаг, крыловын хялгана, саман ерхөг, алаг өвснөөс: агь, ямаан шарилж, арзгар согсоолж, ишгүй гичгэнэ зэрэг ургамлууд ургана. Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 35-40%, ургамлын өндөр 3-10 см болжээ.

**Цөлөрхөг хээрийн бэлчээр /ЦХ/ нь** нутгийн өмнөд хэсэг болон зүүн өмнөд хэсгээр голлон тархах бөгөөд нийт нутгийн 24.79 хувийг эзэлнэ. Ургамалжилтын хувьд гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн дэгнүүлт үетэнт /ЦХ-I-1/, алаг өвст /ЦХ-I-2/, сөөгт /ЦХ-I-3/ бүлэг төрлийн бүлгэмдэл зонхилно.

**Говь, цөлийн бэлчээр /Ц/ нь** Баруунбаян-Улаан, Богд сумдад голлон тархах бөгөөд нийт нутгийн 5.86 хувийг эзэлнэ. Голлон баглуур бударганат /Ц-I-1-2/, хойргот /Ц-I-2-3/, нохой шээрэнт /Ц-I-2-5/, бударгана-монгол өвс-таанат /Ц-I-1-5/ бүлгэмдэл зонхилно.

**Нугын бэлчээр /Н/ нь** Орхон, Онги, Таац болон бусад голын хөндий, нуурын захын аллювийн нугын хээржсэн болон аллювийн нуга-намгийн хөрстэй нуга, нам хотсоор тархаж, нийт нутгийн 8.81 %-ийг эзэлнэ.

Ургамалжилтын хувьд *Улалж-алаг өвст /Н-I-2-4/ ба Улалж-үетэнт /Н-I-2-2/, дэрс-өлөнгөт /Н-III-3-3/, дэрс-алаг өвст /таанатай/ /Н-III-3-4/ бэлчээр* давамгайлна. Бүрдүүлэгч ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд улалжнаас: дэгнүүлт улалж, цэх түрүүт улалж, шмидтийн улалж, үетнээс: нугын биелэг, марцны гол өвс, мөлхөө хиаг, монгол улаан толгойт, дорнодын тор өвс, ахар сорт арвай, алаг өвснөөс: намгийн дүндэггарав, намгийн холтсон цэцэг, дэрэвгэр жиргэрүү, хянгар царгас, их таван салаа, энгийн буржгар, галуун гичгэнэ, эмийн багваахай, ишгүй азаргана зэрэг ургамлууд оролцохоос гадна бүрхэц арвин 65-70% байна. Харин талхлагдсан хувилбарт нь шарилжны оролцоо ихсэж 15-20 % -иар дэд зонхилгогч болсон байна. Голын хөндийн дэнжирхэг хэрсгээр тархсан аллювийн нугын болон аллювийн хээржсэн, үелэсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татмын нугын 1172 га

талбайд хиаг-алаг өвст, үетэн-улалж-алаг өвст, шарилж-үетэн-улалжит, улаан толгой-шарилжит, улалж-үетэн-шарилжит тархах ба өнөөгийн байдлаар бараг нийтдээ талхлагджээ.

**Бэлчээрт тохиромжгүй бэлчээр /БТ/ нь** нийт нутгийн 5.93 хувийг эзлэх бөгөөд энд ургамалгүй чулуурхаг газар, хад асга, сайр, элс орно.

Өвөрхангай аймаг нь Хангайн нуруунд байрласан учир нэн ховор, ховор биологийн төрөл зүйл ихтэй бөгөөд ургамлын судалгаанаас харвал дундаж өндөр уулын бүслүүрт 5, уулын нугад 5, тал хээрт 4, голын татамд 6 зүйл ургамал тус тус тааралджээ. Нэн ховор ургамлын жагсаалтад орсон 133 ургамлаас 10, Монголын улаан номонд орсон 100 гаруй зүйл ургамлын 20 зүйл ургамал тус аймгийн 21 цэгт тэмдэглэгдснийг мэдээллийн санд оруулж өглөө.

### Хүснэгт 5. Өвөрхангай аймгийн ургамалжилт

Зураг дээрх индекс	Ангиллын шифр	Ургамлын нэр	Талбай	
			га	хувь
	<b>Ө</b>	<b>Өндөр уулын бэлчээр</b>	<b>202954.3</b>	<b>3.23</b>
2	Ө-I-1-2	Боролжтой Зожир өвс- бушилзат	6535.5	0.10
6	Ө-II-1-3	Бушилз- жижиг дэгнүүлт үетэнт	62735.7	1.00
8	Ө-III-1-1	Ботууль- бушилз- улалжит	55762.4	0.89
9	Ө-III-1-2	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвс- бушилзат	6779.9	0.11
10	Ө-IV-1-1	Жижиг дэгнүүлт үетэн-бушилзат	59009.2	0.94
11	Ө-IV-1-2	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвс- агьт	12131.6	0.19
	<b>У</b>	<b>Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр</b>	<b>2328627.2</b>	<b>37.02</b>
12	У-II-1-1	Хиагт- алаг өвст	3812.8	0.06
14	У-II-2-2	Ботууль- алаг өвст- улалжит	94847.2	1.51
18	У-II-2-6	Үетэн- алаг өвст	68120.3	1.08
20	У-II-2-8	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст	95668.9	1.52
22	У-II-2-10	Хялгана - алаг өвст	138.6	0.00
23	У-II-3-1	Зүр өвст, Зүр өвс- алаг өвст	967.1	0.02
24	У-II-3-2	Алаг өвст- үетэн- улалжит	2080.3	0.03
27	У-II-4-1	Сөөгөн ширэнгэт	7662.6	0.12
28	У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст	88553.8	1.41
29	У-III-1-2	Ботууль- алаг өвст	81683.9	1.30
32	У-IV-2-1	Ботууль- алаг өвст	198333.6	3.15
33	У-IV-2-2	Ботууль- хялганат	23000.1	0.37
35	У-IV-2-4	Биелэг- алаг өвст	3357.5	0.05
36	У-IV-2-5	Хялганат, Хялгана- алаг өвст	96380.9	1.53
39	У-IV-2-8	Хялгана- үетэнт	46914.5	0.75
40	У-IV-2-9	Хялгана- хазаар өвст	57889.7	0.92
41	У-IV-2-10	Хялгана- харганат	52993.7	0.84
42	У-IV-2-11	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст	139680.2	2.22
43	У-IV-2-12	Жижиг дэгнүүлт үетэн- хялганат	17543.5	0.28
44	У-IV-2-13	Үетэн- алаг өвст	11098.4	0.18
45	У-IV-2-14	Хазаар өвс- хялганат	43024.5	0.68
47	У-IV-3-1	Харгана- үетэнт, Үетэн харганат	31458.7	0.50
48	У-V-1-1	Ботууль- алаг өвс- агьт	56092.0	0.89
49	У-V-1-2	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвс- агьт	189576.5	3.01

50	У-V-1-3	Хялгана- алаг өвст	53660.4	0.85
56	У-V-2-1	Алаг өвс - агь - үетэнт	12884.1	0.20
58	У-VI-1-1	Монгол өвс- ерхөгт	136966.1	2.18
59	У-VI-1-2	Монгол өвс- хазаар өвст, Хазаар өвс- монгол өвст	187573.8	2.98
60	У-VI-1-3	Монгол өвст, Монгол өвс- боролзойт	180114.6	2.86
61	У-VI-1-4	Монгол өвс- таанат	111019.6	1.77
66	У-VI-1-9	Ионгол өвс- баглуурт	175203.8	2.79
68	У-VI-2-1	Боролзой- монгол өвст	82.4	0.00
71	У-VII-1-1	Баглуур- монгол өвст	28372.6	0.45
73	У-VII-1-3	Бударгана- монгол өвст	31870.5	0.51
	<b>ӨХ</b>	<b>Өндөр уулын хоорондох нуга хөндий</b>	<b>19249.1</b>	<b>0.31</b>
78	ӨХ-I-1-1	Бушилз- үетэнт	7628.8	0.12
79	ӨХ-I-1-2	Бушилз- улалжит	11620.3	0.18
	<b>УХ</b>	<b>Нам уулсын хоорондох нуга хөндий</b>	<b>66225.6</b>	<b>1.05</b>
82	УХ-II-1-1	Үетэн- алаг өвст	1077.8	0.02
85	УХ-II-2-1	Үетэн- улалж- алаг өвст	33624.7	0.53
87	УХ-II-2-3	Бутнуур - алаг өвс - улалжит	1763.9	0.03
88	УХ-II-2-4	Жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст хээржсэн нуга	10493.4	0.17
89	УХ-II-2-5	Ботууль- алаг өвст хээржсэн нуга	6205.7	0.10
90	УХ-II-2-6	Биелэг- үетэн- алаг өвст	601.4	0.01
93	УХ-II-3-3	Алаг өвс- улалж- үетэнт	3318.1	0.05
96	УХ-II-4-1	Улалж- үетэнт	9140.6	0.15
	<b>Х</b>	<b>Тал хээрийн бэлчээр</b>	<b>612085.5</b>	<b>9.73</b>
98	Х-I-1-1	Хиагт, Хиаг- алаг өвст	1325.8	0.02
99	Х-I-1-2	Хиаг- жижиг дэгнүүлт үетэнт	16121.6	0.26
103	Х-I-2-2	Ботууль-хялганат, хялгана-ботууль	11822.6	0.19
104	Х-I-2-3	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	107156.4	1.70
105	Х-I-2-4	Хялгана- хиагт	30648.1	0.49
106	Х-I-2-5	Хялгана- хазаарт	65487.1	1.04
109	Х-I-2-8	Хялгана- монгол өвст	5519.1	0.09
110	Х-I-2-9	Хялгана, хялгана- алаг өвст	50035.6	0.80
112	Х-I-2-11	Жижиг дэгнүүлт үетэнт	98448.7	1.57
114	Х-I-2-13	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	17504.3	0.28
115	Х-I-2-14	Биелэг- үеэнт, Биелэг хиагт	6867.9	0.11
116	Х-I-2-15	Дааган сүүл-үетэнт	5270.9	0.08
121	Х-II-1-1	Хиагт	4583.6	0.07
123	Х-II-2-2	Жижиг дэгнүүлт үетэнт, жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст	32832.1	0.52
124	Х-II-2-3	Жижиг дэгнүүлт үетэн- хялганат	23830.7	0.38
126	Х-II-2-5	Хялгана- жижиг дэгнүүлт үетэнт	41769.5	0.66
128	Х-II-2-7	Үетэн- алаг өвст	20993.2	0.33
129	Х-II-2-8	Үетэн- харганат	17139.3	0.27
132	Х-II-2-11	Хазаар өвс- хялганат	36950.7	0.59
133	Х-II-3-1	Алаг өвс- үетэнт	4208.1	0.07
136	Х-II-4-1	Харгана- хялганат	2079.0	0.03
137	Х-III-1-1	Хиаг- үетэнт, Хиаг- алаг өвс- агьт/шавагт/	11491.3	0.18
	<b>ЦХ</b>	<b>Цөлөрхөг хээрийн бэлчээр</b>	<b>1559082.0</b>	<b>24.79</b>
142	ЦХ-I-1-1	Монгол өвст	305505.3	4.86

143	ЦХ-I-1-2	Монгол өвс- хазаар өвст	153629.3	2.44
144	ЦХ-I-1-3	Монгол өвс- боролзойт	59525.9	0.95
145	ЦХ-I-1-4	Монгол өвс- шавагт	103132.5	1.64
146	ЦХ-I-1-5	Монгол өвс- харганат	137789.2	2.19
148	ЦХ-I-1-7	Монгол өвс- таана- бударганат	317929.2	5.05
149	ЦХ-I-1-8	Монгол өвс- баглуурт	89343.8	1.42
151	ЦХ-I-1-10	Монгол өвс- бударганат	40814.6	0.65
153	ЦХ-I-1-12	Хазаар өвс- монгол өвст	97543.1	1.55
154	ЦХ-I-1-13	Хазаар өвс- таана- жижиг алаг өвст	28174.8	0.45
157	ЦХ-I-2-1	Боролзой- монгол өвст	19078.0	0.30
158	ЦХ-I-2-2	Таана- монгол өвст	102172.6	1.62
159	ЦХ-I-2-3	Агь- шаваг- монгол өвст	2141.6	0.03
161	ЦХ-I-3-1	Харганат	102302.1	1.63
	<b>Ц</b>	<b>Говь цөлийн бэлчээр</b>	<b>368394.9</b>	<b>5.86</b>
164	Ц-I-1-2	Баглуур- бударганат	108648.1	1.73
165	Ц-I-1-3	Баглуур- таанат , Таана- баглуурт	11445.1	0.18
166	Ц-I-1-4	Бор бударгана- таана- баглуурт	125843.7	2.00
167	Ц-I-1-5	Бударгана- монгол өвс- таанат	37785.4	0.60
168	Ц-I-1-6	Улаанбударгана- бударганат	3359.5	0.05
170	Ц-I-1-8	Бударгана- таанат, таана- бударганат	8672.2	0.14
173	Ц-I-2-1	Зээргэнэт	432.9	0.01
175	Ц-I-2-3	Хойргот	15983.5	0.25
177	Ц-I-2-5	Нохой шээрэнт	24255.7	0.39
181	Ц-I-2-9	Сийрэг загт	5497.7	0.09
182	Ц-II-1-1	Сульт, Сульт- үетэнт	7911.1	0.13
183	Ц-II-1-2	Сульт- элсний шарилжит	340.4	0.01
188	Ц-II-4-1	Харганат	6195.9	0.10
191	Ц-II-4-4	Холимог сөөгт	12023.7	0.19
	<b>Н</b>	<b>Бүс дундын голынхөндий, нам хотосын нугын бэлчээр</b>	<b>554024.1</b>	<b>8.81</b>
193	Н-I-1-2	Зэгс-үетэнт	699.2	0.01
195	Н-I-2-2	Улалж-үетэнт	7365.3	0.12
197	Н-I-2-4	Улалж- алаг өвст	1283.2	0.02
198	Н-II-1-1	Үетэн-алаг өвст	3968.8	0.06
201	Н-II-2-1	Үетэн- алаг өвст	26834.8	0.43
202	Н-II-2-2	Үетэн- цахилдаг- алаг өвст	28355.5	0.45
205	Н-II-2-5	Үетэн-алаг өвст хээржсэн нуга	12801.5	0.20
207	Н-II-3-2	Алаг өвс- улалжит	996.1	0.02
208	Н-II-4-1	Улалж- үетэн- алаг өвст	26505.0	0.42
214	Н-III-1-1	Өлөнгө- шарилж- алаг өвст	11689.1	0.19
216	Н-III-1-3	Үетэн- дэрст	48605.7	0.77
218	Н-III-2-2	Үетэн- шарилж- алаг өвст	22602.3	0.36
219	Н-III-2-3	Үетэн-жижиг улалжит	1953.4	0.03
221	Н-III-3-2	Дэрс- хиаг- алаг өвст	19468.5	0.31
222	Н-III-3-3	Дэрс-өлөнгөт	78244.8	1.24
223	Н-III-3-4	Дэрс-алаг өвст (таанатай)	68081.8	1.08
224	Н-III-3-4	Дэрс-жижиг улалжит	26190.7	0.42
225	Н-III-3-6	Дэрс- бударганат	45539.0	0.72



226	H-III-4-1	Алаг өвс-үетэнт (лууль шарилжтай)	153.1	0.00
227	H-III-4-2	Цахилдаг- үетэнт (тор өвстэй)	3253.4	0.05
228	H-III-5-1	Жижиг улалж- үетэнт	11664.6	0.19
229	H-III-5-2	Жижиг улалж алаг өвст	5990.8	0.10
230	H-IV-1-1	Шарилж- үетэнт	8056.9	0.13
232	H-IV-2-1	Шар бударгана- дэрст	6164.4	0.10
233	H-IV-2-2	Шар бударгана	11959.0	0.19
235	H-IV-2-4	Бударганат	904.3	0.01
236	H-IV-2-5	Бударгана- дэрст	8944.7	0.14
237	H-IV-2-6	Бударгана- хармагт	30221.1	0.48
238	H-IV-3-1	Хармагт	4492.8	0.07
239	H-IV-3-2	Сийрэг загт	2783.9	0.04
243	H-V-3-1	Холимог сөөгт	28250.6	0.45
	<b>БТ</b>	<b>Бэлчээрт тохиромжгүй газар</b>	<b>372942.1</b>	<b>5.93</b>
245	БТ-1	Мөнх цас	21794.6	0.35
246	БТ-2	Хад, цохио, асга	274014.8	4.36
247	БТ-3	Сайр	176.2	0.00
248	БТ-4	Элс	61335.5	0.98
250	БТ-6	Ургамалгүй чулуурхаг газар	15621.1	0.25

## 2.5 Ан, амьтан

Тус аймгийн нутагт 7 баг (Монгол улсын нуагт байгаа хөхтний багийн 87,5%), 15 овог (мөн 65%), 49 төрөлд (мөн 67%) хамаарах 73 зүйл (мөн 52,9%) нутагладаг. Энд Монгол орны дэлэнт амьтны 8 багийн 7 нь буюу саарьтнаас (тэмээ) бусдын төлөөлөгч аль нэг хэмжээгээр (10, 11, 19) тохиолддог. Тухайлбал, тайгын: баданга хүдэр, нохой зээх, модны үен, ойт хээрийн: цагаан зээр, монгол тарвага, сүүлэрхэг зурам, цайвар үлийч, говийн: хар сүүлтий, хулан адуу, бозлог зурам, алагдаагынхны олон зүйл, өндөр уулын: янгир ямаа, цоохор ирвэс, аргаль хонь, суусар булга, хадны барагчин гэх мэт байгаль газарзүйн янз бүрийн бүс бүслүүрт зохицсон олон янз амьтантайгаараа (10-12 19) бусад аймгаас тодорхой ялгарна.

Нутгийн хойд хэсгийн Хангайн нуруу, түүний зүүн захын салбар уулсаас эхэлсэн Орхон голын савын эх нь гол горхи цэнгэг нуурт зүйл зүйлийн загас элбэгийн дотор тул *Hucho taimen*, зэвэг *Brachymystax lenok*, шивэр ха дран *Thymallus arcticus* зэрэг агнуурын (4) үнэт загаснууд бий. Аймгийн нутагт суурин болон нүүдлийн олон зүйл жигүүртэн шувуу бий. Нүүдлийн шувуу ирсэн дулааны улиралд шувууны зүйлийн тоо, нөөц баялаг хэд дахин нэмэгддэг. Шувуудын дотор хурынхан *Tetraonidae*, тагтааныхны *Columbidae* агнуурын ач холбогдолтой зүйлүүд байна. Орхоны эхний Хангайн өндөр уулсаар цагаан ятуу *Lagopus lagopus*, ойд нь хур *Lyrurus tetrix*, Говийн алтайн уулсаар хахилаг *Alectoris chukar*, хээр, хаяа нам уулсаар дагуур ятуу *Perdix daurica*, тоодог *Otis tarda*, Нууруудын хөндий, говиор ногтруу *Syrhaptes paradoxus*, бараг бүх уулсаар хадны тагтаа *Columba rupes-trik* зэрэг суурин цөөн зүйл байдаг.

Нугасныхны *Anatidae* бор галуу *Anser anser*, бор нугас *Anas strepera* зэрэг нүүдлийн усны арав гаруй зүйл (8, 21) бий.

Агнуурын хөхтөн амьтны бүрэлдэхүүн, тархац нөөцийн тойм: Аймгийн нутагт тархсан 73 (монгол улсын хөхтний зүйлийн 53% ) зүйл хөхтнөөс уламжлалтагнуурын амьтан гэгдэх доорх 34 (46,5%) зүйл бийн дотор 22 зүйл (64,7%) нь агнуурын “үндсэн” буюу одоо мөрдөж байгаа монгол улсын ан агнуурын хуулийн дагуу агнан ашиглаж болох ерийн ан болж байна.

Үүнд: Туулайтан бор туулай, чандага туулай, Мэрэгчтэн: бараан хэрэм, замба жирх, монголтарвага, сүүлэрхэг зурам, бозлог зурам, зээрд сохдой, Махчтан: саарал чоно, шар үнэг, хярс үнэг, суусар булга, нохой зээх, цагаахан үен, ойн үен, солонго үен, үмхий үен, эрээн мххүрэн, халздай дорго, цоохор ирвэс, мануул мий, цоохондой мий, шилүүс мий, туруутан: хулан адуу, зэрлэг гахай, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, хар сүүлтий, цагаан зээр, янгир ямаа, аргаль хонь зэрэг болно.

Уламжлалт үнэт үндсэн чухал ан аргаль хонь, янгир ямаа, халиун буга, баданга хүдэр, хар сүүлтий, цагаан зээр, монгол тарвага, хулан адууны тархац нутаг хомсдож, тоо толгой нь эрс цөөрч ховордсоноос олонхи нь “Монгол улсын ан агнуурын тухай хууль” болон “Амьтны аймгийн итухай” (16,17), манай улсын нэгдэн орсон олон улсын конвенци, эрхзүй, ёсзүйн бусад акт, баримтлалын (18, 25, 29, 30) дагуу агнуураас албан ёсоор чөлөөлөгдсөн байна. Харин урьд агнуурт хоёр, гуравдугаар зэргийн ач холбогдолтой, тохиолдлоор шахам агнадаг байсан туслах чанарын холбогдолтой, өөрөөр хэлбэл нэг талаас агнуурын шууд ашиг өгөөж, зах зээлийн үнэ цэнэ бага, хүч хөдөлмөр илүү зарцуулдаг, нөгөө талаас байгалийн орчин зүйн(экологийн) тэнцвэрт байдал, хөгжилд чухал оролцоо холбогдолтой зурам, үенгийн хэд хэдэн зүйл, маануул мий, халздай дорго зэрэг тус аймагт угаас бага тархацтай цөөн байдаг ан амьтан үндсэн ан болж үлдсэн байна. Монгол тарваганы нөөц баялаг улам багассаар байгаа нь эдийн засагт төдийгүй байгалийн орчин тогтолцооны бүрэн бүтэн тэнцвэр байдалд сөрөг нөлөөтэй байна.

## 2.6. Экологийн өнөөгийн нөхцөл байдал.

Тус аймагт орчны бохирдлыг бий болгох хүчин зүйлсийн тоонд гэр хороолол, уурхай, үйлдвэрүүд орох ба одоогийн байдлаар уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр түүнд олгогдсон эдэлбэрээс гадна орчны бэлчээрийн газрын төлөв байдал чанар доройтжээ. Гэвч энэ нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд харьцуулбал маш бага үзүүлэлттэй байна. Хот суурингийн газруудад дэд бүтэц, шугам сүлжээ хөгжөөгүйгээс хөрс, ус, агаарын бохирдол нэмэгдэх хандлагатай.

**Агаарын бохирдол:** Арвайхээр хотын нутаг дэвсгэрийн газрын гадарга нь нилээд задгай рельефтэй, гол төлөв баруун ба баруун хойноос салхилдаг тул утаа агаарт угаарт тогтнохгүй сарнидаг нь агаарын бохирдолд эерэгээр нөлөөлдөг. Гэвч гэр хорооллын дутуу шаталттай зуух болон уурын зуухнуудаас гарсан утаа салхигүй намуун өдрүүдэд агаарт тогтож нүүрс хүчлийн дутуу эслийн хэмжээг үлэмжхэн нэмэгдүүлдэг боловч бохирдлын хэмжээгээр Улаанбаатар Эрдэнэт хотуудаас хавьгүй бага байна. Мөн хотын доторхи автотээврийн хэрэгсэл агаарын бохирдолд сөргөөр нөлөөлж нүүрсхүчлийн хий /CO/, угаар /CO/ нүүрсустөрөгч /HC/-ийг ялгаруулдаг ба үүнийг багасгах, хяналт тавих талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

**Усны бохирдол:** Өвөрхангай аймгийн гадаргын усан сүлжлэл ойт хээрийн аймгуудыг бодвол харьцангуй бага ба нутгийн хойт хэсэгт гадаргын усан хангамж харьцангуйдээр боловч, өмнөд хэсэг гүний усаар хангагдаж байна. Усны бохирдлын гол шалтгаан болдог хотжилт, уурхай, үйлдвэрлэлийн бөөгнөрөл бөгөөд тус аймгийн Хархорин хот, Бат-өлзийт сумын төв зэргээс бусад нь голын эрэг орчмын бүсээс хот оршдог. Энэ нь гүний ба гадаргын усны бохирдлоос сэргийлж байна.

**Хөрсний бохирдол:** Хөрсөн бүрхэвч механик үйлчлэл болон биологийн гаралтай эх үүсвэрүүдээс нилээд бохирддог боловч химийн гаралтай бохирдлын мэдээлэл үгүй байна.

Аймгийн хэмжээнд 132.9 мянган га тариалангийн газар атаршиж, 14.6 мянган салхины эвдрэлд өртөж, 1.2 мянган га хөрс бохирдож, 514.9 мянган га бэлчээр талхлагдаж, 11.7 мянган га хортон мэрэгчдэд нэрвэгдэж, 1.6 мянган га уурхайн нөлөөгөөр эвдэрсэн байна.

Хөрсөн бүрхэвч тачир сийрэг ургамлан нөмрөгтэй, хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй, нимгэн ялзмагт үетэй тул харьцангуй эмзэг хөрсний өнгөн хэсэг зулгармагц карбонат болон хялбар задрах давс хуримтлагдсан цайвар шороон давхаргаас CO<sub>2</sub> агаарт ууршиж агаар дахь түүний агууламжийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Хөрсний бохирдлыг үүсгэж байгаа өөр нэг эх үүсвэр нь хатуу хог хаягдал бөгөөд түүнийг зайлуулах, устгах албан ёсоор зөвшөөрөгдсөн цэгт хүргэж хаях үйл ажиллагааны доголдлоос зориулалтын бус цэгүүд үүсч, гуу жалга, гудамж талбайд эмх замбараагүй хаяж байгаа нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэсч байна. Хог хаягдлын эх үүсвэрийг төрлөөр нь авч үзвэл ахуйн, аж ахуйн нэгж байгууллагын, ахуй үйлчилгээний, үйлдвэрийн, барилга байгууламжийн, гудамж талбайн цэвэрлэгээний хог байна. Хог хаягдлын цэгийн тоо, байршил, талбайн хэмжээ, хог хаягдлын шинж байдал, түүнийг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах арга хэмжээ болон устгал, зайлуулалтын байдал туйлын хангалтгүй байгаагаас цаас, нийлэг уут, картон цаас, нийлэг материал нь салхи шуурганд хийсэж орчныг бохирдуулж хогийн талбайг зохиомлоор тэлж байгаа нь ч ажиглагдлаа.

## **2.7. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн муж**

Газрын харилцааг хөгжүүлэх, газар ашиглалтыг төлөвлөх, газрын нөөцийг үнэлэхэд байгалийн нөхцлийг тус бүрд нь үнэлэхэд учир дутагдалтай байдаг. Иймээс өмнөхи хэсэгт тодорхойлсон Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийн геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамшил, амьтны аймгийн хам бүрдэл, тэдгээрийн хоорондын ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцлүүдээр нь мужлах шаардлагатай байдаг.

Монгол Улсын газрын нөхцөл нөөцийг үнэлэх, түүний ашиглалтын бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлох зорилгоор нийт нутаг дэвсгэрийг байгалийн үндсэн элемент, бүсшлийн ялгааг харгалзан газрыг 3 бүс, 12 муж, 31 тойрог хуваан мужилсан ба муж бүрд хамрагдах газрыг ангилан хувааж газар ашиглалтын үндсэн чиглэлийг тодорхойлсон юм. /Д.Даш, Ц.Бадам 2002/

Тус аймгийн нутаг дэвсгэрийн ландшафт бүрэлдэхэд Хангайн болон Говь-Алтай нурууны уулт гадарга, Дундад халхын нам уулс, цав толгод, хангай, тал хээр, говийн уур амьсгал ихээр нөлөөлсөн байна.

Монгол Улсын газар нутгийн мужлалаар ангилж үзэхэд тус аймгийн нутаг дэвсгэрт Хангайн бүсийн 1 муж, 2 тойрог, Говийн бүсийн 2 муж 2 тойрог, Тал хээрийн бүсийн 1 муж 1 тойрогт ялгарч байна. Муж, тойргийн хуваарилалтыг дараах хүснэгтээр харуулав. /Хүснэгт 6, зураг 4/

**Хүснэгт 6. Аймгийн нутаг дэвсгэрийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужууд**

Д/д	Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай /га/
1	Алтайн ар говийн цөлөрхөг муж	Нууруудын хендийн тойрог (Г-4)	494553.8
2	Говийн Алтайн уулсын муж	Их, Бага Богдын уулсын тойрог (Г-5)	643766.9
3	Дорнод говийн цөлөрхөг муж	Дорнод говийн хойт хэсгийн тойрог (Г-9)	981863.8
4	Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн муж	Дундад халхын тэгш өндөрлөгийн тойрог (Т-1)	1402554.0
5	Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж	Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5)	2104187.0
6	Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж	Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6)	672115.3
<b>Бүгд</b>			<b>6299040.8</b>

**Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5)-т** уулзүйн сүлжээг Хангайн гол ба өмнөд тэгш өндөрлөг болон салбар уулс бүрэлдүүлэх ба уур амьсгал нь зундаа сэрүүвтэр, жилдээ 200-290 мм тунадас ордог ба 1 дүгээр сарын дундаж агаарын температур Хужиртад  $-21.1^{\circ}\text{C}$ , Арвайхээрт  $-14.7^{\circ}\text{C}$  байдаг байна. 7 дугаар сард дунджаар  $14.6-16.2^{\circ}\text{C}$  байна. Дулааны улирлын цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 80-100 хоног бөгөөд энэ нь хавар 5 дугаар сарын сүүлч 6 дугаар сарын эхнээс 9 дүгээр сарын эх хүртэл үргэлжилнэ. Агаарт  $0 \dots -2^{\circ}\text{C}$  цочир хүйтрэл болох нь дунджаар 10 удаа,  $-3 \dots -4^{\circ}\text{C}$  хүрч хүйтрэх нь 4-5 удаа,  $-5^{\circ}\text{C}$ -аас доош хүчтэй цочир хүйтрэх нь дулааны улиралд дунджаар 2 удаа тохиолддог байна. Энэ нутагт их халуун болох үед цочир хүйтрэх, мөндөрт цохиулах зэргээр эрсдэлтэй боловч ерөнхийдөө газар тариалан эрхлэхэд харьцангуй тохиромжтой нутаг юм.

**Ургамал нөмрөг.** Ургамалжилтын хувьд Хангайн нурууны олонхи уулсын хажуугаар ботууль-алаг өвст, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст уулын хээр өргөн тархсан байх ба тэнд Ленийн ботууль, саман дурваа, сунагар биелэг, сибирь ботууль, сибирь ба байгаль хялгана Шеллийн бутнуур зэрэг үетэн, зогдор, өлөн, хигмэл бивлэнцэр, одой далантүрүү, дагуур тайр, нарийн навчит тарна, цомогт баавар цэцэг зэрэг ургамлууд голлох байр эзлэнэ.

Өргөн хөндийнүүддээ хуурай шивээт хялгана, шивээт хялгана-агьт хээртэй. Харин хангайн нурууны баруун болон өвөр хэсгээр их хээржсэн тул түүгээр дамжин цөлөрхөг хээрийн ургамал энэ мужид нэвтэрсэн байдаг.

Одоогийн байдлаар 1214 зүйл ургамал бүртгэгдээд байгаагийн 151 зүйл өвслөг ургамал (тойргийн ургамлын 12.44% ), 1063 зүйл модлог болон сөөглөг ургамал (87.51%) байна. Зүйлийн бүрдлээрээ хамгийн баялаг мужид орж байгаа бөгөөд модлог болон сөөглөг ургамлын тоо хамгийн олонбайгаа нь уулын хээр, тайгын ойн шинжийн аль алиныг нь харуулж, өндөр уул элбэгтэй тул тагийн ургамал ихтэйг, тойргийн захаар том том элсэн манхан шургаж орсон, нуур голын давс хужиртай эрэг, марз мараатай голууд байдгийг илтгэж байна.

Хангайн тэгш өндөрлөгийн тойргийн Хангайн нурууны өндөр ба дундаж өндөр уулаар зожир өвст, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын ба уулын нугын ялзмагт хөрстэй, бушилзат бэлчээр бөгөөд уулын цармын бэлчээр нь зун-намар сарлагт тохиромжтой. 5.5-6 ц/га тэжээлийн нөөц бүхий 350-400 кг/га тэжээлийн нэгжтэй. Харин сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт нугат-хээрийн, чулуурхаг хар хүрэн ба хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-ерхөг-хялганат, ерхөгт хуурай хээрийн бэлчээр зун-намар бог мал, үхэр, адуунд тохиромжтой, 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-550 кг/га тэжээлийн нэгжтэй.

Таацын голын сав дагуу нунтаг карбонатлаг хүрэн, хар хүрэн хөрстэй жижиг бутлаг үетэн-хялганат, хазаар өвс-хялганат дов толгод ба талархаг хуурай хээрийн бэлчээртэй. 7-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намар үхэр, адуунд тохиромжтой.

**Ан амьтан.** Энэ мужид нийтдээ 5 ангийн 338 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 51.9 % нь оршин амьдардаг байна /6-р хүснэгт/.

**7-р хүснэгт. Сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн**

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	17	1	1	5	-	29
Овог	15	42	4	2	8	-	71
Зүйл	64 (46.0%)	251 (60.5%)	4 (19.0%)	2 (33.3%)	17 (10.0%)	-	338 (51.9%)

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 багт хамаарах 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 46.0 % болж байна. Эдгээрийн дотор шавжичтан, далавчтан тус бүр 5, туулайтан 6, мэрэгчтэн 26, махчтан 14, туурайтан 8 зүйл тус тус байна. Дэлэнтэн дотор зүйлийн тоогоор мөн л мэрэгчтэн /эндэхийн хөхтөний 40.6%/ , махчтан / 21.8%/ зонхилно.

Энэ мужийн нутаг дэвсгэрт хойноос умрын ой тайгын зүйлүүд /нохой зээх, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, чандага туулай, асганы огодой, бараа хэрэм/, өмнөөс Төв азийн хээрийн зүйлүүд /Монгол тарвага, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг, мануул мий, дагуур огодой, боролзон туулай, хэргэлзий оготно гэх мэт/, мөн өндөр уулын амьтан /аргаль хонь, янгир ямаа, суусар булга, цоохор ирвэс, тагийн огодой гэх мэт/ харилцан нэвтрэлцэж сууршсанаар онцлог. Энэ тойрогт агнуурын чухал ач холбогдолтой уламжлалт ангийн 24 зүйл амьтан тэмдэглэгдсэнээс 15 зүйлийн тархац нутаг, тоо толгой аль

нэг хэмжээгээр багасан цөөрч ховордсоны дотор 2 зүйл /цоохор ирвэс, голын халиу/ бараг устаж, 5 зүйл /суусар булга, мануул мий, баданга хүдэр, аргаль хонь, янгир ямаа/ ихээхэн ховорджээ. Эндхийн дэлэнтэнээс монголын улаан номонд 5 зүйл /янгир ямаа, аргаль хонь/, олон улсын улаан номонд 2 зүйл /нохой зээх, саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтанд 4 зүйл, /аргаль хонь, янгир ямаа, халиун буга/ оржээ.

**Шувуу.** Энэ мужид 17 баг, 42 овгийн 251 зүйл шувуу тэмдэглэсэн нь манай орны шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 60.5 % болно. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлэх бөгөөд дараа нь хөгчүү хэлбэртэн, шонхор хэлбэртэн, галуу хэлбэртэн тус тус ордог. Ийнхүү Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн нутаг дэвсгэрт оршин амьдрах дээрх 4 багийн 203 зүйл шувуу нь уг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 80.8 %-ийг эзэлдэг ажээ.

**Мөлхөгчид.** Энэ мужид хайрстны баг, гүрвэлийн салбар багт хамаарах замба гүрвэлийн овгийн цоохор хонин гүрвэл /*Phrynoscephalus versicolor*/, жинхэнэ гүрвэлийн овгийн монгол гүрвэл /*Eremias argus*/, могойн салбар багт хамаарах хар могойн овгийн рашааны могой /*Elaphe dione*/, хорчигнуурт могойн овгийн бамбай хоншоорт могой /*Aqkistrodon halys*/ гэсэн 4 зүйл тэмдэглэгдсэн бөгөөд эдгээр нь Орхоны сав оочин цоочин тархалттай юм. Нөгөө хоёр зүйл могойн хувьд Хангайн мужийн ойт хээр, хээр, уулын хээр, нуга, намаг гэх мэт бараг бүх хэв шинжийн биотопд оршин амьдарна. Ялангуяа булаг, шандын эх, халуун, хүйтэн рашааны орчмоор элбэг.

**Хоёрнутагтан.** Хангайн мужид сүүлгүй хоёр нутагтны багт хамаарах бахын овгийн монгол бах /*Bufo raddei*/, мэлхийн овгийн шивэр мэлхий /*Rana amurensis*/ гэсэн 2 зүйл амьтан тэмдэглэжээ. Гол төлөв Хойд мөсөн далайн ай савын усан сангуудаар тархсан, элбэг тохиолдох зүйлүүд юм. Хангайн нурууны өврөөс эх авч Нууруудын хөндийд усаа нийлүүлдэг Түй, Онгийн голын эх орчмын нутаг, тэдгээрийн ай савд багтах булаг, шандаар монгол бах нилээд элбэг.

**Загас.** Энэ тойргийн Орхон ба Онгийн голын ай савд дан ганц уулархаг Азийн цэнгэг усны *Oreoleuciscus* төрлийн 3 зүйлээс гадна *Phoxinus* ба *Nemachilus* төрлийн агнуурын холбогдолгүй жижиг загаснууд бий.

**Ландшафтын онцлог.** Хангайн гол нуруунд өндөр уулын нуга түүнийг дагасан бут сөөгөн ширэнгэ ян оргилын намаг, хад чулуун нураг даган ноёрхдог. Өндөр уулын нугууд нь нэгэн жигд хэв шинжтэй бөгөөд энэ нь харьцангуй цөөн зүйл алаг өвс бүхий бушилз, бушилз –улалжит бүлгэмдлээс бүрдэнэ. Дээшлэхэд бушилзат нуга дундуур нураг асга бий болж түүнийг хэсэгхэн хувааж талбайг нь багасгана. Үүнээс бүр дээшлэхэд нүцгэн хад асга, нураг болж хувирах ба тэдгээрийн зайд тагийн цөөн зүйл ургамал ургана. Хангайн нурууны өндөрлөг хэсгээр ой багавтар тохиолдоно.

**Орхон – Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6)-т** Хангайн нурууны зүүн салбар дундаж, нам уулс, Орхон голын хөндий бүрдүүлнэ. Орхон гол бол Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал бөгөөд хангайн өндөр уул Суваргахайрхан / 3200 м / - аас эх авч, Хангайн уулсаас гадна харин өөрийн баруун гарын том цутгалууд болох Туул, Хараа ба Ерөөгөөр дамжин Хэнтийн уулархаг орноос усжина. Орхон гол нь Хархориноос доош 40 км хүртэл өргөн бөгөөд бас нэг зэрэгцээ гол болох

хөгшин Орхоноор усжиж хээрийн хөндийгөөр урсана. Орхон голын зүүн гарын цутгалуудаас томоохон нь Тамирын гол юм. Тамирын хөндий нь дунд ба адаг хэсэгтээ өргөн тавиу / дундчаар 4-5 км / байх ба голын гольдролын өргөн нь 15 – 30 метрийн хооронд байна. Орхон голын дагуух ухаа гүвээрхэг гадаргатай нутагт ихээхэн хэрчигдсэн элэгдлийн гадарга зонхилох бөгөөд тэдгээрийн хооронд намаг, багахан нуурт хотгорууд түгээмэл тархжээ. Гадаргын байдал ихээхэн намагжсан явдал тус орны хойт хэсэгт тархсан мөнх цэвдэгт ул хөрстэй шууд холбоотой байдаг.

**Уур амьсгалын** нь өмнөхи тойргоос арай зөөлөн 7 дугаар сарын дундаж агаарын температур нь 17-20<sup>0</sup>С, хоногийн дундаж агаарын температур 10<sup>0</sup>С-ийн заагийг хавар 5 дугаар сарын сүүлчээр, намар 9 дүгээр сарын дунд үеэр тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 117-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250<sup>0</sup>С-ийн дулаан хуримтлагддаг.

Хавар эцсийн цочир хүйтрэл олон жилийн дунджаар 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын эхээр шувтарч намар анхны цочир хүйтрэл 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр тохиолддог. Цочир хүйтрэлгүй байх хугацаа 80÷100 хоногт хүрэх бөгөөд 90 хоног байх магадлал 75% байдаг. Дулаан хангамжийн хувьд энэ мужид буудайн эрт болцын сорт, арвай, хошуу будааны эрт ба дунд болцын сорт, вандуй, төмс зэрэг ургамлыг тариалах бололцоотой. Дулааны улиралд 250-300 мм хур тунадас ордог. Харин Орхоны хөндийд хээрийн бүсийн шинж арай илүү байдаг онцлогтой. Энэ нутагт жилдээ 250-300 мм хур тунадас ордог. Өндөр уулсаар нь ой зонхилох бөгөөд хус, улиангар заримдаа бага зэрэг холилдон ургасан өвслөг ургамалт шинэсэн ой тохиолдоно. Орхоны голын хажуугийн цутгал намагжсан, татам нь шугуй торлог ихтэй. Зүйлийн бүрдэл нь алаг цоог бөгөөд ботууль, туужууны өвс, саман ерхөг зэрэг үетнээс гадна алаг өвс нилээд элбэг. Харин уулсын нөгөө талаар хуурай хээрийн бүлгэмдэл болох хазаар өвс-хялганат, зүр өвс-хялганат, хялгана-навтуулт хээр тааралдана. Уулс хоорондын хөндий нь намагжсан бөгөөд энд үетэн, үетэн-улалжит нуга нам бургаснаас бүрдсэн багавтар шугуй бий. Орхон голын сав дагуу намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт-улалжит, татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий нугын алаг өвст нугын бэлчээртэй. 26-29 ц/га тэжээлийн нөөцтэй, 1900-2100 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой. Ан амьтаны хувьд өмнөхи тойрогтой адил юм.

#### 8-р хүснэгт. Сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэн-тэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	6	18	1	2	6	-	33
Овог	16	45	3	4	11	-	79
Зүйл	58 (41.7%)	219 (52.7%)	5 (23.8%)	4 (66.6%)	24 (14.2%)	-	310 (47.6%)

**Ландшафтын онцлог.** Эндхийн ландшафтад уулын тайгын ширэгт хөрстэй үетэн бүхий нарс-шинэс болон уулын тайгын цэвдэгт хөрстэй давжаа бут-ногоон хөвд бүхий шинэсэн ойгоос бүрдэх тайга, татмын нуга, ойт хээр, нугат хээр зонхилох рольтой. Эндхийн ойд хусан ой түрж ургах явдал хааяагүй тохиолдоно. Ялангуяа ойн түймрийн дараа шинэс, нарсан ойд хус ихээр түрж ургадаг байна.

Иймд дурьдсан нутагт алаг өвс-улалжит шинэсэн ой, түүний оронд ургасан хусан ой нэлээд том талбай эзэлнэ.

Томоохон голуудын татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана. Эндхийн ихэнх цутгал уулын жижиг голуудын татам дагууд сөөгөн ширэнгэ бүхий намгархаг нуга давамгайлна.

**Алтайн ар говийн цөлөрхөг мужийн Нууруудын хөндийн тойрог / Г – 4 /** Хангайн өмнөт тэгш өндөрлөг ба Говийн Алтайн хойт хэсгийн уулсын хооронд өргөрөгийн дагуу орших урт хотгор багтдаг бөгөөд тус аймгийн баруун өмнөд хэсэг Таацын цагаан нуур орчмын газар хамрагдана. Энэ хотгорын хойт, өмнөт хажуугаар үлдэц нам уулс, цав толгод түгээмэл тархсан байна. Нууруудын хөндийн зүүн зах нь Онгийн гол, Улаан нуур орчмын талархаг газраар төгсөнө. Энд нууруудын хөндийн зүүн төгсгөл Дорнод говийн өндөрлөг талтай хиллэж оршино. Энэ мужид эх газрын уур амьсгалын эрс тэс нөхцөл хамгийн тодорхой илэрдэг. Энд өвөл, зуны болон өдөр шөнийн температурын зөрүү хамгийн их, өөрөөр хэлбэл өвөлдөө нэн хүйтэн, зундаа халуун, хуурай уур амьсгалтай. 1 дүгээр сарын дундаж агаарын температур  $-20 \div -23^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй хамгийн их хүйтэн нь  $-40.5 \div -45.0^{\circ}\text{C}$  хүрдэг. 7 дугаар сарын дундаж температур  $+20 - 24.2^{\circ}\text{C}$  орчим байна. Агаарын үнэмлэхүй их температур  $34.0 - 38.0^{\circ}\text{C}$  хүрдэг.

Хаврын сүүлчийн цочир хүйтрэл дунджаар 5 дугаар сарын сүүлчээр дуусаж, намар дунджаар 9 дүгээр сарын 12-ноос цочир хүйтрэл болж эхэлдэг. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 112-120 хоног үргэлжилдэг.

Жилд дунджаар 50.0-78.0 мм хур тунадас ордог. Нууруудын хөндийн тойрогт багтах Таацын цагаан нуурын орчмоор элсэрхэг, цөлийн бор сараал хөрстэй баглуурт цөлийн бэлчээртэй. 3-4 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун намарт тэмээнд тохиромжтой.

Ан амьтны бүрэлдэхүүнд Алтайн ар говийн цөлөрхөг мужийн бүх төрлийн биотопор тохиолдох өргөн тархалттай бөгөөд тооны хувьд зонхилох зүйлүүд нь дэлдэн зараа, уссаг багваахай, умардын сарсаахай, сахалт багваахай, үхэр огодой, боролзон туулай, бозлог зурам, шаргал чичүүл, орог зузга, хөх шишүүхэй, сүүллэг шишүүхэй, говь шишүүхэй, зээрд сохдой, шивэр алагдаага, говийн алагдаага, элсч савгадаахай зэрэг болно. Энэ мужийн хэмжээнд ямар нэг хэмжээгээр ховордсон амьтанд зэрлэг гахай, татаар бөхөн, хар сүүлтий, цагаан зээр, янгир ямаа, аргаль хонийг оруулав. Дээрх зүйл амьтан нь хүний шууд нөлөө буюу агнуураас болж ховордсон ажээ.

**Ландшафтын онцлог.** Эндэхийн байгалийн ландшафтын бүтэц нь хотгоруудын шинж төрхтэй цөлжүү хээр, өмнөдийн хуурай хээр, заримдаг цөл, элсэн хуримтлалын ландшафт гол суурийг эзэлнэ. Эдгээр ландшафтын тархалтын өвөрмөц онцлог нь ихэнхдээ хөрс, ургамалжилтын онцлогтой уялдан тодорхой эрэмбээр хотгорын бүсчлэл үүсгэдэгт оршино.

**Говийн Алтайн уулсын муж Их, Бага Богдын уулсын тойрог / Г – 5/** нь тус аймгийн өмнөд хэсгийг эзлэх бөгөөд Гурван Богдын гурав дахь нуруу “Арц богд” орчмын нутаг юм. Энэ нуруу нь зүүн талдаа нилээд намссан, харин өмнө зүгтээ эгц, урт налуу байдалтай тогтжээ. Түүний хамгийн өндөр Их баян уул нь 2086 метр үнэмлэхүй өндөртэй байна. Энд Их Богдынхтой адил эрс эгц хажуунууд үгүй байна. Гэхдээ Арц богдын ар хажуу нь нилээд эгц, өвөр хажуу нь маш урт налуу тул жижиг толгодтой, аажим уналттай ташуу тал газар шиг төрх байдалтай байдгаараа онцлог. **Уур амьсгалын хувьд** Говь-Алтайн уулсын



шувтрага, тул өвөр талаараа жилийн аль ч улиралд дулаан, үнэмлэхүй хамгийн их температурын утга 35-38<sup>0</sup>С, дулааны улирлын 50 орчим хоногт агаарын температур +30<sup>0</sup>С-аас их байдаг. Харин ар хэсгээрээ арай сэрүүн.

Энэ мужид жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 100 орчим мм, 80%-ийн хангамжтай жилийн нийлбэр тунадасны хэмжээ 30-60 мм байдаг.

Ургамалжилт нь тэгш талархаг газраа өдлөг хялгана-баглуурт, өдлөг хялгана-ортууз-баглуурт, өдлөг хялгана-таанат, дан өдлөг хялганат цөлөрхөг хээртэй; өмнөд хэсгийн нууруудын чулуурхаг, хайргархаг хормой, хажуугаар улаан бударганат, хойрогт, хотирт, намхан загт цөл, тэгш талархаг газраар нь тэсэг-тогторгонот цөлтэй. Уулс хоорондын хотгор дагасан багахан элсэн манх, довцгоор бор шаваг, бунгийн харгана, сөөгөн шимэрс, хар суль зэрэг элссэг сөөг зонхилон ургах юмуу эсвэл сийрэгхэн заган шугуйтай байна.

Энэ мужид дугираг амтан, загаснаас бусад 4 ангийн 172 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 26.4 % нь оршин амьдардаг

**Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн хойт хэсгийн тойрог / Г – 9 /-ийн хамгийн баруун зах хэсэг нь тус аймгийн зүүн өмнөд хэсгийн нутгийг хамрана. Гадаргын тогтоцын хувьд Дорнод говь нь Алтайн өмнөх болон ар говиос ялгаатай ухаа гүвээт тал ихтэйгээрээ Монголын дорнод талтай төстэй тал говийн бүсийн шинжийг хадгална. Ухаа гүвээт талын дунд энд тэнд ганц нэг буюу хэсэг толгод товойж харагдана. Тэдгээрийн хажуу бэл голдуу налуу мөлгөр боловч хааяа эгц бөгөөд хадархаг хажуутай толгодтой. Зарим толгод оорцог уулын байдалтай ч байна. Тийм уулс ихэвчлэн боржин болон боржингийн төрлийн чулуулгаас тогтсон бүтэцтэй байна.**

Хотгорын үнэмлэхүй өндөр нь 700 – 1000 метр юм. Түүний ёроол нь зарим газар бүрмөсөн нүцгэн , заримдаа заг, бударгана бүхий хужир бүрд болон тойрмуудтай байна. Мөн ургамлаар бэхлэгдсэн элс, бага хэмжээний жижиг толгод болон үлдэгдэл толгойнуудтай хэсэг газар тохиолдоно. Хамгийн нам газруудад нь жижиг нуурууд үзэгдэнэ.

**Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн мужийн Дундад Халхын тэгш өндөрлөгийн тойрог / Т – 1 / нь тус аймгийн нутгийн төв хэсгийн зүүн захаар орших бөгөөд хотгор гүдгэрийн хувьд зөөлөн элэгдсэн хэлбэртэй, өргөн хуурай хөндийтэй өргөн уудам талуудтай, бөөрөнхийдүү толгод ба өргөрөгийн дагуу орших өндөрлөгүүдтэй талархаг газар болно. Эндэхийн хөрс нь нягт наанги шороолог бөгөөд сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг. Нам хотгор газруудад нь зууван хэлбэртэй хужир бүрдүүд орших бөгөөд энд ул хөрсний ус ойрхон байрлах тул гүйхэн бөгөөд бага хэмжээтэй давстай нуурууд болон хужир тойром их тархжээ.**

Харьцангуй өндөр багатай, ялимгүй эвдлэгдсэн ухаа, гүвээ толгодын дотор орчин тойрны газраас 200- 300 метр өндөртэй уулын хэсгүүд болон шилүүд тус тус ялгаран үзэгдэнэ.

## ГУРАВ. АЙМГИЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


### 3.1. Газрын нэгдмэл сан, түүний ашиглалт

Газрын нэгдмэл сангийн 2004 оны тайлангаас үзэхэд аймгийн нийт нутаг дэвсгэр 6289.5 мян.га бөгөөд үүний 5767.8 мян.га буюу 55.1 хувийг хөдөө аж ахуйн газар, 19.0 мян.га буюу 24.8 хувийг хот тосгон бусад суурингийн газар, 9787.1 га буюу 1.1 хувийг зам, шугам сүлжээний газар, 192.3 мян.га буюу 16.6 хувийг ойн сан бүхий газар, 3318.3 га буюу 0.2 хувийг усан бүхий газар, 297.3 мян.га буюу 2.2 хувийг тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна. /хүснэгт 9/

#### Хүснэгт 9. Өвөрхангай аймгийн газрын нэгдмэл сангийн бүтэц

№	Газрын үндсэн ангилал	Талбай	
		Мян.га	Хувь
1	Хөдөө аж ахуйн газар	5767846.9	91.7
2	Хот тосгон, бусад суурины газар	18997.5	0.3
3	Зам, шугам сүлжээний газар	9787.1	0.2
4	Ойн сан бүхий газар	192278.0	3.1
5	Усны сан бүхий газар	3318.3	0.1
6	Тусгай хэрэгцээний газар	297305.0	4.7
	<b>БҮГД</b>	<b>6289532.8</b>	<b>100.0</b>

Диаграмм 4




Нийгмийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн хөгжлийг даган газар ашиглалтын хэлбэр зориулалт тодорхой хэмжээнд өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулав. /Хүснэгт 10 /

## Хүснэгт 10. Өвөрхангай аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт /га/

Д/д	Он	2002	2003	2004	Зөрүү+- 2002- 2003 он	Зөрүү+- 2003- 2004 он
	<b>Газрын ангилал</b>					
1	Нийт нутгийн хэмжээ	6289533	6289533	6289533		0.0
	ХАА-н газар бүгд	5960721.6	5767847	5767846.9	-192874.7	0.0
1	Үүнээс: Бэлчээр	5909070.9	5717002	5716954.7	-192069	-47.2
2	Хадлан	6819.8	5821.8	5821.8	-998	0.0
3	Тариалан	5756.1	6949.5	6949.5	1193.4	0.0
4	Атаржсан газар	38386.7	36981.7	36981.7	-1405	0.0
5	ХАА-н барилга	688.1	1091.9	1139.1	403.8	47.2
	Хот тосгон бусад суурин газар	25735.8	18997.5	18997.5	-6738.3	
6	Үүнээс: Барилгажсан талбай	771.2	791.1	791.1	19.9	0.0
7	Гэр хороолол	1015.4	1127.6	1156.5	112.2	28.9
8	Нийтийн эзэмшил	21066.8	14209.6	14180.7	-6857.2	-28.9
9	Үйлдвэрийн зориулалттай	42.7	57.5	57.5	14.8	0.0
10	Уурхайн зориулалттай нийт	2839.7	2811.7	2811.7	-28	0.0
3	Зам шугам сүлжээний газар	9651.6	9787.1	9787.1	135.5	0.0
	Үүнээс: Эрчим хүчний	1513.0	1761.9	1761.9	248.9	0.0
	Холбооны	1006.3	1006.3	1006.3	0	0.0
	Авто зам	6456.6	6343.2	6343.2	-113.4	0.0
	Агаарын тээвэр	320.0	320.0	320.0	0.0	0.0
	Ус дамжуулах хоолой	3.7	3.7	3.7	0.0	0.0
	Үерийн далан	352.0	352.0	352.0	0.0	0.0
4	Ойн сан бүхий газар	278727.0	192278.0	192278.0	-86449.0	0.0
	Үүнээс: Ой	227038.0	147192.0	147192.0	-79846.0	0.0
	Огтлогдсон ой	3175.0	2800.0	2800.0	-375.0	0.0
	Хамгаалалтын бүс	48514.0	42286.0	42286.0	-6228.0	0.0
5	Усан сан бүхий газар	4922.0	3318.3	3318.3	-1603.7	0.0
	Үүнээс: Гол	3103.0	1524.3	1524.3	-1578.7	0.0
	Нуур	1243.0	1218.0	1218.0	-25.0	0.0
	Булаг шанд	576.0	576.0	576.0	0.0	0.0
6	Тусгай хэрэгцээний газар		297305.0	297305.0	297305.0	0.0
	Үүнээс: Тусгай хамгаалалтай		290628.0	290628.0	290628.0	0.0
	Батлан хамгаалах		6600.0	6600.0	6600.0	0.0
	Боловсрол, туршилт ШУ		77.0	77.0	77.0	0.0
	Нөөц газар	9775.0				
	Үүнээс Эзэмшил ашиглалтанд олгоогүй газар					

	Ашиглахад тохиромжгүй газар	9775.0				
	Бусад газар					

Диаграмм 5



Тайлбар: 1-Бэлчээр, 2-хадлан, 3-тариалан, 4-атаржсан газар, 5- ХАА-н барилга, байгуулалмж, 6-барилгажсан талбай, 7-гэр хороолол, 8-нийтийн эзэмшил, 9-үйлдвэрийн зориулалттай, 10- уурхайн зориулалттай, 11-эрчим хүчний шугамын газар, 12-авто замын газар, 13-ойн сан бүхий газар, 14-огтлогдсон ой бүхий газар, 15-ойн хамгаалалтын бүсийн газар, 16-гол горхи, 17-нуур цөөрөм, 18- тусгай хамгаалалттай газар, 19-батлан хамгаалах газар, 20-боловсрол, ШУ-ны туршилтын талбай

**ХАА-н газарт** гарсан өөрчлөлтийг 2003 онтой харьцуулбал бэлчээр 243720.1 га-аар хасагдсаны 191492.3 га нь тусгай хамгаалалттай газарт, 248.9 га нь шугам, сүлжээний газарт, 25.1 га авто замын газарт, 2.4 гэр хорооллын газарт га, 0.8 га ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газарт, 369.9 га өвөлжөө хаваржааны газарт 28 га уурхайн газарт тус тус шилжжээ. харин 2004 онд бэлчээрийн газар 47.2 га-аар хасагдсан нь ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газарт шилжсэнтэй холбоотой.

Хадлангийн газрын хувьд 2003 онд өмнөх оныхоос 998.0 га-аар хасагдсан нь тусгай хамгаалалттай газрын ангилалд шилжсэн, харин 2004 оны байдлаар хадлангийн газарт өөрчлөлт гараагүй. Тариалангийн газар нь өмнөх онд 5756.1 га байснаа 2003 онд 6949.5 га болж нэмэгдсэн нь 403.9 га газрыг ХАА-н барилга, байгуулалмжийн дэвсгэр газарт, 56 га газрыг ШУ, судалгаа туршилтын талбайд шилжүүлсэн ба 6 га газрыг мөн тусгай хамгаалалттай газрын ангилалд шилжүүлсэн.

Атаршсан 146.1 мянган гаа-гаас 1289.6 га-г эргэлтэнд оруулж, тариалангийн талбайн газрыг нэмэгдүүлсэн нь 2004 онд тус газрын балансад тусгагдаагүй байна.

**Хот суурин газар:** Барилга байгууламжийн дэвсгэр газар өмнөх онд 771.2 га байснаа 2003 оны байдлаар 791.1 га болж өөрчлөгдсөн нь 17 га газрыг цаг уурын ажиглалтын талбайн зориулалтаар тусгай хэрэгцээний газарт, 2 га газрыг нийтийн эзэмшилд, бусад гэсэн ангиллын 880.1 га газрыг нийтийн эдэлбэрт тус

тус шилжүүлж, нийтийн эдэлбэрээс 0,6 га-г барилга, байгууламжид, 14.8 га-г үйлдвэрийн газарт, 82.6 га-г гэр хороололд тус тус шилжүүлсэн байна. Бусад гэсэн ангилалд байсан 7632.8 га газрыг барилга байгууламжийн дэвсгэр болон гэр хороололд шилжүүлж, цэргийн ангийн 6600 га болон 53.7 га-г тусгай хамгаалалттай газар тус тус шилжүүлсэн байна. 2004 онд нийтийн эзэмшлийн 28.9 га-гаар хасагдсан бөгөөд үүний Уянга суманд 1.5 га-г, Богд суманд 8.5 га-г, Арвайхээр суманд 18.9 га газрыг тус тус гэр хорооллын газарт шилжүүлсэн. Харин гэр хорооллын газар 1156.5 га болж нэмэгдсэн.

**Зам шугам сүлжээний газар:** 2003 оны байдлаар 25.1 га бэлчээрийн газрыг авто замын газарт, 138.0 га тусгай хэрэгцээний газарт шилжүүлж, 248.9 га газарт эрчим хүчний агаарын шугам тавьсан. 2004 онд энэ ангиллын газарт өөрчлөлт ороогүй.

**Усны сан бүхий газар:** 2003 онд энэ ангиллын газраас 1604.0 га газрыг тусгай хамгаалттай газарт шилжүүлсэн. 2004 онд усан сан бүхий газар 3318.3 га бөгөөд үүнээс гол мөрний эзлэх газар 1524.3 га, горхи булаг шандын эзлэх газар 576.0 га, нуур цөөрөм, тойрмын эзлэх газар 1218.0 га байгаа нь тухайн онд өөрчлөлт ороогүй болно.

**Ойн сан бүхий газар:** 2003 онд ойн сан бүхий газраас 86449.0 га газрыг тусгай хамгаалалттай газрын ангилалд шилжүүлсэн бол 2004 онд энэ ангиллын газарт өөрчлөлт гараагүй байна. 14002.0 га, үүнээс 13976 га ой, 6 га нь мод үржүүлгийн газар байна.

**Тусгай хэрэгцээний газар:** 2003 оны байдлаар тус ангиллын газарт бэлчээрээс 191492.3 га, хадлангаас 998.0 га, тариалангийн газраас 62.0 га, атаршсан газраас 115 га, барилга байгууламжийн дэвсгэр газраас 17 га, нийтийн эдлбэрээс 1 га, бусад гэсэн ангиллаас 6653.7 га, авто замын газраас 138.0 га, ойн сангийн газраас 86449.0 га, усан сангийн газраас 1604.0 га, нөөц газраас 9775.0 га тус тус шилжсэн бол 2004 онд тус ангиллын газарт ямар нэг хөдөлгөөнд ороогүй байна.

Газар ашиглалтын өнөөгийн бүтэц, аймгийн хөгжлийн цаашдын чиг хандлагаас харвал газрын сангийн ангилалд хөдөө аж ахуйн газар давамгайлсаар байх хандлагатай. Интинсив ашиглалттай газрууд нь Арвайхээр, Хархорин зэрэг төв суурингаас гадна цөөн тооны уурхайн газрууд, зах зээл ойр орших тариалангийн газрууд байх болно.

### 3.2. Газрын харилцааны өнөөгийн байдал.

Нийгмийн харилцааг даган газрын харилцаанд оролцогчдын эрх үүрэг улам бүр нарийсч, иргэн аж ахуйн байгууллага газрыг хууль эрхийн хэмжээнд баталгаатай эзэмшиж ашиглаж эхэлснээс хойш бараг 10 шахам жил боллоо.

Одоогоор тус аймгийн хэмжээнд нийт 1556 иргэний 107.9 га, 13 аж ахуйн нэгж байгууллагын 0.6 га газрын өмчлөх эрх нь баталгаажсаны 107.9 га гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0.6 га нь аж ахуйн зориулалтаар тус тус өмчилж байна.

Харин нийт 13640 иргэн 2630.3 га газрыг эзэмшиж байгаа ба үүний 103 иргэн 468.9 га газрыг тариалангийн зориулалтаар, 5514 иргэн 1104.1 га газрыг ХАА-н барилга байгуулалмжийн дэвсгэр газар буюу голчлон өвөлжөө, хаваржааны зориулалтаар, 8002 иргэн 1041.0 га газрыг гэр хорооллын

зориулалтаар, 21 иргэн 16.3 га газрыг барилга байгуулалмжийн дэвсгэр газрын зориулалтаар тус тус эзэмшиж байгаа бол 96 төрийн байгууллага 6886.9 га газар эзэмшиж байгаагийн 41 байгууллага 61.5 га газрыг барилга байгуулалмжийн дэвсгэр газрын зориулалтаар, 1 иргэн 2.0 га газрыг амралт, рашаан сувиллын зориулалтаар, 31 байгууллага нийтийн эдэлбэрийн буюу цэцэрлэгт хүрээлэн, хог хаягдлын газрын зориулалтаар, 1 байгууллага 6600 га газрыг батлан хамгаалах зориулалтаар, 21 байгууллага 77 га газрыг шинжлэх ухаан, техникийн сорилт туршилт болон цаг уурын ажиглалтын талбайн зориулалтаар тус тус эзэмшиж байна. Газар эзэмшигч 307 аж ахуйн нэгж байгууллага 10832.8 га газрыг эзэмшиж байгаа бөгөөд үүний 13 нь 6536.2 га газрыг тариалангийн зориулалтаар, 3 ААН нь 35.0 га газрыг ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газрын зориулалтаар, 244 ААН нь 711.3 га газрыг хот суурингийн доторхи барилга байгууламжийн дэвсгэр газрын зориулалтаар, 2 ААН 47.6 га газрыг амралт, рашаан, сувиллын зориулалтаар, 2 ААН нь 54.1 га газрыг цэвэрлэх байгуулалмжийн газрын зориулалтаар, 26 ААН 57.5 га газрыг үйлдвэрийн зориулалтаар, 8 ААН 2811.7 га газрыг уурхайн дэвсгэр газрын зориулалтаар, 2 ААН нь 320 га газрыг агаарын тээврийн газрын зориулалтаар, 1 ААН нь 1.5 га газрыг холбооны шугам, түүний станцын дэвсгэр газрын зориулалтаар, 3 ААН нь 302 га газрыг эрчим хүчний шугам, түүний барилга байгуулалмжийн дэвсгэр газрын зориулалтаар, 3 ААН нь 3.5 га газрыг байгалийн цогцолбор газарт тус тус эзэмшиж байна.

Тус аймгийн хэмжээгээр бусдын эзэмшлийн газрыг ашиглагч Монгол улсын иргэн болон гадаадын хуулийн этгээд, харьяалалгүй хүн байхгүй байна.

### 3.3. Газрын үнэлгээ, төлбөр

Газар нь хүний оршин тогтнох орон зайн хэрэгцээнээс гарч эдийн засаг, зах зээлийн утга агуулгатай болж газрын үнэлгээ төлбөрийн систем бүрэлдсэн билээ. Өвөрхангай аймагт хууль ёсны газрын эзэмшигч, ашиглагчдаас 2004 онд 58617.1 мян.төгрөгийг орон нутгийн төсөвт хуримтлуулжээ. /Хүснэгт 11/

**Хүснэгт 11. Газрын төлбөрийн хуримтлал**

Д/д	Газрын ангилал	2003 онд төлсөн төлбөр		2004 онд төлсөн төлбөр	
		мян.төг	хувь	мян.төг	хувь
1	Бэлчээр	5454.4	9.9	6723.9	11.5
2	Хадлан	14	0.0	14	0.0
3	Тариалан	5741.6	10.4	4494.7	7.7
4	ХАА-н барилга байгууламж	6527.2	11.9	6786.7	11.6
5	Хот суурины барилга байгууламжийн дэвсгэр газар	16371.8	29.7	16400.5	28.0
6	ШТС, авто машины зогсоол	1135.5	2.1	1039.5	1.8
7	Гэр хороолол	3457	6.3	5224.9	8.9
8	Уурхайн дэвсгэр газар	13462.4	24.4	15024.9	25.6

9	Тусгай хамгаалалттай газар	960	1.7	960	1.6
10	Аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж буй газар	1948	3.5	1948	3.3
	Нийт дүн	55071.9	100.0	58617.1	100.0

Газрын төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 152-р тогтоолыг үндэслэн тогтоодог бөгөөд сүүлийн жилүүдэд хотын механик өсөлттэй холбоотойгоор газрын эрэлт хэрэгцээ ялангуяа гэр хорооллын хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор төлбөр тогтооход онцгой анхаарч төвлөрлийг сааруулах механизм болгон ашиглавал зохистой.

### 3.4 Газар хамгаалах арга хэмжээ

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт бэлчээрийн газар хамгийн ихээр талхлагдсан бөгөөд зарим нэг газарт уурхайн үйл ажиллагаагаар ухагдаж эвдэрчээ. Ялангуяа Уянга сумын нутагт гар аргаар алт олборлож буй хүмүүсийн нөлөөгөөр нилээд газар ухагдаж дахин нөхөн сэргээлт хийгдэхгүйгээр хаягдаж байна. /Хүснэгт 12 /

#### Хүснэгт 12. Доройтолд орсон газрын хэмжээ /нэгдмэл сангийн ангилал бүрээр/

Д/д	Арга хэмжээ авсан газар	Талбай /га/
1	Тариалангийн газар	7513.2
2	Бэлчээрийн газар	253319.7
3	Хот тосгон бусад суурин газар	761.9
4	Ойн сан бүхий газар	141.0
5	Усан сан бүхий газар	77.9
6	Уурхайн эдэлбэр газар	43.0
	Нийт дүн	261856.7

Тариалангийн газарт олон наст тарих, ойн зурвасаар хамгаалах, төрөл бүрийн бордоогоор бордох, хортон мэрэгчтэй тэмцэх, бэлчээрийн газарт элсний нүүлтээс хамгаалах, даацыг тохируулах, хог хаягдлаас цэвэрлэх, ашиглалтаас чөлөөлж, сэлгэн ашиглах, хот суурин газрын хувьд зүлэгжүүлж мод бут тарих, хамгаалалтын далан суваг босгох, хатуу хучилттай зам тавих, ахуй болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэх, ойн сангийн газарт ойн хортонтой тэмцэх, ойн цэвэрлэгээ хийх, усан сан бүхий газарт усан сангийн орчны газрыг цэвэрлэх, орчны хөрсийг хамгаалах, уурхайн эдэлбэр газарт ухагдсан газрыг дарж булах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Жишээ нь: Баянгол суманд сумын төвийг элсжилтээс хамгаалах зорилгоор 1 км газарт ойн зурвас байгуулсан. Мөн зарим сумдад тогтвортой амьжиргаа болон бэлчээрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд малчдын бүлэг байгуулан бэлчээрийн газрыг хашиж

хамгаалах арга хэмжээ авч байна. Мөн дээрх төслүүдийн хөрөнгөөр бэлчээрт худаг ус гаргах ажлуудыг хийж байгаа.

Тус аймгийн нутаг дэвсгэрийн доройтолд орсон газруудыг нөхөн сэргээх асуудлыг дараах хүснэгтэд заасан дагуу шийдвэрлэх боломжтой юм. /Хүснэгт 13/

**Хүснэгт 13. Доройтолд орсон газруудын нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэр**

Д/д	Нөлөөллийн ангилал	Талбай		Хөрөнгийн эх үүсвэр
		га	хувь	
1	Техногений нөлөөлөлтэй	8089.8	0.13	Эзэмшигч, ашиглагчийн хөрөнгөөр
2	Элсний нүүлттэй	75628.8	1.20	Улсын болон орон нутгийн төсвөөр
3	Их талхлагдсан	349726.8	5.56	Улсын болон орон нутгийн төсвөөр
4	Дунд зэрэг талхлагдсан	1587434.0	25.24	Байгалийн аясаар нөхөн сэргэнэ

Эндээс харахад доройтолд орсон газруудыг эзэмшигч, ашиглагчтай буюу голчлон уурхайн газрыг тухайн эзэмшигч, ашиглагчийн хөрөнгөөр нөхөн сэргээх бол бусад нийтийн эзэмшлийн газруудыг улсын болон орон нутгийн төсвөөр нөхөн сэргээх нь зүйтэй юм.



## ДӨРӨВ. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатуудад нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлохдоо уг төлөвлөлтөнд шаардлагатай нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын хандлага, хэтийн төлөвийг тодорхойлов.

Монгол Улсын газрын хуулийн дагуу газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 12-16 жилийн баримжаатай төлөвлөгддөг бөгөөд энэхүү төлөвлөгөө нь 2005-2020 оныг хамарч байна. Харин төлөвлөлтийн суурь нь 2000-2004 оны дундаж үзүүлэлтэнд суурилагдсан болно.

### Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төлөвлөлтөнд харгалзсан нийгэм-эдийн засгийн нөхцөлүүд

#### 4.1. Хүн ам. Хүн амын төвлөрөл ба суурьшилт

#### ***Хүн ам, нийгмийн талаархи SWOT шинжилгээ***

##### Давуу талууд:

1. Аймгийн хүн ам 108,5 мянга, өрхийн тоо 28,4 мянга бөгөөд 1 өрхөд 3,85 хүн ногдож байна. Хүн амын 42,7 хувь нь хот сууринд, 57,3 хувь хөдөөд амьдарч байгаа бөгөөд малгүй, эсвэл цөөн тооны малтай болсон хөдөөний иргэд ажлын байртай болох, эмнэлэг, боловсролын үйлчилгээ болон зах зээлд ойртох үүднээс аймаг дотроо хот, суурин газар бараадаж, шилжин суурьшиж амьдарч байна. Цаашид ч хот суурингийн хүн ам хөдөөгийнгийн хүн амаас илүү хурдацтай өсөх хандлагатай байна.

	Суурьшлын байдал	хэмжих нэгж	2004 он	Хэрэгжилтийн үе шатууд		
				1-р үе	2-р үе	3-р үе
1	Хот суурингийн хүн ам	м.хүн	46366	68500	73111	81106
2	Хөдөөгийн хүн ам	м.хүн	62133	82004	89811	100522
3	Нийт хүн ам	м.хүн	108489	150504	162922	181628

2. 1 кв.км нутагт 1,8 хүн ногдож байгаа нь улсын дунджаас бага зэрэг дээгүүр байна. Аймгийн нутаг дэвсгэрт хүн амын нягтшил харилцан адилгүй байна. Нягтшил хамгийн их Хархорин, Хужирт суманд 1 кв.км-т 5,7-4,2 хүн ногдож байхад нягтшил хамгийн бага Гучин –Ус, Богд, Төгрөг, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан суманд 0,5-0,8 хүн ногдож байна. Төв зам, дэд бүтэц болон зах зээлээс хол шалтгааны улмаас Гучин –Ус, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан сумдын иргэд бага байдаг байхад орон нутагт алт олборлох, дэд бүтэц, үйлдвэрлэл, аялал жуулчлал илүү хөгжсөн шалтгаанаас Уянга, Хужирт, Хархорины хүн ам их байдаг байна. Цаашдаа ч энэ сумдын хөгжлөөс шалтгаалан хүн амын нягтшил илүү байх болно.

3. Нийт хүн амын 61,2 хувь нь хөдөлмөрийн насны, 32,6 хувь нь 15 хүртэлх насны, 6,2 хувь нь 60-аас дээш насны хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин жил тутам 1 хувиар нэмэгдэж байгаа нь цаашид нийгмийн хөгжилд эерэгээр нөлөөлөх болно.

4. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын бага, дунд 28 сургуульд 830 багш ажиллаж, 687 бүлэгт 23384 сурагч суралцаж байна.

		хэмж их нэгж	2004 он	Хэрэгжилтийн үе шатууд		
				1-р үе	2-р үе	3-р үе
1	Сурагчдын тоо	м.хүн	23,4	28,7	33,8	39,8
2	Сургуулийн тоо	шир	28	34	40	47
3	Нэмэгдэх сурагчид	м.хүн		5,3	10,4	16,4
4	Хүүхдийн тоо	м.хүн	3,2	3,6	5,1	7,2
5	Цэцэрлэгийн тоо	шир	29	32	46	65
6	Нэмэгдэх хүүхэд	м.хүн		0,4	1,9	4,0

5. Аймгийн хэмжээнд Хангайн бүсийн оношлогоо, эмчилгээний төв-1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-1, сумын эмнэлэг-16, их эмчийн салбар-1, бага эмчийн салбар-62, эмийн сан-26 ажиллаж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ салбарт 421 ор, 161 их эмч, 466 эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна. Эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээ бусад аймгуудын дундаж үзүүлэлтээс харьцангуй илүү түвшинд байна.

#### Сул талууд:

1. Аймгийн хүн ам зарим жилүүдэд өсч, зарим жилүүдэд буурдаг ба энхүү өсөлт, бууралтанд хүн амын механик бууралт буюу шилжин явагсдын тоо голлон нөлөөлжээ. Хүн амын ердийн өсөлт дундажаар 1,7 хувь буюу жилд 1923 хүн байна. Гэтэл шилжин явагсад шилжин ирэгсдээс жилд дундажаар 2225 илүү байгаа нь хүн амын тоог жилд дундажаар 0,3 хувь буюу 334 хүнээр буурахад хүргэж байна.

2. Шилжин явагсдын 5-6 хувь нь Орхон, Төв, Булган аймаг руу, 30 орчим хувь нь аймаг дотроо шилждэг байхад 64 хувь нь Улаанбаатар хот руу шилжжээ. Шилжин явагсдын 66,7 хувь нь хөдөлмөрийн насныхан бөгөөд мэргэжил боловсрол эзэмшсэн, ажлын туршлагатай болсон хүмүүс нилээдгүй байдаг.

3. Хөдөлмөрийн насны хүн амын 72,0 хувь буюу 45,5 мян.хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлээгүй 9,5 мян.хүн байгаагийн 2,3 мян.хүн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн байна. Ажилгүйчүүдийн 78,3 хувь нь ерөнхий боловсролын сургууль төгсөөд анх удаа ажил эрж байгаа хүмүүс байгаа нь мэргэжлийн сургалтууд явуулах хэрэгтэйг харуулж байна.

	хэмжих нэгж	2004 он	Хэрэгжилтийн үе шатууд		
			1-р үе	2-р үе	3-р үе
Хөдөлмөрийн нөөц	м.хүн	63,3	71,2	78,3	86,0

Э/З-н идэвхитэй хүн ам	м.хүн	47,8	49,1	50,1	51,2
Нийт ажиллагсад	м.хүн	45,6	47,0	48,2	49,4
Бүртгэлтэй ажилгүй	м.хүн	2,3	2,4	2,5	2,6

4. Сургуулийн 1 бүлэгт дунджаар 34 сурагч ногдож байхад Арвайхээр, Уянга сумын сургуульд 38 ногдож байна. Энэ нь 1 бүлэгт суралцах тогтоосон сурагчийн тооноос хэтэрч байгаа бөгөөд цаашид хүн амын нягтшил ихтэй хот сууринд сургуулийн барилга барих шаардлагатайг харуулж байна.

5. Сургуулийн дотуур байранд 2932 хүүхэд амьдарч байгаа нь нийт сурагчдын 12,5 хувийг эзэлж байна.

Боломж:ууд:

1. Эртний нийслэл Хархорин хотыг жишиг хот болгосон, аялал жуулчлалыг бүсчилэн байдлаар хөгжүүлснээр орон нутгийн дэд бүтэц сайжирч, ажлын байр шинээр олноор бий болно.

2. Нийгэм-эдийн засгийн босоо болон хэвтээ тэнхлэгүүд эрчимтэй хөгжснөөр хүн амын механик бууралт буюу шилжих явах хөдөлгөөн багасч, бусад хот болон аймаг сумдаас шилжин ирэгсдийн тоо нэмэгдэж, хот суурингийн хүн амын тоо өсөх хандлагатай.

Эрсдэлтэй талууд:

1. Ган зудаас малгүй болж орлогогүй болсон, төв замаас алслагдсан малчин иргэд хот суурин бараадах болсноор, эсвэл Монгол Улсын засаг захиргааны шинэчлэлт хэрэгжсэн тохиолдолд, мөн түүнчлэн аймгийн төвд ойролцоохи сумын иргэдийн олонхи нь аймгийн төв рүүгээ татагдан суурьшин тухайн сумын /Тарагт сум/ үүрэг тодорхойгүй болсноор зарим сумдыг татан буулгахад хүргэж болзошгүй байна.

2. Байгаль орчны доройтол, зах зээлээс алслагдмал байдал, ажлын байрны хомсдол, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ зохих түвшинт хүрэхгүй байгаа нь хүн амын амьжиргаа, суурьшилтанд сөргөөр нөлөөлнө.

**Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага**

*Нэгдүгээр үе шат /2005-2010 он/*

1. Аймгийн хүн ам жилд дунджаар 1,7-2,0 хувиар өснө. Хот суурингуудын дэд бүтэц, аялал жуулчлал эрчимтэй хөгжснөөр шилжин ирж суурьшигчдын тоо нэмэгдэнэ.

2. Тогтвортой ажлын байр 3000-ийг шинээр бий болгох замаар ажилгүйдлийг бууруулна. Орон нутгийн хөгжилд чиглэсэн, хөдөлмөр их шаарддаг, нийтийг хамарсан ажлаар 3000 түр ажлын байрыг бий болгоно.

3. Хархорин суманд хөдөлмөр сургалтын төвийг ашиглалтанд оруулж, мэргэжлийн болон давтан сургалтыг орон нутгийн хөгжил, үйлдвэрлэл үйлчилгээний онцлог, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр явуулж 1600 ажилгүй иргэдийг хамруулж 60 хувийг ажлын байртай болгоно.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэл явуулах ажлын байрыг Арвайхээрт шинээр бий болгож ажиллуулна.
5. Арвайхээр суманд 640, Хархорин суманд 240-с доошгүй суудалтай хичээлийн байр шинээр барина. Сургуулиуд болон дотуур байрны өргөтгөлийг хийнэ.
6. Арвайхээр хотын ШУТИС-ийн Технологийн сургууль, Хархорины төрийн өмчийн коллеж, Эрдэнэт хотын ШУТИС-ийн Техникийн сургууль хоршиж бүсийн их, дээд сургуулийн цогцолбор болно.
7. Эрүүл мэндийн үйлчилгээг нийтэд ойртуулахын тулд зарим сумын болон ерхийн эмнэлгийн барилгыг шинээр барина.
8. Арвайхээр хотод спортын цогцолбор барьж ашиглалтанд оруулна.

#### Хоёрдугаар үе шат /2011-2015 он/

1. Хархорин хотын барилгажилт, хотжилт явагдаж эхэлснээр хот суурингийн хүн ам эрс нэмэгдэнэ.
2. Хангайн бүсийн байгалийн баялаг, түүхий эдийн нөөц, амьдралын туршлага, оюуны чадавхийг зах зээлд бүрэн ашиглах, орчин үеийн технологийг хөгжүүлэхтэй холбогдсон их, дээд сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага бий болгоно.
3. Хувийн хэвшлийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын тоо, үйлчилгээний хүрээ нэмэгдэнэ.

#### Гуравдугаар үе шат /2016-2020/

1. Хангайн бүсийн тулгуур төв, Жишиг хот - Хархорин хот болон Аялал жуулчлалын бүсүүд хөгжснээр аймгийн нийт хүн ам өсч, дэд бүтэц сайжирч, үйлдвэрлэл үйлчилгээ өргөжин тэлнэ.
2. Ажлын байр олноор бий болсноор ажилгүйдэл багасч, ядуурал буурна.

#### *Ажлын байрны тоо, хэтийн төлөв*

	хэмжих нэгж	2004 он	Хэрэгжилтийн үе шатууд		
			1-р үе	2-р үе	3-р үе
Аймгийн хэмжээнд	м.хүн	38102	38864	39641	40434
үйлдвэрлэлийн салбарт	м.хүн	1940	1978.8	2018.4	2058.7
үйлчилгээний салбарт	м.хүн	2293.5	2339.37	2386.2	2433.9
ХАА-н салбарт	м.хүн	33868	34545.4	35236	35941

3. Хүн амын амьдрах нөхцлийг сайжруулахад чиглэсэн нийгмийн үйлчилгээний хүрээ өргөснө.

4. Зам харилцаа, дэд бүтэц хөгжсөн, зах зээлд ойрхон байх болсноор аймгийн нийт хүн амын бодит орлого нэмэгдэнэ.

#### **4.2. Дэд бүтэц, хот суурингийн хөгжил**

##### *Дэд бүтэц, хот суурингийн талаархи SWOT шинжилгээ*

##### Давуу талууд:

1. Өвөрхангай аймаг нь газарзүйн байршлын хувьд Монгол орны төв хэсэгт орших бөгөөд өөрийн нутаг дээгүүр дайрсан хатуу хучилттай автозамаар баруун аймгуудыг төвийн бүстэй холбодог. Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн зам барих засах, гүүр барих ажил хийгдэж байна.

2. Арвайхээр хот болон Хангайн бүсийн тулгуур төв болох Хархорин хот Булганы 110 кв-ын цахилгаан дамжуулах шугмаар хангагдаж байна. Өвөрхангай аймгийн 15 сум төвийн эрчим хүчний системд холбогдсон, одоо Гучин-Ус сумыг холбох ажил хийгдэж байна. Мөн Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Гучин-Ус, Баян-Өндөр, Хайрхандулаан сумдын дизелийн цахилгаан станц улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдсэн.

2. Хөдөө орон нутгийн нийт айл өрхийн 7,49 хувь буюу 13,4 мянган айл өрх нар салхины болон цахилгаан эрчим хүчний бусад эх үүсвэрээр хангагддаг болсон байхад Өвөрхангай аймгийн малчин өрхүүдийн 16 хувь нь нар, салхины эрчим хүч ашиглах цахилгаан үүсвэртэй болсон байна.

3. Арвайхээр хотоос Баянхонгор хот хүртэл 220 км аналог радио релейний шугам, Булганы Дашинчилэн сумаас Арвайхээр хот хүртэл 230 км тоон релейний шугам ашиглагдаж байна. Хужирт сум, Хархорин хот Мобиком-ын сүлжээнд холбогдсон. Хөдөөгийн холбоонд сансарын холбоо болон радио холбоо, утсан болон утасгүй холбоо зэрэг шинэ техник технологийг нэвтрүүлэх ажил хийгдэж байна.

4. Нисэх онгоц буух шороон зурвастай. Арвайхээр, Хархорин хотууд болон Хужирт рашаан сувиллын газар нь агаарын харилцааны сүлжээнд хамрагддаг.

##### Сул талууд:

1. Алслагдсан сумуудын зам харилцаа, дэд бүтцийн хөгжил нь аймгийн дундаж түвшингээс хоцорч байдаг.

2. Урьд өмнө баригдсан барилгуудын ашиглалтын хугацаа дуусч байгаа болон хуучирч муудснаас болж сүүлийн 5-6 жилд барилгын их засварын ажил хийж байгаагаас биш, шинээр барилга байшин бараг баригдсангүй.

Боломж:ууд:

1. 2004 онд 8580 ширхэг мод бут суулгаж, 31543 кв.м талбайг зүлэгжүүлсэн нь цаашид энэ чиглэлээр ажил өрнүүлж хотыг хотын өнгө үзэмжийг сайжруулах, элсжилт цөлжилтийг бууруулах боломжтойг харуулж байна.

Эрсдэлтэй талууд:

1. Олон жилийн дараалсан ган, элсжилт цөлжилт, байгальтай зүй зохисгүй харьцсан /алтны уурхайн ажиллагаа г.м/ зэргээс шалтгаалан гол горхи, цөөрөм ширгэснээс усны асуудал гарч байна.

**Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага**

**Нэгдүгээр үе шат /2005-2010 он/**

1. Дулааны цахилгаан станцыг Арвайхээр хотод барьж, 220 кВ-ын шугамыг Арвайхээрээс Баянтээг, Баянтээгээс Баянхонгор аймаг руу татна.

2. Баянтээгээс Баруунбаян-Улаан, Богд сумдыг төвийн эрчим хүчний сүлжээнд холбох боломжтой.

3. Хархорин-Хөшөө Цайдамын хооронд 47 км, Хархорин-Хар балгасын хооронд 30 км, Хархорин-Хужиртын хооронд 55 км зам засна. Орхон болон бусад жижиг гол дээгүүр гүүр барина.

4. Өвөрхангай аймагт 2 хот /Арвайхээр, Хархорин/, 2 хот маягийн суурин /Дөлгөөн-Өвдөгхудаг, Баянтээг/ хөдөөгийн суурин 17, нийт 21 төв суурин аймгийн нутагшилтын тогтолцоо байсныг өөрчилж,

**Хархорин** төвтэй /Бат-Өлзий, Хужирт/,

**Арвайхээр** төвтэй /Дөлгөөн-Өвдөгхудаг, Уянга, Тарагт-Нэгдэл дундын амралт, Хайрхандулаан/,

**Есөнзүйл** төвтэй /Өлзийт, Бүрд, Баян-Өндөр/

**Баянгол** төвтэй /Сант, Төгрөг/

**Гучин-Ус** төвтэй /Богд/,

**Баянтээг** төвтэй /Нарийнтээл, Баруунбаян-Улаан/ сумдыг хамарсан 6 бүлэг суурингийн тогтолцоог бий болгоно. /Зураг №5/

**Хоёрдугаар үе шат /2011-2015 он/**

1. Орхон гол дээр 100 мвт-ын УЦС барихаар төлөвлөж байна.

2. Хархорин хотыг жишиг хот хөгжих үндэс болох гол гол магистраль замууд болон дэд бүтэцийн сүлжээ бий болж, барилгажилт явагдана.

**Гуравдугаар үе шат /2016-2020/**

1. Хангайн бүсэд нийт 922 км төмөр зам баригдахаар төлөвлөгдөж байгаагаас 570 гаруй км зам нь Өвөрхангай аймгийн нутгаар дайрахаар тусгагдсан.

Д/д	Төмөр замын чиглэл	Нийт төмөр замын урт /км/	Өвөрхангай аймгийн нутгийг дайрсан төмөр замын урт /км/
<b>Хэвтээ тэнхлэгт</b>			
1	Сайхан-Овоогоос Баянтээг	192,0	172,0
2	Баянтээг-Баянхонгор	105,0	55,0
<b>Босоо тэнхлэгт</b>			
3	Баянтээг –Гурвантэс	315,0	225,0

2. Хархоринд Хөгшин Орхоны хөндийд Олон улсын ачаа тээврийн нисэх онгоцны буудал барина.

3. Хот суурингийн газрын хэмжээ нэмэгдэнэ.

#### **4.3. Үйлдвэржилт, эдийн засгийн хөгжил**

##### **Үйлдвэржилт, эдийн засгийн талаархи SWOT шинжилгээ**

###### Давуу талууд:

1. Аймгийн хэмжээнд 376 аж ахуйн нэгж бүртгэлтэй ажиллаж байгаагийн ОНӨААҮГ-3, ТӨҮГ-4, ХК-18, ХХК-182, нөхөрлөл-71, хоршоо-98 байгаа нь хувийн хэвшлийнх нийт байгууллагуудын 93,3 хувийг эзэлж байна. Цаашид хувийн хэвшлийнхнийг дэмжиж ажиллах боломжтой.

2. Өвөрхангай аймгийн нутагт хийгдсэн геологийн судалгааны үр дүнд өнөөгийн байдлаар ашигт малтмалын 33 төрлийн 180 гаруй орд, илрэл байгаагийн дөнгөж 20 орчим хувьд нь эрэл хайгуулын ажил хийж нөөцийг нь үнэлсэн байна.Цөөн тооны алтны шороон орд, тухайлбал, Өлт, Хонгилт, Хуурай сайр зэрэг ордуудад олборлолт хийж хийж байгаа ба зарим барилгын материалын ордуудыг орон нутгийн чанартай өчүүхэн бага хэмжээгээр ашиглаж байна.

###### Сул талууд:

1. Төвлөрсөн эдийн засгийн харилцааны үеэс жилдээ 16,2 мян.тн гурил, 13,2 мян.тн хивэг үйлдвэрлэж байсан гурлын үйлдвэр, 412,0 мян.л спирт нэрж байсан спиртын үйлдвэр, 6680,0 мян.тоосго цохиж байсан тоосгоны үйлдвэр, мөн хэвлэлийн үйлдвэр санхүүгийн болон эргэлтийн хөрөнгө дутагдсан, зах зээлд өрсөлдөх чадвар сул байгаа зэргээс зогсонги байдалтай байна.

2. Малын гаралтай түүхий эд боловсруулах болон нэхмэл, сүлжмэлийн зэрэг үйлдвэрлэлийн салбар үндсэндээ байхгүй байна.

###### Боломж:ууд:

1. Өвөрхангай аймгийн хэмжээнд жилд дунджаар үйлдвэрлэлийн хэрэгцээнд 300 шоо метр, ахуйн хэрэгцээнд 1000 шоо метр, түлээнд 20000 шоо метр мод бэлтгэж байгаа нь мод, модон эдлэлийн үйлдвэрлэл хөгжих бололцоотойг илтгэж байна.

2. Аймгийн нутаг дэвсгэрийн 1209,8 мян.га талбайд гадаадын 8 улс орны аж ахуйн нэгж, иргэдэд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 35 лицензи олгогдсон байгаа нь цаашид уул уурхайн салбарыг аймгийн хэмжээнд хөгжүүлэхэд гадаад орны хөрөнгө оруулалтыг татан оролцуулах боломжтойг харуулж байна.

3. Орон нутгийн нөөц бололцоонд түшиглэн барилгын материал болон барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой.

Эрсдэлтэй талууд:

1. Байгаль экологид халтай үйлдвэрлэл явуулснаас болж гол горхи ширгэж алга болох, цөлжилт, хуурайшилт үүсэх, эргээд буцаад хүн амын амьдрах, ажиллах орчинд сөргөөр нөлөөлж байна.

**Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага**

**Нэгдүгээр үе шат /2005-2010 он/**

1. ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэнэ.
2. “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг сум бүрт өрнүүлж чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий “брэнд” бүтээгдэхүүнийг шинээр бий болгож дотоод гадаадын зах зээлд гаргана.
3. Аймгийн нутаг дэвсгэрийг Орхоны хөндийн бүс нутаг, Арвайхээр-Найман нуурын бүс нутаг, баруун болон говийн бүс нутаг гэсэн 4 аялал жуулчлалын гол бүс нутагт хуваан, гадаад болон дотоод жуулчдад зориулсан 12 томоохон маршрут зохион байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Хужирт, Могойт, Цэнхэрийн халуун рашааныг түшиглүүлэн рашаан сувиллын цогцолбор байгуулна.
4. Мод, модон эдлэлийн уламжлалт үйлдвэрлэлээ хөгжүүлэхийн зэрэгцээгээр мод боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, хаягдалгүй технологи нэвтрүүлэх, аялал жуулчлалын зориулалттай бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
5. Хүн ам харьцангуй төвлөрсөн, цаг уурын таатай нөхцөлтэй, аялал жуулчлалын өргөн боломжтой аймгийн хувьд дотоод хэрэгцээгээ хангах, бусад бүс нутагт борлуулах болон экспортын зориулалттайгаар, уламжлалт өвөрмөц технологээр хийгдсэн, байгалийн цэвэр бүтээгдэхүүн - мах, сүү, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
6. Арвайхээр хотод төмөр бетон эдлэхүүний үйлдвэр, Өвдөгхудагт ханын материалын үйлдвэрийг сэргээн ажиллуулна.

**Хоёрдугаар үе шат /2011-2015 он/**

1. ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 10 хувьд тогтвортой хадгална.



2. Хангайн бүсийн хэмжээний түлш, галд тэсвэртэй материал, цемент, өнгөт эрдэнийн чулуу, барилгын ханын болон өнгөлгөөний материалын түүхий эдийн хэрэгцээг бүрэн цаашилбал, улсын хэрэгцээний зохих хэсгийг хангах нөхцлийг бүрдүүлнэ.

### Гуравдугаар үе шат /2016-2020/

1. 43,2 сая тн нөөцтэй нүүрсний 2 орд, 40,3 сая тн нөөцтэй шатдаг занарын 1 орд, 1467,5 мян.тн нөөцтэй битумын 1 орд уурхайг түлш болон бусад чиглэлээр ашиглана.

2. 1389,7 мян.куб.м нөөцтэй элсний 2 орд, 3092,4 мян.куб.м нөөцтэй барилгын чулууны 4 орд, 2011,0 мян.куб.м нөөцтэй элс-хайрганы 1 орд, 5323,2 мян.куб.м нөөцтэй өнгөлгөөний чулууны 1 орд, 244,7 мян.куб.м шохойн чулууны 2 орд, 11298,1 мян.куб.м нөөцтэй шаврын 4 ордыг барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр ашиглана.

3. Янз бүрийн нөөцтэй алт, зэс, ховор металл, эрдэнийн чулууны зэрэг ордуудыг олборлохдоо тэргүүний дэвшилтэт, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхгүй техник технологи ашиглана.

#### 4.4. ХАА-н үйлдвэрлэл, түүний эрчимжилт

#### МАА-н талаархи SWOT шинжилгээ:

##### Давуу талууд:

1. Монгол улсын 21 аймгийн дотор Өвөрхангай аймаг малынхаа тоогоор жил бүр эхний 3 байрын аль нэгэнд байнга орж байдаг.

Өвөрхангай аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбар, түүний дотор бэлчээрийн мал аж ахуй зонхилох хувийн жин эзэлдэг.

#### Өвөрхангай аймгийн хүн ам, малын тоо, МАА-н түүхий эдийн үйлдвэрлэлийн нөөц

д/д	Үзүүлэлтүүд	2005 он	Хэрэгжүүлэх үе шатуудаар			
			1-р үе	2-р үе	3-р үе	
1	Хүн ам	108489	150504	162922	181628	
2	малын дундаж уур /тоо толгой/ кг	Тэмээ	13100	13000	12000	11000
3		Адуу	136600	130500	125000	122000
4		Үхэр	99600	100500	95500	90500
5		Хонь	1060100	1000150	950000	900000
6		Ямаа	992200	950000	900000	850000
7		Бүгд /хонин толгой/	3572200	3436600	3268000	3140700
8		ноолуур	232462	251478	255269	259117
9	хонины ноос	1371642	1320698	1268657	1218666	

10	арьс шир түүхий эд, кг	тэмээний ноос	95115	72794	59293	48295
11		хялгас, хөөвөр	86652	77467	72044	67107
12		хонины арьс	176485	150560	144627	138928
13		ямааны арьс	124222	134383	136409	138466
14		үхрийн шир	18581	15466	13692	12122
15		адууны шир	13252	12484	11992	11520
16		тэмээний шир	1054	806	657	535

Тайлбар: Ямааны ноолуурыг 320 гр, хонины ноосыг 1.5 кг, тэмээний ноосыг 6.5 кг, бодын хөөвөр, хялгасыг дунджаар 350гр-аар тооцов. Бод болон богийн арьс, ширний тоог төрөл бүрийн малын заазлалтын улсын дундаж хувийг үндэслэн тооцов.

3. Сумдын зах зээлд нийлүүлэх гол нэр төрлийн бүтээгдэхүүн, түүхий эдийн үндсэн нөөц нь сумдын малын төрөл, тэдгээрийн байгаль, цаг агаарын нөхцөлд зохицон байршсан байдлаас хамаарч ялгаатай байдаг. Өвөрхангай аймгийн Баянгол, Сант Баян-Өндөр, Хужирт, Богд, Бүрд, Есэнзүйл, Уянга зэрэг сумдад тус аймгийн зонхилох хэсэг байршсан тул эдгээр төрлийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд их хэмжээгээр нийлүүлэх боломжтой.

4. Ямааны ноолуур, тэмээний ноосны нийлүүлэлтийн зонхилох хувийг тус аймгийн говийн бүсийн сумд Богд, Баянгол, Сант, Нарийнтээл сумд эзэлж байхад хонины ноос болон бодын хөөвөр, хялгасны зах зээл дэх нийлүүлэлтийн нөөцийн байршил нийт сумдад жигд тархалттай байна.

5. Өвөрхангай аймаг нь ойт хээр, хээр, говийн гурван бүсэд оршдог учраас мал аж ахуй эрхлэх боломжийг түүнд тохируулах боломжтой.

#### Өвөрхангай аймгийн мах, сүү үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Д/д		2004 он	Хэрэгжүүлэх үе шатууд			
			1-р үе	2-р үе	3-р үе	
1	хнүсэнд хэрэглэх малын тоо толгой	Тэмээ	1610	1232	1004	817
2		Адуу	13136	12375	11887	11419
3		Үхэр	20637	17168	15199	13456
4		Хонь	247217	238036	228656	219646
5		Ямаа	201375	217848	221132	224466
6		Бүгд	483975	486660	477879	469804
7	нийлүүлэх махны хэмжээ, тн	Тэмээ	364	279	227	185
8		Адуу	1808	1705	1637	1573
9		Үхэр	3431	2855	2528	2238
10		Хонь	7180	6909	6637	6375
11		Ямаа	4623	4994	5069	5146
12		Бүгд	17407	16742	16099	15517
13	000-20	ингэ	3829	2930	2387	1944

14	НИЙЛҮҮЛЭХ СҮҮНИЙ ХЭМЖЭЭ, МЯН.Л	ГҮҮ	33538	31595	30350	29154
15		ҮНЭЭ	30506	25379	22468	19890
16		ЭМ ХОГЬ	352781	339679	326295	313437
17		ЭМ ЯМАА	306672	331759	336760	341837
18		БҮГД	727326	731342	718259	706263
19		ИНГЭ	357	273	223	181
20		ГҮҮ	6708	6319	6070	5831
21		ҮНЭЭ	10677	8882	7864	6962
22		ЭМ ХОГЬ	1411	1359	1305	1254
23		ЭМ ЯМАА	1533	1658	1683	1709
24	БҮГД	20383	18492	17145	15936	

Тайлбар: Амьдын жин: тэмээ-450, адуу-250, үхэр-280, хонь-45, ямаа-35 кг, Нядалгааны гарц: тэмээ-50.3, адуу-51.9, үхэр-52, хонь-47.8, ямаа-43%-аар тус тус тооцов.

6. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг нэг талаас эрчимжсэн аж ахуй эрхлэх замаар, нөгөө талаас сүрэгт эзлэх хээлтэгчийн хувийн жинг нэмэгдүүлэх замаар хангана.

Малын төрөл	2005 он	1-р үе шат	2-р үе шат	3-р үе шат
Бүгд	927300	943900	966200	988000
Ингэ	3700	3800	3900	4000
Гүү	36800	37500	38600	39000
Үнээ	36900	37600	38700	40000
Эм хонь	441900	450000	465000	480000
Эм ямаа	408000	415000	420000	425000

Сул талууд:

1. Аймгийн нийт малын тоо толгойн өсөлт, бууралтын сүүлийн 15 жилийн статистик мэдээг авч үзэхэд жилд дунджаар тэмээ 4,9%, адуу 1,1%, үхэр 2,9%, хонь 0,7%-аар байнга буурч байхад зөвхөн ямаа 6,6%-аар өсчээв Энэ нь зах зээлийн эрэлттэй холбоотой боловч сүргийн бүтцийн оновчтой харьцаанд сөргөөр нөлөөлөх талтай.

2. Байгаль, цаг агаарын тааламжгүй үзэгдлийн давтамжаас болж мал сүрэг ихээр хорогддог. Араатан амьтан болон малын хулгай зэрэг арчлагаа хамгаалалттай холбоотой малчин хүний үйл ажиллагаанаас болж цөөнгүй хорогддог.

3. Сүү махны өндөр ашиг шимт, цэвэр үүлдэр, эрлийз, нйтгийн шилмэл омгийн малын олдоц ховор байдаг.

Боломж:ууд:

1. 1989 онд 14,0 мянган шувуу тахиатай байснаа бараг шувуугүй болж байгаад сүүлийн үед 6 суманд 683 тахиа, 38 галуутай болж шувуу үржүүлэх сонирхол иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд идэвхижсэн.

2. 1989 онд 6,0 гахайтай байснаа огт гахайгүй болсон ба сүүлийн жилүүдэд бага зэрэг өсч 45 гахайтай болсон ба энэ сонирхол нэмэгдэж байгаа.

3. Өндөр үр шимтэй сарлаг, хайнагийн аж ахуйг бие даан хөгжүүлэх бүрэн боломжтой.

Эрсдэлтэй талууд:

1. Мал сүргийн доторхи сүргийн бүтцийн зохистой харьцаа алдагдсан.

Олон жил дараалан зуд, ган зэрэг байгалийн гамшиг тохиолдоход маш олон тоогоор сүйрч үрэгддэг.

Малын бэлчээрийн ургац муудсан, худаг усны хүрэлцээ багассан.

**Газар тариалангийн талаархи SWOT шинжилгээ:**

Давуу талууд:

1. Өвөрхангай аймаг нь нийтдээ 6289,5 мянган га нутагтай бөгөөд үүний 91,7 хувь буюу 5767,8 мянган га нь ХАА-н эдэлбэр газар байдаг. ХАА-н эдэлбэр газрын бүтцийг авч үзэхэд 99,1 хувийг бэлчээр, 0,1 хувийг хадлангийн талбай, 0,12 хувь нь тариаланд тохиромжтой эдэлбэр газар эзэлж байна.

2. Сүүлийн жилүүдэд газар тариалан эрхлэх талбайн хэмжээ нэмэгдэж байна.

**Өвөрхангай аймгийн газар тариалангийн байдал**

Д/д	Он	2001 он	2002 он	2003 он	2004 он	Дундаж	
1	Нийт тариалсан талбай	2772,8	3512,2	2343,6	4020,8	3162,4	
2	үүнээс	үр тариа, га	2510,0	3258,6	2100	3639,0	2876,9
3		Буудай	2454,0	3255,0			2854,5
4		Төмс	177,8	168,1	165,3	201,2	178,1
5		Хүнсний ногоо	69,5	83	78,3	93,5	81,1
6		Тэжээлийн ургамал	15,5	2,5		87,1	35,0
7		Хураасан ургац, үр тариа /тн/	1379,1	775,9	3203,0	1331,3	1672,3
8	үүнээс	Буудай	1379,1	772,0			1075,6
9		Төмс, тн	1224,1	952,2	1513,6	1766,2	1364,0
10		Хүнсний ногоо, тн	532,1	426,3	734	883,5	644,0
11		Тэжээлийн ургамал		10,5		194,5	102,5
12		Гар тэжээл, тн					
13		Байгалийн хадлан, мян.тн	17,7	13,0	22,4	20,3	18,4
14	1 га-аас хураасан үр тариа, цн	5,5	4,0	1,5	0,4	2,9	
15	Буудай	5,6	2,4			4,0	
16	Төмс	68,8	58,3	94,6	87,8	77,4	

3. Төмсний 79,3 га, хүнсний ногооны 36,8 га, малын тэжээлийн 25,1 га усалгаатай талбайгаас 781,0 тн төмс, 404,1 тн хүнсний ногоо, 28,0 тн малын тэжээл хураан

авсан. 1 га усалгаатай талбайгаас дунджаар 9,75 тн төмс, 10,98 тн хүнсний ногоо, 1,16 тн малын тэжээл хурааж авсан нь цаашид усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

4. Өөрсдийн хэрэгцээнээс илүү гарсан 1065,0 тн үр тариа, 690,6 тн төмс, 487,0 тн хүнсний ногоог зах зээлд нийлүүлж борлуулсан байна.

Сул талууд:

1. Мал хувьчлагдсанаас хойш малын тэжээлийн ургамал тариалах талбай эрс багассан. 1989 онд тариалсан нийт талбайн 30,4 хувь буюу 8996,7 га-д нь малын тэжээл тариалж байсан бол 2004 онд 1,1 хувь буюу 35,0 га-д тариалжээ.

2. Газар тариалангийн үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн аж ахуй одоо бараг байхгүй. Газар тариалангийн чиглэлийн байгууллагуудын ихэнхи нь төмс, хүнсний ногооны тариаланг эрхлэж байна.

3. Хуучин байсан усжуулалтын систем хуучирч муудсан.

Боломж:ууд:

1. Нийтдээ 43931,2 га талбайд тариалан эрхлэж боломжтойгоос 36981.7га (84,2 %) нь атаршсан учраас зөвхөн 6949,5 га (15,8 %) талбайд тариалж байна. Атаршсан газрын боломжтойг дахин ашиглах, нөхөн сэргээснээр тариалангийн талбайг нэмэгдүүлэх боломжтой.

2. 364 ш зуны хүлэмжийн 20,2 мян.кв.м талбайгаас 43,0 тн далд хөрсний нарийн ногоо хураан авч даршилж нөөцөлж хэрэглэсэн байна. Мөн 10 агропарк, 928,4 тн багтаамжтай 121 зоорь, энгийн болон болон гүний 185 худаг ажиллаж байна.

3. Байгалиас 5,7 тн жимс жимсгэнэ, 83,7 тн самар, 3,9 тн сонгино, мангир, 0,6 тн мөөг ашигласан.

Эрсдэлтэй талууд:

1. Өвөрхангай аймаг нийтдээ 2789 км урттай 220 гаруй гол горхи, 35 нуур, 558 орчим булаг шанд, 20 гаруй рашааны орд байдгаас 51 гол горхи, 97 булаг, 3 рашаан, 20 нуур тойром нь ширгэсэн байна.

Д/д		Усны нөөц /шоо км/	Ашиглах боломжит нөөц
1	Гол мөрний усны нөөц	0,56	0,22
2	Газрын доорх усны нөөц	0,10	0,05

2. Хөрсний эвдрэл, доройтол, элсжилт цөлжилт их явагдаж байгаа.

**Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага****Нэгдүгээр үе шат /2005-2010 он/**

1. 100 худагт засвар шинэчлэлт хийж, 30 инженерийн хийцтэй худаг, 200 гар худаг шинээр гаргана.

2. Сумдад усалгаатай тариалан хөгжүүлж, тариаланчдад тариалангийн газрыг өмчлүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх замаар ашиглалтыг сайжруулж, ургацыг нэмэгдүүлнэ.

**Үр тариа**

Д/д		Хэмжих нэгж	2004 он	Хэрэгжүүлэх үе шатууд		
				1-р үе	2-р үе	3-р үе
1	Тариалангийн талбай	Га	2876,9	5753.8	19194.5	19194.5
2	Хураах ургац	Тн	1076.2	1291.4	1549.7	1859.7
3	Шаардлагатай гурил	Тн	119337.9	165554.4	179214.2	199790.8
4	Хэрэгцээт хэмжээ	%	0.90	0.78	0.86	0.93

3. Малын тэжээлийн таримлын нэр төрлийг олшруулан жилд дунджаар 250 га талбайд тариалалт хийдэг болж тэжээлийн баазыг нэмэгдүүлнэ.

5. Фермерийн болон эрчимжсэн аж ахуйнууд бий болно.

Д/д		Хэмжих нэгж	2004 он	Хэрэгжүүлэх үе шатууд		
				1-р үе	2-р үе	3-р үе
1	Сүүгээр хангах боломж	тн	20383	18492	17145	15936
2	Хэрэгцээг хангах түвшин	%	58.7	38.4	32.9	27.4
3	Шаардагдах сүүний хэмжээ	тн	34716.5	48161.3	52135.0	58121.0
4	Шаардлагатай сайн үүлдрийн үнээ	тоо	12858	17838	19309	21526
5	75 үнээтэй фермерийн тоо	тн	171	239	257	287

6. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах “Зоорь”, “Хүлэмж” төслүүдийг хэрэгжүүлнэ.

Д/д		Хэмжих нэгж	2004 он	Хэрэгжүүлэх үе шатууд		
				1-р үе	2-р үе	3-р үе
1	Тариалангийн талбай	Га	260	306	400	566
2	Хураах ургац	Тн	2008	4406	6912	8150

3	Шаардлагатай хэрэгцээ	Тн	6509.3 4	9030.2	9775.3	10897.7
4	Хэрэгцээг хангах түвшин	%	30.8	48.8	70.7	74.8

7. ХАА-н үйлдвэрлэлийг механикжуулах, газар тариалангийн салбарт нутагшсан сортын үр үржүүлэх, үржлийн шилмэл омог, хэвшлийн малын цөм сүрэг бүрдүүлнэ.

8. Бага газраас их ургац авахын тулд усалгаатай газар тариаланг хөгжүүлэх

### **Хоёрдугаар үе шат /2011-2015 он/**

1. Бэлчээрийн болон атаршсан талбай багасч эрчимжсэн аж ахуйн талбай эрс нэмэгдэнэ.
2. Зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын цэгүүдийг ажиллуулж эхэлнэ.
3. Усалгаат тариалангийн талбайн хэмжээг эрс нэмэгдүүлнэ.

### **Гуравдугаар үе шат /2016-2020/**

1. Атаршсан талбай болон услалтын системүүдийг бүрэн сэргээн ашиглана.
2. Өнөөгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн хүчин чадал бэхжиж, эдийн засгийн боломж нэмэгдэнэ.
3. Хүн амын хүнсний хэрэгцээнд хүнсний ногооны эзлэх хувь нэмэгдэж бүтээгдэхүүний зах зээл нэмэгдэнэ.

## ТАВ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН БҮСҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1990 оноос өмнө монгол оронд хэрэгжиж байсан газар төлөвлөлтийн зарчим нь газрыг нийгэмд аль болох өгөөжтэй ашиглах асуудал байсан бол өнөө үед нийгмийн аливаа үйл ажиллагааг байгалийн нөөцийн даац чадавхид тохируулах, газрын доройтол болох цөлжилт, ой, ургамал, хөрс, усны нөөцийн хомсдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

Газрын менежментийн энэхүү үндсэн зарчмыг баримтлан Өвөрхангай аймгийн өнөөгийн болон хэтийн хөгжилд зохицсон газрын менежментийн бодлогын бүсүүдийг төлөвлөхөд энэхүү ерөнхий төлөвлөгөөний зорилго оршино.

Аймгийн хөгжлийн өнөөгийн ба ойрын 16-20 жилийн чиг баримжааг харгалзан нийт нутаг дэвсгэрийг газрын менежментийн дараахи бүсүүдээр төлөвлөв. Үүнд:

- 1 Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүс
- 2 Хотын болон суурьшсан газрын менежментийн бүс
- 3 Зам шугам сүлжээний газрын менежментийн бүс
- 4 Ойн сангийн газрын менежментийн бүс
- 5 Усан сангийн газрын менежментийн бүс
- 6 Уурхай болон газрыг хадгалан хамгаалах, нөхөн сэргээлтийн менежмент гэх мэт.

### 5.1. Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд

Аймгийн нутаг дэвсгэрийн дийлэнхи хэсгийг хамрах хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд нь ашиглалтын зориулалтаараа **бэлчээрийн, хадлангийн, тариалангийн** гэсэн ангиллын дагуу төлөвлөгдсөн бөгөөд хөдөө аж ахуйн барилга байгууламжийн /хашаа саравч, үтрэм зэрэг/ газры тухайн бүсийн дотор байршихаар тооцож, хэрэгжилтийн шатанд сумын газар зохион байгуулалтын жил бүрийн төлөвлөгөөгөөр зохицуулагдах юм. /Зураг 6/


#### 5.1.1 Бэлчээрийн газрын менежмент

Тус аймаг нь уламжлалт мал аж ахуйг хөгжүүлж ирсэн ба бэлчээр ашиглалт нь улирлын сэлгээгээр голлон зохицуулагддаг. Сүүлийн үед хот суурин, зах зээлээ бараадан малчид улирлаар нүүдэллэх нь багасснаас хагас суурьшмал хэвшил үүсч байгаа нь газар ашиглалтанд зохисгүй нөлөө үзүүлж бэлчээрийн доройтлыг нэмэгдүүлж байна.

Мал аж ахуйн хөгжлийн хэтийн чиглэл, нутаг бэлчээрийн хүрэлцээг тооцон үзвэл цаашид бэлчээрийн аж ахуй түлхүү хөгжих нь ойлгомжтой. Газар ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газрыг зохистой ашиглан хамгаалах үүднээс томоохон хот, суурингийн ойролцоохи болон улсын чанартай төв замын дагуухи газруудад эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бодлогыг баримтлан өнөөгийн бэлчээрийн газрын менежментэд зарчмын нилээд өөрчлөлтүүдийг тусгав.



Бэлчээрийн газрыг газрын эзэмшилт ашиглалтын хувьд 4 үндсэн бүсэд хувааж тус бүрт нь ашиглалтын чиглэлийг тогтоолоо.



### 5.1.1.1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс

Тус аймгийн хувьд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл төдийлөн хөгжөөгүй боловч тухайлбал Тарагт суманд сүүний болон гахай-тахяны аж ахуйг хөгжүүлсэн нь түүний байршлын давуу талаар тодорхойлогдож байна.

Цаашид Хангайн бүсийн эдийн засгийн хөгжлийн бодлого, зах зээлд ойр байдал, үйлдвэрлэл үйлчилгээ түлхүү хөгжсөн болон төв зам дагуу оршдог зэрэг давуу талыг нь бодолцон Хархорин, Уянга, Бат-Өлзий, Хужирт, Тарагт, Өлзийт, Зүүнбаян-Улаан зэрэг сумдад **хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс** бууюу **эрчимжсэн мал аж ахуйн бүсийг** төлөвлөв. /Хүснэгт 13/

Энэхүү бүсийн газар зохион байгуулалтын онцлог нь юуны өмнө олгогдох газрын хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, нарийн төрөлжүүлэн хуваарилахаас гадна эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермерүүд, аж ахуйн нэгжид уг газрыг гэрээний үндсэн дээр эзэмшүүлнэ. Эзэмшил газрын байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах асуудлыг газар эзэмшигч бүрэн хариуцах ба үйлдвэрлэлийнхээ үр ашгийн дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулна. Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэл явуулах учир ашиг шимийн төрөлжилтийн бус бусад мал, амьтан холилдон нутаглах, бусдын мал дамжин өнгөрөхийг тусгай эрхзүйн актын дагуу хатуу хориглох арга хэмжээ авна.

Мөн аж ахуйнууд нь өөрийн хэрэгцээт тэжээлийг тариалах чиглэлээр газар тариаланг хөгжүүлж болно.

#### Хүснэгт 14. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой нутгийн бэлчээрийн даацын одоогийн үнэлгээ

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээр ашиглалтын коэф	Бэлчээрийн даац /үхэр/
		Талбай /га/	Ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/		
1	Зүүнбаян-Улаан	9356.2	2.9	27.1	100	625
2	Өлзийт	6382.9	1.7	10.9	100	250
3	Тарагт	39815.3	1.5	59.7	60	825
4	Хархорин	6445.2	2.6	16.8	100	386
5	Хужирт	1726.8	2.5	4.3	100	99
6	Уянга	3366.5	2.9	9.8	100	225
7	Бүрд	6556.0	1.8	11.8	100	272
8	Арвайхээр	2279.4	2.9	6.6	100	152

Дээрх тооцоог саалийн үнээг дан байгалийн тэжээлээр хангах нөхцөлд ашиглаж болох бөгөөд дулааны улирлын 5 сард байгалийн тэжээлээр үлдсэн сард тариалсан тэжээлийн ургамлаар тэжээх нөхцөлд малын тоог нэмэгдүүлэх боломжтой.

Эрчимжсэн мал аж ахуйн үр ашигт зах зээл болон төв замаас алслагдсан байдал онцгой ач холбогдолтой бөгөөд стандартаар 100 хүртэл км алслагдсан

бол тохиромжтой байдлын хувьд I, 100-200 хүртэл км алслагдсан бол II, 200-300 км алслагдсан бол III, 300-аас дээш км алслагдсан бол тохиромжгүй гэж үздэг. Энэхүү газар зохион байгуулалтаар төлөвлөгдсөн эрчимжсэн мал аж ахуйн бүс нь сум тус бүрд өөрийн зах зээл болон төв замаас хамгийн холдоо 50 км орчим байгаа нь алслагдсан байдлын хувьд тохиромжтой буюу 1 гэсэн үнэлгээний бүсэд байна.

Эрчимжсэн аж ахуйн хүчин чадал нь тэжээлийн нөөцөөс шууд хамаарах ба үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс байгалийн бэлчээрийг түлхүү ашиглахаар тооцож, хүйтний улиралд малыг үр тариа, тэжээлийн манжин, сүрэл, дарш, давс хужиараар байнгын байранд тэжээнэ гэж үзээд нийтдээ 75928.26 га бэлчээр, 6932.2 га тэжээлийн талбайг ашиглахаар төлөвлөсөн болно.

### Хүснэгт 15. Эрчимжсэн мал аж ахуйн тоо

Д/д	Байршил	Аж ахуйн тоо
1	Зүүнбаян-Улаан	6-13
2	Өлзийт	3-5
3	Тарагт	8-15
4	Хархорин	4-8
5	Хужирт	1-2
6	Уянга	2-4
7	Бүрд	3-5
8	Арвайхээр	2-3

Хүнсний хэрэглээний хувьд Тарагт, Хархорин сумд хавьгүй илүү боловч бэлчээрийн нөөц багатайгаас их хэмжээний газар шаардагдана. Иймээс газрын хүрэлцээг харгалзан аж ахуйн тоог хязгаарлахад хүргэж байна. Дээрх тооцоолол нь зөвхөн бэлчээрийн нөөц, га-ийн ургац хоёрыг тооцож гаргасан тооцоо бөгөөд эрчимжсэн аж ахуй эрхлэгчид нь үйлдвэрлэлээ таримал тэжээлээр бүрэн хангасан тохиолдолд түүнийг эрс нэмэгдүүлэх боломжтой.

Одоогоор эрчимжсэн аж ахуйн зориулалтаар төлөвлөгдсөн бүс нутаг голын хөндий, уулсын ар хөндий, хоолой дагасан хар хүрэн, хүрэн хөрстэй, ургамалшилтын хувьд баялаг, ургац сайтай, цаашид сайруулахад бэрхшээл багатай, экологийн даац сайтай газруудыг хамруулсан ба өнөөгийн байдлаар ямар нэг зохицуулалтгүй ашигласнаас бэлчээр талхлагджээ. Иймээс төлөвлөгдсөн бүсийн байгаль орчны тэнцвэрийг хадгалах, нэгэнт доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, усны эх булгийг хамгаалах арга хэмжээг авах нь чухал байна.

#### 5.1.1.2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газартай хосолмол аж ахуйн суурьшлын бүс

Зах зээлийн багтаамжаар төдийлөн сайнгүй, зөвхөн дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл үйлчилгээг өрхийн аж ахуйн болон хоршооны хэмжээнд эрхлэж сүү ба махны чиглэлийн үхэр, хонь, адууны эрчимжсэн аж ахуйг уламжлалт болон хагас суурин маллагааны аргаар хөгжүүлэх бүс нутгийг энэ

ангилалд хамруулав. Энэ нь одоогийн хагас суурин маллагааны аргатай ижил боловч газар зохион байгуулалтын хувьд нийтийн ашиглалтын бэлчээрээс илүү оновчтой арга хэмжээг шаардана.

Газар зохион байгуулалтын онцлог нь олгогдох газрын хэмжээг нарийн нормчилж, төрөлжүүлэхгүй боловч аж ахуй эрхлэгчдийн хүсэлтээр газрыг сонгон гэрээний үндсэн дээр малчдад болон малчдын хамтлагуудад эзэмшүүлнэ.

Газар ашиглалтыг сайжруулах, үр шимийг нэмэгдүүлэхийн тулд аж ахуй болон малчдын хамтлаг дундын хоршилтыг дэмжиж, газрын байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах асуудлыг малчид ба хамтлагууд бүрэн хариуцаж бэлчээр зохион байгуулалтыг нарийвчлан төлөвлөх шаардлагатай. Үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд энэ бүс нутгийг гол төлөв аялал жуулчлал харьцангуй хөгжсөн ба төв зам дагуу байрладаг боловч байнгын зах зээлээс алслагдсан, бүтээгдэхүүн борлуулах хугацаа нь хязгаарлагдмал сумдуудад төлөвлөв. Энд нийт 900246.21 га буюу нийт нутаг дэвсгэрийн 14.3 хувийг хамарсан. /Хүснэгт 16/

### Хүснэгт 16. Бүс нутаг дахь бэлчээрийн даац

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь/	Аж ахуйн чиглэл
		Талбай /га/	Ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/		
1	Баруунбаян-Улаан сумын Бор овооны орчимд	11292.30	1.3	1468.0	2368	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй
2	Бат-Өлзий сумын Онгоцотын ам, Хойд агуйтын ам, Өвтийн ам, Урд агуйтын ам, Бөхийн шар	4447.98	2.6	1156.5	1865	сүүний чиглэлийн үхрийн аж ахуй
3	Баянгол сум	90721.2	3.5	31752.4	51214	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй
4	Хайрхандулаан сум Тээлийн голын хөндийд	5737.4	1.1	631.1	40456	сүүний чиглэлийн үхрийн аж ахуй
5	Хужирт суманд Хаахай болон Орхон голын хөндийд	4537.6	2.4	1089.0	811	сүүний чиглэлийн үхрийн аж ахуй
6	Богд сум	231463.58	1.3	30090.3	48533	ноос, ноолуур сүүний чиглэлийн ямаа болон тэмээний аж ахуй
7	Гучин-Ус	71597.61	1.3	9307.6893	15012	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй

8	Нарийнтээл	303061.19	1.2	36367.3428	58657	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй
9	Тарагт Баянгол сумдын нутгийн заагт	4926.66	1.5	738.999	1192	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй
10	Төгрөг	81042.48	1.4	11345.9472	18300	ноолуур сүүний чиглэлийн ямааны аж ахуй
11	Уянга	91418.28	2.9	26511.3012	42760	сарлагийн аж ахуй

Уулсын ар, бэл хормой, голын хөндийгөөр чийгсэг нугын ургамалтай, нам уулс, ухаа гүвээ дагаж уулын хар хүрэн болон бараан өнгийн хөрстэй хялгана, жижиг үетэн, алаг өвст хээр зонхилно. Хүн малын нягтрал ихтэй хэсэгт бага зэрэг талхлагдсан. Цаашид газрын ачааллыг хэтрүүлэхгүй зөв зохицуулах шаардлагатай.

### 5.1.1.3 Өрхийн аж ахуйн суурьшлын бүс

Томоохон хот суурингийн ойр орчимд зөвхөн өрхийн хэрэгцээний мал бүхий иргэдийг суурьшуулах, мөн газар тариалан, жимс жимсгэнэ, далд хөрсний ногоо, гахай, тахиа, зөгийн аж ахуйг хөгжүүлж буй бүсэд байрлах цөөн тооны мал бүхий өрхийн хэрэгцээнд зориулан төлөвлөсөн газар нь энэхүү бүсэд хамрагдана.

Төлөвлөлтөөр Арвайхээр сум, Тарагт сумын Дайрганы гол болон Нарийнтээл суманд Арцын гол, Таацын гол дагуу нийт 9530.0 га газрыг төлөвлөсөн. Дээрх газруудад иргэд далд хөрсний ногоо тариалж, энэ төрлийн аж ахуй хөгжсөн тул эдгээрийг түшиглэн цаашид өрхийн аж ахуйг нэмэгдүүлэх шаардлагатай.

Газрыг малын бэлчээрийн зориулалтаар ашиглах бөгөөд газрын төлөв байдал, чанарын асуудлыг өрхүүд хариуцна. Бүс дэхь малын тоог түрээсийн төлбөрөөр зохицуулж, хариуцлага хүлээлгэх байдлаар газрыг хамгаалах арга хэмжээ авахыг зөвшөөрнө.

### 5.1.1.4. Чөлөөт ашиглалтын бүс

Хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон Өвөрхангай аймгийн хувьд чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээр давамгайлна. Энэ бүсэд уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд улирлын бэлчээрийн хил заагийг ялгаж гаргалаа.

Газар зохион байгуулалт нь бэлчээр ашиглалтын уламжлалт аргад үндэслэгдэнэ. Үүнд улирлын сэлгээтэйгээр бэлчээрийг нийт дундаа ашиглуулах асуудлыг орон нутгийн төр захиргааны шийдвэрээр зохицуулах ба бэлчээр эзэмшүүлэхийг хориглоно. Малчид газрыг зөв зохистой ашиглах хамгаалах үүрэгтэй бөгөөд нутаг бэлчээрийг улирлын сэлгээ болон отор сонгох замаар ашиглана.

Чөлөөт ашиглалтын бэлчээрийг усжуулах асуудлыг төрөөс шийдэх боловч өөрсдийн хөрөнгөөр худаг гаргасан тохиолдолд зохих урамшуулал хөнгөлөлтийг

хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. Тус аймгийн хэмжээнд нийт 4893387.4 га газрыг чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээрт төлөвлөсөн бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь энэ бүсэд хамагдаж байна. /Хүснэгт 16/

### Хүснэгт 17. Зун-намрын улирлын бэлчээрийн даац

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь/
		Талбай /га/	Малд идэгдэх ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	
1	Баруунбаян-Улаан	90783.1	1.6	145.3	23428
2	Бат-Өлзий	43484.9	2.9	126.1	20340
3	Баянгол	115278.4	1.5	172.9	27890
4	Баян-Өндөр	59677.3	1.7	101.5	16363
5	Богд	200726.4	1.7	341.2	55038
6	Бүрд	57396.2	1.8	103.3	16663
7	Гучин-Ус	118887.3	1.5	178.3	28763
8	Есөнзүйл	42419.2	1.8	76.4	12315
9	Зүүнбаян-Улаан	68620.4	1.7	116.7	18815
10	Нарийнтээл	21135.5	1.5	31.7	5113
11	Өлзийт	41706.8	1.7	70.9	11436
12	Сант	65912.6	1.7	112.1	18073
13	Тарагт	127961.7	1.7	217.5	35086
14	Төгрөг	156642.5	1.5	235.0	37897
15	Уянга	79303.4	2.7	214.1	34535
16	Хайрхандулаан	89449.9	1.5	134.2	21641
17	Хархорин	79270.5	2.6	206.1	33242
18	Хужирт	21519.4	2.8	60.3	9718

Зун-намрын бэлчээр нь голдуу томоохон голууд болон худаг ус ойролцоо байдаг нь бэлчээрийг талхлагдалд оруулахад хүргэдэг бөгөөд судалгаанаас харахад зун-намрын улирлын бэлчээр талхлагдалд их өртсөн байна.

### Хүснэгт 18. Өвөл-хаврын улирлын бэлчээрийн даац

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь/
		Талбай /га/	Малд идэгдэх ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	
1	Арвайхээр	2382.94	0.9	214.5	346
2	Баруунбаян-Улаан	83708.2	0.9	7533.7	12151

3	Бат-Өлзий	182419.4	1.6	29187.1	47076
4	Баянгол	86504.4	0.9	7785.4	12557
5	Баян-Өндөр	234608.2	1.0	23460.8	37840
6	Богд	454006.9	0.9	40860.6	65904
7	Бүрд	200375.5	1.1	22041.3	35550
8	Гучин-Ус	257530.4	0.9	23177.7	37383
9	Есөнзүйл	125303.3	1.1	13783.4	22231
10	Зүүнбаян-Улаан	173610.8	1.3	22569.4	36402
11	Нарийнтээл	232511.1	0.8	18600.9	30001
12	Өлзийт	120212.2	1.1	13223.3	21328
13	Сант	196607.5	0.9	17694.7	28540
14	Тарагт	172860.4	0.9	15557.4	25093
15	Төгрөг	249862.3	0.9	22487.6	36270
16	Уянга	101619.4	1.8	18291.5	29502
17	Хайрхандулаан	259757.2	0.8	20780.6	33517
18	Хархорин	143583.5	1.4	20101.7	32422
19	Хужирт	135748.5	1.5	20362.3	32842

Энэ бүсэд голдуу тал хээрийн болон цөлөрхөг хээрийн өргөн уудам нутаг дэвсгэртэй сумдууд хамрагдах ба ургамлан нөмрөг нь сийрэг тачир, ургац багатай, хөнгөн хөрстэй, уур амьсгалын хувьд хуурайдуу байдгаас нь газрын нөхөн сэргээх чадвар маш сул байдаг онцлогтой.

#### 5.1.1.5. Бэлчээрийн газрыг нөхөн сэргээх

Тус аймгийн хувьд газар нутгийн ихэнх хувийг ХАА-н газар тэр тусмаа бэлчээрийн газар эзлэх ба голчлон уламжлалт мал аж ахуй эрхэлдэг. Хархорин сумаас бусад сумдад газар тариалангийн үйлдвэрлэл багахан хувийг эзэлдэг.

Сүүлийн жилүүдийн уур амьсгалын хуурайшилт, нутагшил суурьшлын өөрчлөлт нь бэлчээрийн газрын төлөв байдал чанарт сөргөөр нөлөөлж байна. 2003 онд хийгдсэн бэлчээрийн газрын хянан баталгааны судалгаанаас үзвэл тус аймгийн бэлчээрийн 45.67 хувь нь хүний үйл ажиллааны улмаас төлөв байдал, чанарын өөрчлөлттэй болжээ. /Хүснэгт 19/

#### Хүснэгт 19. Бэлчээрийн нөлөөллийн байдал

Д/д	Нөлөөллийн ангилал	Талбай	
		га	хувь
1	Техногений нөлөөлөлтэй	8089.8	0.13
2	Хад асга чулуутай	34744.5	0.55
3	Элсний нүүлттэй	75628.8	1.20
4	Худаг усны хүрэлцээгүй	396714.7	6.31
5	Алслагдсан	272115.3	4.33



6	Их талхлагдсан	349726.8	5.56
7	Дунд зэрэг талхлагдсан	1587434.0	25.24
8	Хэвийн бэлчээр	3565079.1	56.68

Нийт бэлчээрийн 5.56 хувь буюу 349726.8 га нь их талхлагдалд орсон, 1.2 хувь нь элсжээд байгаа тул ашиглалтаас түр чөлөөлж сэргээх шаардлагатай. Техногений нөлөөлөлд хамрагдах уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар хэмжээгээр бага боловч орчиндоо үзүүлэх нөлөө ихтэй байна.

### Хүснэгт 20. Ашиглалт багатай бэлчээрийн хэмжээ ба шалтгаан

Д/д	Шалтгаан	Талбай	
		га	Нийт нутагт эзлэх хувь
1	Хад асга чулуутай	34744.5	0.55
2	Худаг усны хүрэлцээгүй	396714.7	6.30
3	Алслагдсан	272115.3	4.32

Худаг усны хүрэлцээгүй болон алслагдсан гэсэн шалтгаанаар ашиглахгүй байгаа бэлчээрт худгийг засах, шинээр худаг гаргах замаар бэлчээрийн хүрэлцээг нэмэгдүүлж, бэлчээрийн талхлагдал бууруулах боломжтой.

Чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээр зохион байгуулалтын үндэслэл нь 3 сэлгээт ашиглалтын бүдүүвч юм.

### Хүснэгт 21. Бэлчээрийг дулааны улиралд ашиглах гурван сэлгээт бүдүүвч

Ашиглах жилүүд	Бэлчээрийн хэсэг, түүнийг ашиглах дараалал		
	I хэсэг	II хэсэг	III хэсэг
Эхний жил	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	Намар /X-XI сард нэг ээлжээр/
Хоёр дахь жил	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	/X-XI сард нэг ээлжээр/	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/
Гурав дахь жил	X-XI сард нэг ээлжээр	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/

Харин их талхлагдсан бэлчээрийг байгалийн аясаар нөхөн сэргээхэд доорхи сэлгээг хэрэглэнэ.

### Хүснэгт 22. Талхлагдсан бэлчээрийг сэргээх сайжруулах сэлгээний бүдүүвч

Ашиглах дараалал /жилээр/	Бэлчээрийн хэсэг, түүний улирлаар ашиглах дараалал				
	I хэсэг	II хэсэг	III хэсэг	IV хэсэг	V хэсэг

Эхний жил	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр
Хоёр дахь жил	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр
Гурав дахь жил	ҮIII-X сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө
Дөрөв дэхь жил	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр
Тав дахь жил	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр

### 5.1.2. Хадлангийн газрын менежмент

Өвөрхангай аймаг нь 5821.8 га хадлангийн газартай бөгөөд эндээс 2004 онд нийт 20.3 мян.тонн хадлан бэлтгэжээ. Сүүлийн 4 жилийн байдлаар 2003 онд хамгийн их буюу 22.4 мян.тонн хадлан хадсан байна.

#### Хүснэгт 23. Хадлангийн газрын хэмжээ ба ашиглалтын байдал.

Д/д	Сумын нэр	Талбай		Ашиглалтын байдал
		га	хувь	
1	Төгрөг	3.00	0.05	Хадлан хаддаг
2	Бүрд	280.00	4.81	Хадлан хаддаг
3	Баруунбаян-Улаан	89.00	1.53	Хадлан хаддаг
4	Өлзийт	129.00	2.22	Хадлан хаддаг
5	Есөнзүйл	1175.00	20.18	Хадлан хаддаг
6	Зүүнбаян-Улаан	1310.00	22.50	Хадлан хаддаг
7	Нарийнтээл	30.80	0.53	Хадлан хаддаг
8	Хархорин	1436.00	24.67	Хадлан хаддаг
9	Хайрхандулаан	19.00	0.33	Хадлан хаддаг
10	Хужирт	1129.00	19.39	Хадлан хаддаг
11	Уянга	221.00	3.80	Хадлан хаддаг
	<b>Нийт</b>	<b>5821.80</b>	<b>100.00</b>	

Тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхээр бэлчээрээс хадаж болох 2650.76 га талбайг төлөвлөсөн бөгөөд энэ талбайгаас жилд дунджаар 10.2 мян. тонн өвс бэлтгэнэ гэж үзэхэд аймгийн хэмжээнд жилд 32.6 мян.тонн хадлан бэлтгэх боломжтой юм.

**Хүснэгт 24. Хадаж болох бэлчээрийн хэмжээ**

Д/д	Сумын нэр	Талбай	
		га	хувь
1	Бат-Өлзий	1256.93	43.22
2	Баян-Өндөр	89.90	3.09
3	Өлзийт	154.22	5.30
4	Есөнзүйл	99.73	3.43
5	Зүүнбаян-Улаан	596.82	20.52
6	Нарийнтээл	21.62	0.74
7	Сант	118.33	4.07
8	Тарагт	314.61	10.82
9	Хархорин	151.40	5.21
10	Хайрхандулаан	53.37	1.84
11	Төгрөг	51.02	1.75
	<b>Нийт</b>	<b>2907.95</b>	<b>100.0</b>

Өвөрхангай аймгийн хэмжээнд одоо байгаа хадлангийн талбайнуудаас гадна Нарийнтээл, Уянга, Тарагт, Баян-Өндөр, Баруунбаян-Улаан, Есөнзүйл, Бат-Өлзийт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад хадаж болох бэлчээрийн нөөц нилээд байгаа бөгөөд эдгээрийг ашигласнаар хадлангийн талбайг нэмэгдүүлж болно. Бэлчээрийн газрын төлөвлөлттэй холбоотой эрчимжсэн буюу нарийн төрөлжсөн аж ахуйн орчмын хадлангийн талбайнуудыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

**5.1.3.Тариалангийн газрын менежмент**

Өвөрхангай аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн гол бүс нь Хархорин, Нарийн тээл, Төгрөг зэрэг суманд байрлана. Тариалалт хийдэг 6949.5 га талбайн 6480.6 га буюу 93.3 хувьд үр тариа тариалж, 455.9 га буюу 6.6 хувьд төмс, хүнсний ногоо, 13 га буюу 0.1 хувьд тэжээлийн ургамал тариалж байна. Тус аймгийн хэмжээнд нийт 36981.7 га атаршсан талбай байгаа бөгөөд энэ нь хөрсний үржил шимийн хувьд эргүүлэн тариаланд ашиглахад боломжтой газар байна.

Тариалангийн газрыг хөрсний шимт чанараар нь ангилан үзвэл дараахи байдалтай байна. /Хүснэгт 25/

**Хүснэгт 25. Тариаланд ашиглаж буй болон ашиглаж болох газрын хэмжээ ба чанар**

Зураг дээрх дугаар	Тариалангийн хэлбэр	Бүгд талбай /га/	Үүнээс			
			Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрстэй газар /Агрогрупп I/	Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрстэй газар /Агрогрупп II/	Тариаланд тохиромжтой сайн чанарын хөрстэй газар /Агрогрупп III/	тариаланд ашиглаж болох боловч төдийлэн тохиромжтой бус хөрс

1	Тариаланд ашиглаж буй	10010.00	9889.42	120.58		23.9
2	Тариалах боломжтой атаршсан газар	18769.41	18769.41			11.0
3	Усжуулалт, нэмэлт сайжруулалт хийж ашиглах талбай	7272.04	6970.53			301.51
4	Атаршуулан бэлчээрт шилжүүлэх	314.86	290.57	23.35	0.94	
5	Өрхийн тариалан хөгжүүлэх боломжтой	305.78	232.48	73.3		
6	Тэжээл тариалах	6307.10	6307.1			
	<b>Нийт дүн</b>	<b>42979.19</b>	<b>42459.51</b>	<b>217.23</b>	<b>0.94</b>	<b>336.4</b>

1970-аад оны эхээр Өвөрхангай аймгийн тариалангийн талбайд агроүйлдвэрлэлийн I группын хөрс 42459.5 га буюу 98.7 хувь, II группын хөрс 217.2 га буюу 0.5 хувь, III группын хөрс 0.94 га буюу 0.002 хувь, V группын хөрс 301.5 га буюу 0.8 хувьд тархсаныг судалгаагаар тогтоожээ. Гэвч ашиглалтын явцад эдгээр нь үржил шимээ алдаж элэгдэл эвдрэлд орсон байна. 1990 оны эхээр хийгдсэн хөрсний судалгаагаар тус аймгийн тариалангийн хөрсний 64.3 хувь нь элэгдэл эвдрэлд орсны 17.3 хувь нь хүчтэй эвдэрсэн байна. Ялангуяа газар тариалангийн голлох бүс Хархорин сумын тариалангийн талбайн төрх байдлыг судлан үзвэл хөрсний өнгөн хэсэг нь нунтагарч, бүтэцгүй болсон 5-10 см-ийн зузаантай элсээр хучигдсэн, талбайн захаар далан үүсгэсэн байгаа ба ийм байдал, Өдзийтийн Овоо, Хөшигний хөндийд ажиглагдана. Мөн 242.5 га хөрс усны эвдрэлд оржээ.

Гэвч зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс орны стратегийн гол бүтээгдэхүүн болох гурилын дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлээс хамгаалах, усжуулалтыг хэрэглэх замаар ургацын хэмжээг нэмэгдүүлэн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Хөрсийг хамгаалах, үржил шимийг дээшлүүлэхийн тулд дараахи арга хэмжээг авах, үүнийг хэрэгжүүлэхийн тулд газар эзэмшигч ашиглагчдын гэрээний нөхцөлд нарийн тусгах, мөн эвдрэлд орсон хөрсийг улс, орон нутгийн хөрөнгөөр нөхөн сэргээх ажлыг жилийн бүрийн төсөвт тусгуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

### **Хөрс хамгаалах талаар авах арга хэмжээ:**

1. Канад зэрэг манай орнтой ижил төстэй уур амьсгал, хөрсний нөхцөл бүхий оронд амжилттай хэрэгждэг хөрс боловсруулалтын цомхотгосон технологийг нэвтрүүлэх, үүнийг нэвтрүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын болон хөрөнгийн асуудлыг шийдэх бодлого боловсруулан улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх

2. Газар тариаланд тариалалтын уламжлалт технологи хэрэглэж буй тохиолдолд 30-50 см-ийн өргөнтэйгээр салхины зонхилох чигт хөндлөн байдлаар зурваслан тариалах, хөрс боловсруулалтанд хавагч техникийг голлон ашиглах, хөрсөн дээр босоо болон хэвтээ гуурсийг аль болох ихээр үлдээх

3. Ойн зурвас байгуулах, түүний өтгөрлийг орон нутгийн салхины хурд, давтамжид зохицуулан эрдэм шинжилгээний байгууллын зөвлөснөөр хийх

4. Хүчтэй эвдрэлд орсон талбайд олон наст тариалах. Ингэхдээ олон настын үр суулгалтын гүн хэт гүехэн тул ногоон тэжээлээр хөшиглөн тариалах нь үр дүнтэй юм. Ногоо тэжээлийг 6-р сарын 10-наас 6-р сарын 20-ны дотор тарьж, түүнийг соёолохоос өмнө олон насыг бороо угтуулан суулгах нь зүйтэй.

5. Уриншийн элдэншүүлэлтийг зөв зохион байгуулах

#### **Хөрсний үржил шимийг сайжруулах талаар авах арга хэмжээ:**

1. Тариалах таримлын төрлөөс шалтгаалан хөрсийг эрдэс болон шим бордоогоор бордох нь зөвхөн хөрсний шим тэжээлийн бодисыг нөхөөд зогсохгүй арвин их ургац авах боломжийг бүрдүүлнэ.

2. Хөрснийг бордохын тулд хөрсний агрохимийн картограмм хийлгэж бордооны тунг, сэргээг нарийвчлан тогтоолгох шаардлагатай.

3. Хөрс бордох тун тухайн хөрсний шим тэжээлийн бодисын түвшингээс гадна таримлын төрлөөс шалтгаалан өөр өөр байх боловч хангайн ба тал бүсэд үр тарианд NPK 90:90:60, төмс хүнсний ногоонд 100:110:90 эрдэс бордооны тун, 1га-д 40 цн –оор тооцож шим бордоог хэрэглэх нь зүйтэй. Харин цөлөрхөг хээрийн бүсэд голдуу усалгаатай тариалан эрхлэх бөгөөд бордоог хэрэглэхдээ давсжилтын зэрэг төрлийг нарийн тогтоож бордох шаардлагатай юм.

4. Хөрсний үржил шимийн хэвийн байлгах, мөн түүнчлэн дээшлүүлэхэд оновчтой тогтоосон ээлжлэн тариалах системийг бүрдүүлэх. Үр тариа болон бусад тарималд өмнөгчийн чадавхи болоод ногоон уринш бордуурыг ашиглах нь эдийн засгийн болоод экологийн олон сайн талтай.

5. Хог ургамалтай тэмцэх. Сүүлийн үед хэрэглэж байгаа техникийн явалтыг цөөлсөн гербицид ашиглах технологийг нэвтрүүлэх

6. Талбайн чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэх

#### **5.1.3.1. Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийн менежмент**

Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийг хуучин тариалалт хийж байсан Хархорин, Бүрд, Есөнзүйл сумдад үр тарианы чиглэлээр, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан, Хужирт сумдад малын тэжээлийн чиглэлээр, Нарийнтээл, Төгрөг, Уянга, Баруунбаян-Улаан сумдад төмс, хүнсний ногооны чиглэлээр тус тус төлөвлөв.

#### **Хүснэгт 26. Тариалангийн газрын менежментийн бүсүүд**

Д/д	Газрын нэр	Зураг дээрхи контурын дугаар	Талбай /га/	үүнээс				Тайлбар
				Агро групп I	Агро групп II	Агро групп III	Агро групп V	
Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүс								
1	Бүрд	001-023	3036.10	3036.10				үр тариа
2	Баруунбаян-Улаан	001-002	34.90				34.90	төмс, хүнсний ногоо
3	Өлзийт	001-003, 010-012, 014-015	1353.44	1353.44				үр тариа
4	Есөнзүйл	005	2810.04	2810.04				үр тариа
5	Зүүнбаян-Улаан	001, 003-006	342.86	338.76	4.10			малын тэжээл

6	Хархорин	001, 003, 005-018, 020-028, 030-038, 051-056, 064-249	26772.02	26772.02				үр тариа
7	Хайрхандулаан	003-008	374.88	374.88				малын тэжээл
8	Хужирт	009-014-013, 024-027	628.38	386.74	38.36	185.69	17.59	малын тэжээл
9	Уянга	001-011	613.15	508.45	104.70			төмс, хүнсний ногоо
		<b>Бүгд</b>	<b>35965.77</b>	<b>35580.43</b>	<b>147.16</b>	<b>185.69</b>	<b>52.49</b>	
Өрхийн тариалан эрхлэх бүс								
1	Тарагт	007-011, 013	232.48	232.48				төмс, хүнсний ногоо
2	Баянгол	001-002	51.59		51.59			төмс, хүнсний ногоо
3	Нарийнтээл	007	21.71		21.71			төмс, хүнсний ногоо
		<b>Бүгд</b>	<b>305.78</b>	<b>232.48</b>	<b>73.3</b>			
Газар тариаланг МАА-тай хослуулан эрхлэх бүс								
1	Уянга	001-011	613.15	508.45	104.70			төмс, хүнсний ногоо, малын тэжээл
2	Бат-Өлзий	001-010	111.40	111.40				төмс, хүнсний ногоо, малын тэжээл
3	Өлзийт	004-006, 007-009, 013	658.81	658.81				төмс, хүнсний ногоо, малын тэжээл
4	Тарагт	001-006	1017.01	1011.33	5.68			төмс, хүнсний ногоо, малын тэжээл
5	Хархорин	002, 004, 019, 029, 050, 057-059, 060-063	3782.24	3782.24				төмс, хүнсний ногоо, малын тэжээл
6	Нарийнтээл	001-003, 005-006	78.13		55.13	16.57	6.43	төмс, хүнсний ногоо

7	Төгрөг	001-003	30.52		30.52			ТӨМС, хүнсний ногоо
8	Хужирт	001-008	749.57	749.57				ТӨМС, хүнсний ногоо, малын тэжээл
		<b>Бүгд</b>	<b>7040.83</b>	<b>6821.8</b>	<b>196.03</b>	<b>16.57</b>	<b>6.43</b>	

Газар тариаланг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нь голдуу зузаан ба дунд зэргийн зузаан, дунд шавранцар, дунд бага зэрэг чулуурхаг, чулуутай хүрэн ба хар хүрэн хөрс, хүнд шавранцар нугын хар хүрэн хөрс, нугын карбонатлаг бага зэрэг чулуутай хар шороон хөрс, нугын хар шороон хөрс дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг, хар хүрэн, дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг хүрэн, нугын хүрэн хөрс, нимгэн хүрэн, зузаан цайвар бага зэрэг чулуутай хүрэн хөрстэй бөгөөд дийлэнхи нь агро үйлдвэрлэлийн I- II зэрэглэлийн ангид хамрагдана. Харин дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг хүрэн, нугын хүрэн хөрс нимгэн хүрэн, зузаан цайвар бага зэрэг чулуутай хүрэн хөрс, мөн цөлөрхөг хээрийн мараалаг, нугархаг бор хөрс нь агроүйлдвэрлэлийн III ба IV группэд хамрагдах боловч ихээхэн алаг цоог байрласан тул үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хүчин зүйлсийн тоонд орохгүй байна.

Тус бүсэд байгаа услалтын системийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээс харж болно.

### Хүснэгт 27. Өвөрхангай аймгийн инженерийн хийцтэй услалтын систем, түүний ашиглалтын байдал

Д/д	Услалтын системийн нэр	Услалтын системийн координат	Ашиглалтанд орсон он	Төслийн анхны хүчин чадал /га/	1990 оны эхэнд байсан хүчин чадал /га/	2001 оны эхэнд байсан хүчин чадал /га/
1	Хархорин	X 102° 54'	1962	8150	3285	500
		У 47° 13'				
2	Сарын хөндий	X 103° 28'	1979	74	74	0
		У 46° 43'				
3	Мазарын гол	X 102° 31'	1976	37	37	10
		У 45° 17'				
4	Цуурайн гол	X 102° 36'	1987	219	219	0
		У 47° 22'				

Эндээс харахад услалтын системийн ашиглалт ихээхэн хангалтгүй байгаа бөгөөд Мазарын голын ба Хархорины услалтын системийн 6.1-27 хувь нь ашиглалттай байна. Цаашид орчин үеийн дэвшилтэт техник технологийг хэрэглэснээр услалтын системүүдийг сэргээж ашиглах нь газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болно.

Эдгээр услалтын системүүдээс гадна Тарагт сумын Хүрэмт болон Бүрд сумын Боригдойн энгийн услалтын системийг сэргээн ашиглахаар төлөвлөв.

Энэ бүсэд орших талбайнуудыг үр тарианы аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд эзэмшүүлэхээс гадна цөөн хэдэн талбайг малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалахад зориулан өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулна.

Одоогийн байдлаар тариалангийн газрын эргэн тойрны бэлчээр их талхлагдсан учир нөхөн сэргээх зорилгоор тариалалтын явцад талбай хоорондын замыг цэгцлэх замаар орчны бэлчээрийг талхлахгүй байх, нөхөн сэргээх зэрэг зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

### **5.1.3.2. Газар тариаланг мал аж ахуйтай хослуулан эрхлэх бүсийн менежмент**

Энэ бүсийг Бат-Өлзий, Өлзийт, Хархорин, Хужирт, Тарагт сумдад төлөвлөж байгаа бөгөөд энэ хэсэг нь голдуу мал аж ахуйн хувьд хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн аж ахуйн бүс учир голчлон малын тэжээл болон тухайн аж ахуйд хэрэгцээнд шаардлагатай тариалалт хийхээр төлөвлөгдөж байна.

Хөрсний үржил шимийн хувьд голдуу агро үйлдвэрлэлийн I группын хөрстэй учир үр тариа болон малын ногоон тэжээл, далд хөрсний ногоо, жимс жимсгэнэ тариалахад алинд нь ч тохиромжтой.

1973 онд ашиглалтанд орсон Арвайн талын 120 га талбайг услах хүчин чадалтай услалтын систем 2001 онд ямар ч ажиллагаагүй болжээ. Цаашид үүнийг сэргээж, нарийн төрөлжсөн аж ахуйд эзэмшүүлэх, мөн боломжтой хэсгийг нь өмчлүүлэх нь зүйтэй юм.

### **5.1.3.3. Өрхийн тариалангийн бүсийн менежмент**

Хүн амын суурьшлыг дагуулан голоос суваг шуудуу татах замаар хямд төсөр, экологийн хувьд эрсдэлгүй байхаар услалтыг бий болгож өрхийн тариаланг хөгжүүлэхээр төлөвлөв.

Өнөөгийн байдлаар Тарагт сумын нутаг Дайрганы гол орчимд болон Нарийнтээл сумын Арцын голд 34.1 га бүхий багахан хэмжээний талбайнуудыг голоос татсан суваг шуудуугаар усалж ногоо тариалдаг. Цаашид төлөвлөлтөөр 305.78 га газрыг тус бүсэд оруулах бөгөөд өрхийн тариалангийн талбайнууд нь хэсэгчлэн бага хэмжээгээр зохион байгуулагдсан учир хөрсний үржил шим харьцангуй сайн. Тарагт суманд агро үйлдвэрлэлийн I группын хөрс зонхилж байгаа бол нөгөө хоёр суманд агро үйлдвэрлэлийн II группын хөрс тархжээ. Нарийнтээл сумын хувьд төмс, хүнсний ногооны тариалалтаар аймагтаа нилээд дээгүүр ордог, ялангуяа байцааны тариалалт энэ суманд их байдаг. Айл өрхүүд болон иргэд энэ тал дээр нилээд туршлагатай болсон, мөн баруун аймгуудыг холбосон төв зам дээр байдаг зэрэг нь газар тариалан ялангуяа өрхийн тариалан эрхлэх боломжийг бүрдүүлдэг. Хөрсний нөхцлөөр таруу Баянгол сум нь аймагт ойр байдаг давуу талаа ашиглан сүүлийн үед газар тариалан эрхлэх сонирхолтой болжээ.

Өрхийн тариалангийн бүсийн газар зохион байгуулалтын онцлог нь газрын хэмжээ 0.1 га-гаас ихгүй байх ба газрыг иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмшүүлж, өмчлүүлж болно.



Өрхийн тариаланчдын хоршсон үйл ажиллагааг дэмжиж услалтын систем барих, агротехникийн арга хэмжээ авах зэргийг нэгдсэн замаар шийдвэрлэх үүднээс газрыг энд тэнд алаг цоог олгохгүй багц байдлаар олгох нь зүйтэй. Газрын хуулийн дагуу төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх, хөрөний үржил шимийг тогтоож аргохимийн картограмм хийлгэх, түүнчлэн элэгдэл эвдрэлээс хамгаалах асуудлыг тариаланчид өөрсдийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх бөгөөд тэдгээрийг газрын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг хөрөнгө оруулалттай уялдуулан шийдэхийг орон нутгийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

#### **5.1.3.4. Атаршуулах газар**

Урьд өмнө тариалангийн зориулалтаар хагалагдсан газруудын хөрсний үржил шим харьцангуй сайн боловч усны нөөц хомс, орон зайн хувьд алслагдсан зэрэг байдлаас болоод 314.86 га газрыг атаршуулсан байна. Эдгээрийг бэлчээрт ашиглах нь тохиромжтой гэсэн орон нутгийн саналыг тус төлөвлөгөөнд тусгалаа. Эдгээр газрууд 2005 оны байдлаар бүрэн атаршиж үндсэндээ ургамлан нөмрөгийн бүтцэд байгалийн ургамал давамгайлах болсон байна.

#### **5.1.3.5. Газар тариаланд ашиглаж болох атар газар:**

Тус аймгийн хувьд тариалангийн талбайг нэмж төлөвлөх шаардлагагүй бөгөөд одоо байгаа атаршсан талбайнуудыг эргэлтэд бүрэн оруулж ашиглах нь зүйтэй юм.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тариаланд ашиглахад тохиромжтой цөөхөн газруудыг сонгосон бөгөөд эдгээрийг орон нутаг болон иргэдийн санал болгосны үндсэн дээр зөвхөн өрхийн тариалангийн зориулалтаар ашиглахаар төлөвлөсөн юм.

Аймгийн хэмжээнд нэмж өрхийн тариаланд төлөвлөсөн 73.3 га газар талбай нь хөрсний агро үйлдвэрлэлийн II группын буюу тариаланд тохиромжтой дунд чанарын хөрстэй байна. Энэ хөрсөнд нарийн ногоо тариалах боломжтой бөгөөд хөрс боловсруулалтыг сайтар хийх нь чухал. Мөн эрдэс болон шим бордоог өргөн хэрэглэх, хөрсийг эвдрэлээс хамгаалах шаардлагатай.

### **5.2. Хотжсон болон суурьшсан газрын менежментийн бүсүүд**

#### **5.2. Хотжсон болон суурьшсан газрын менежментийн бүсүүд**

Өвөрхангай аймагт улсын ба аймгийн зэрэглэлтэй хот тус бүр 1, сумын төв тосгод 18 байна.

Эдгээрээс инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй нь Арвайхээр ба Хархорин хотууд юм. 1960-аад оны үед баригдсан Хархорин хотын инженерийн шугам сүлжээ бүхэлдээ ажиллагаагүй болжээ.

Сумын төвийн барилга байшин болон гэр хорооллууд нь нам даралтын болон ердийн зуухаар халдаг. Бохир цэвэр нэгдсэн усны системгүй байна.

1980-1988 оны үед хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийгдэж төв суурингуудын дотоод бүсчлэлийг тогтоосон боловч энэ төлөвлөгөө гүйцэд

хэрэгжээгүйгээс дотоод бүсчлэлийг ялгахад ихээхэн түвэгтэй болсон байна. Энэ нь өнөөгийн газрын харилцаа болон хот байгуулалтын наад захын шаардлагад нийцэхгүй байна.

### **5.2.1. Хотын газар нутгийн үүргийн бүс**

Өвөрхангай аймагт улсын зэрэглэлтэй хот нэг, аймгийн зэрэглэлтэй хот нэг, бусад нь орон нутгийн тосгодын ангилалд багтдаг хот суурингууд оршдог ба эдгээрийн газрын менежментийн бодлогыг хот ба тосгодын доторхи функциональ бүсүүдээр ялгаж тодорхойллоо.

Хот суурингийн газрын менежментийн бүсчлэлийн зарчим нь ландшафтын онцлог нөхцлийг хүн амын төвлөрөл ихтэй, газар ашиглалт эрчимтэй явагддаг хязгаарлагдмал орон зайд зохистой ашиглан хамгаалах, хүний ая тухтай амьдрах орчлыг бүрдүүлэхэд тулгуурласан ба газрын харилцааны өнөөгийн шаардлагаар газар төлөвлөлт ба ашиглалтыг өөрийнх нь экологийн чадавхид тохируулан нормчлохдоо газарзүйн мэдээллийн системийг ашигласан болно.

Төв суурин газруудад 1980-аад оны дунд ба сүүлчээр хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан боловч түүний хэрэгжилт хангалтгүй, хотын доторхи бүсчлэл сумдад төдийгүй томоохон хотуудад ч алдагджээ. Харин Хархорин хотын ерөнхий төлөвлөгөөг 2004 онд хот байгуулалт нийтийн аж ахуйн газраас шинэчлэн боловсруулж, хотын доторхи бүсийг шинэчлэн тогтоожээ.

Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний газар нутгийн үүргийн бүсчлэлийн хүрээнд барилгажуулах асуудлыг хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр шийдэж, газрын эрэлт хэрэгцээний дагуу жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх нь газрын харилцааны удирдлагын үндсэн механизм юм.

Хот, суурингийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын төвлөрөл суурьшлыг харгалзан хотын доторхи функциональ бүсүүдийг дараахи байдалтай төлөвлөв. /Хүснэгт 28, зураг 6-25/

Үүнд:

#### **Гэр хорооллын бүс:**

Эхнээсээ эмх замбараа муутай, төлөвлөгөөгүй байгуулагдсан, газарт учруулах сөрөг үр дагавар ихтэй уламжлалт-гэр сууцын хэлбэрээ хадгалсан, ердийн галлагаатай, цахилгаанаас өөр дэд бүтэцгүй хотын хүн амын дийлэнхи нь суурьшсан бүс юм. Хорооллын доторхи нийтийн эзэмшил газар нь тохижилттгүй, техник болон хүн малын нөлөөгөөр талхлагдаж хөрсний бүтэц алдагдаж тоосжсон, бохир зайлуулах системгүйгээс ахуйн шингэн хаягдал хөрсөнд шингэдэг. Энэ нь хүн амын бөөгнөрөл ихтэй томоохон хотууд болох Хархорин, Арвайхээр хотуудад хөрс ба агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байна.

Гэр хорооллын хөрсний элсжилтээс үүссэн тоосжилт агаарын чанарт сөргөөр нөлөөлөхөөс гадна элсний нүүлтийг нэмэгдүүлж байна.

Гэр хорооллын газрыг оновчтой нормчлон төлөвлөж олгоогүйгээс зарим айл өрхийн хашаа цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс болон худгийн эрүүл ахуйн бүсэд оржээ. Мөн гудамжны орц гарцыг төлөвлөөгүйгээс гудамжны урт хэт үргэлжилж, хүн ба машин техникт илүү явалт үүсгэж үр ашиггүй зардлыг бий болгожээ.

2003 оноос гэр бүлийн зориулалтаар газар өмчлүүлж эхэлсэн нь томоохон хотуудын төлөвлөлтийг сайжруулахад зохион байгуулалтын болоод хөрөнгө хүчний нэмэлт зардлыг үүсгэх нөхцлийг бүрдүүлж байна.

Гэр хорооллын бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэхэд дараахи хэдэн асуудлыг шийдэх шаардлагатай юм.

1-рт: Цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс, худгийн болон голын усны эрүүл ахуйн бүсэд суурьшсан айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх

2-рт: Гэр хорооллын гудамжны зохион байгуулалтыг сайжруулан орц гарцтай болгох, хэт үргэлжилсэн гудамнуудыг таслан нэвтрэх замыг чөлөөлөх

3-рт: Нийтийн эзэмшил газар, айлуудын хашааны газрыг зүлэг болон бусад ногоон байгууламжтай болгох замаар гэр хорооллын газрыг нөхөн сэргээх, хамгаалах, тохижуулах

4-рт Газрын төлбөрийг өрх бүрт бүрэн хэмжээгээр ногдуулан, харин газраа хамгаалсан нөхөн сэргээсэн айл өрхүүдэд төлбөр татварын хөнгөлөлт үзүүлэх

Төлөвлөлтийн хугацаанд хот суурингийн хүн амын нөхөн болон механик өсөлт хотуудад янз бүр байх боловч Арвайхээр, Хархорин хотуудад нилээд эрчимтэй байх болно. Нийтийн тохилог орон сууцны хангамж хүн амын өсөлтийг гүйцэхгүй нь ойлгомжтой учир гэр хорооллыг хот тэлэх бүсэд байршуулахаар төлөвлөгөөнд тусгалаа.

Одоогийн байгаа гэр хорооллын газрын нягтралыг сайжруулан гудамжнуудыг тэгшитгэн олгох, хороололын дундах илүү орон зайг гэр бүлийн зориулалтаар эзэмшүүлэх бодлогыг баримтлан шинээр нэмж олгохоор төлөвлөсөн болно.

**Нийтийн үйлчилгээний бүс:** Энэ бүсэд банк, зочид буудал, холбоо, худалдааны төвүүд, эмийн сан, дэлгүүр /барааны болон хүнсний / зэрэг үйлчилгээний газрууд хамрагддаг бөгөөд бүгдийг нэг дороос гэсэн зарчмыг баримтлан нийтийн зориулалттай орон сууцны болон амины орон сууцны бүстэй хамтатган төлөвлөв.

Зарим сумын төвүүдэд энэ бүсийн зохион байгуулалт алдагджээ. Тухайлбал Хайрхандулаан, Бат-Өлзий сумын төвүүдэд нийтийн үйлчилгээний бүс гүний худгийн эрүүл ахуйн бүсэд байршуулсан нь газар болон хот байгуулалтын норм дүрмийг зөрчсөнөөс гадна үйлчилгээ иргэдээс холдож байгаа тал ажиглагдлаа. Тухайлбал Хужирт сумын төвд энэ бүс зөвхөн голын баруун талаар байрласан нь голын зүүн талын айлуудаас ихээхэн алслагджээ.

Нийтийн үйлчилгээний бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амд үйлчилгээний хүрэлцээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэхэд дараахи асуудлыг шийдэх шаардлагатай байна.

1-рт: “Бүгдийг нэг дороос” гэсэн зарчмыг баримтлан үйлчилгээг хүн амд ойртуулан төлөвлөх шаардлагын үүднээс зарим хот суурингуудад нийтийн үйлчилгээний бүсийг нэмж төлөвлөв.

2-рт: Олонхи хот суурингуудад нийтийн үйлчилгээний бүсийн байрилга байгууламжууд цэгчилсэн байршилтай бие биенээсээ салангид байгаа нь хотын өнгө үзэмж архитектурт зохисгүй нөлөөлж байгаад дүгнэлт хийж, шинээр олгох боломжгүй болсон жижиг орон зайнуудыг газар эзэмшигч ашиглагчдын эзэмшилд шилжүүлэх

3-рт: Газрыг шинээр олгохдоо архитектур орон зайн шийдлийг харгалзаж, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрмийг баримтлах

4-рт: Эзэмшил газрынхаа 10- аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгосон аж ахуйн нэгж байгууллага иргэдийн газрын төлбөрийг хөнгөлөх чөлөөлөх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх

5-рт: Газар эзэмшигч ашиглагч нь өөрийн мэдлийн үйлчилгээний барилга байгууламжийн өнгө үзэм, орчны газрын тохижилт үйлчилгээг хариуцах

6-рт: Бүсийн доторхи нийтийн эзэмшил газрыг нөхөн сэргээх, тохижуулахад шаардлагатай хөрөнгийг газрын төлбөрийн хэмжээтэй нь уялдуулан тогтоож, зүлэгжүүлэх, усжуулах арга хэмжээг орон нутгийн төр захиргааны байгууллага шийдвэрлэж, түүний бүрэн бүтэн байдлыг дэвсгэрийн байгууллагуудын газар эзэмшлийн гэрээнд тусган хариуцуулах

7-рт: Газар зохион байгуулалтын дагуу эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн нормлол зөрчсөн газар эзэмшигчдийг зохистой бүсэд нь нүүлгэн шилжүүлэх

**Захиргаа, албан газрын бүс:** Засаг даргын тамгын газар, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, мал эмнэлэг, соёлын төв, нийгмийн даатгал, халамжийн төв, цагдаагийн хэсэг зэрэг албан газрууд энэ бүсэд байршдаг ба орон нутгийн хотуудын хамгийн тохижилт, архитектур сайтай хэсэг гэж үзэж болно.

1970-аад оноос хойш ихэнхи төв суурингуудад хийгдсэн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө дагуу энэ хэсэг нь зохион байгуулагдсан бөгөөд Арвайхээр, Хархорин хотоос бусад суурингуудад нийтийн шугам сүлжээгүйгээр хөгжиж иржээ. Гэвч Хархорин хотын шугам сүлжээ сүүлийн жилүүдэд ашиглалтаас гарсан байна.

**Нийтийн зориулалттай орон сууцны бүс:** Захиргаа, албан газрын бүсийн орчимд хотын зэрэглэлээсээ шалтгаалан олон болон нам давхарын орон сууцнууд баригддаг бөгөөд сумын төвүүдийн 1-5 давхар орон сууцнуудыг энэ бүсэд хамруулав.

Албан байгууллага болон орон сууцны доторхи нийтийн эзэмшил газрын тохижилт туйлын хангалтгүй, зам талбайн засвар үйлчилгээ ихээхэн хоцрогдсон элсэнд дарагджээ. Орон сууц болон газар хувьчлагдсантай холбоотойгоор нам давхарын орон сууцны орчны газрыг хашаажуулж, түүнээс залгуулан гэр хороолол болгосон нь хотын газар нутгийн үүргийн бүсчлэлийг алдагдуулж байна.

Хүн амын нөхөн ба механик өсөлт, түүнтэй холбогдон гарах бүх төрлийн үйлчилгээ, Монгол Улсын Засгийн газрын 40000 орон сууц хөтөлбөрийн зорилт зэргийг харгалзан Арвайхээр болон бусад сумын төвийн барилгажилт /албан байгууллага, орон сууц/-анд шаардагдах газрын хэмжээг төлөвлөсөн. /Хүснэгт 29/

**Хүснэгт 29. Сумын төвүүдийн барилгажилтанд шаардагдах газрын хэмжээ /га-гаар/**

ДД	Сумын нэр	Барилгажилтанд шаардагдах газар		
		1-р шат	2-р шат	3-р шат
1	Арвайхээр	0.86	18.5	18.31
2	Хархорин	0.86	3.6	3.79
3	Сумын төвүүдэд	5.1	15.6	15.59

Захиргаа, албан газрын ба нийтийн орон сууцны бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой

газар ашиглалтыг бүрдүүлэх шаардлагын үүднээс дараахи асуудлыг шийдэх нь зүйтэй.

1-рт: Бүсийн доторхи барилга байгууламжуудийг архитектур орон зайн шийдэл оновчгүй голдуу бие биенээсээ салангид цэгчилсэн байршилтай байгаа нь хотын өнгө үзэмжид зохисгүй нөлөөлөөд зогсохгүй хотын дэд бүтцийг үр ашигтай ашиглахад ч сөргөөр нөлөөлж байна. Иймд шинээр олгох боломжгүй болсон жижиг орон зайнуудыг газар эзэмшигч ашиглагчдын эзэмшилд шилжүүлж тэдний хүч хөрөнгөөр тохижуулах

2-рт: Газрыг шинээр олгохдоо архитектур орон зайн шийдлийг харгалзаж, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрмийг баримтлах

3-рт: Эзэмшил газрынхаа 10- аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгосон байгууллага, аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг хөнгөлөх чөлөөлөх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх

4-рт: Давхар орон сууцны оршин суугчид, орон сууц өмчлөгчдийн холбоо нийтийн эзэмшил газрын ашиглалтанд хяналт тавих, уг газрыг тохижуулахад оролцох эрх зүйн орчинг бүрдүүлэх

5-рт: Газар эзэмшигч ашиглагч нь өөрийн мэдлийн барилга байгууламжийн өнгө үзэмж, орчны газрын тохижилт үйлчилгээг хариуцах

6-рт: Бүсийн доторхи нийтийн эзэмшил газрыг нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгохтой холбогдсон дэд бүтцийг бий болгох зардлыг /зүлэгжүүлэх, усжуулах, зам засвар/ орон нутгийн төр захиргааны байгууллага шийдвэрлэж, түүний бүрэн бүтэн байдлыг дэвсгэрийн байгууллага, оршин суугчдад хариуцуулах

7-рт: Энэ бүсэд хүн ба техникийн хөдөлгөөн ихт тул бүс доторхи замуудыг оновчтой төлөвлөх

8-рт: Байгалийн болон хиймэл ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 12м.кв хүртэл нэмэгдүүлэх шаардлагатай.

**Дэд бүтцийн бүс:** Энэ бүсэд эрчим хүчний дэд станц, дизель станц, өндөр хүчдэлийн шугам, холбооны шугам, тэдгээрийн хамгаалалтын бүсийг оруулсан бөгөөд, дэд станц, дизель станц, өндөр хүчдэлийн шугамын хамгаалалтын бүсийг “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн дагуу сумын төвүүдийн дэд станцын эргэн тойрон 10 метрийн өргөнтэйгээр тогтоосон.

Дээрхи хамгаалалтын бүсэд барилга байгууламж, орон сууц, хашаа байшин барихыг хориглодог бөгөөд одоогоор хамгаалалтын бүсэд орсон гэр хороолол болон албан газрын асуудлыг даруй шийдвэрлэж баталгаатай газар тогтвортой амьдрах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

**Замын хамгаалалтын бүс:** Энэ бүсэд зам болон түүний хамгаалалтын бүсийг оруулсан. Замын хамгаалалтын бүсийг “Авто замын тухай хууль”-ийн дагуу сумын төвийн замаас хоёр тийш 4 метр хүртэл өргөнтэйгээр тогтосон. Зуунмод хот болон Баянцагаан сумын төвөөс бусад суурингууд нь замын сүлжээ бараг байхгүй бөгөөд оршин суугчид дураараа замбараагүй явсанаас ихэнх сумдын төвийн газар нь эвдрэлд оржээ. Бүх сумдуудад шинээр замын сүлжээ төлөвлөсөн бөгөөд сумын төвийн замыг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм”-ийн дагуу 6 метрийн өргөнтэйгээр болон замын хамгаалалтын бүсийг 4 метрийн өргөнтэйгээр төлөвлөсөн. Цаашид төлөвлөсөн зам болон түүний

хамгаалалтын бүсийн дагуу газар ашиглалтыг бүсийн зориулалтын дагуу ашиглуулах шаардлагатай.

**Голын усны хамгаалалтын бүс:** Голын сав газар нь орчныхоо газруудаас ландшафтын тогтоцоороо эрс ялгаатай бөгөөд хүн болон амьтдын амьдрах орчныг байнга тэтгэж, байгалийн нөхөн сэргэх чадвар сайтай байдгаараа онцлогтой. Голын сав газрын хөрсөн бүрхэвч нь тал хөндийн хөрсийг бодвол эмзэг, хөрсний усны түвшин харьцангуй дээр, хөрсний гүнд их хэмжээний чулуулаг биетүүд хуримтлагдснаас гадаргын ус хялбар нэвшин хөрсний гүний усанд хүрдэг. Экологийн энэ байдлыг харгалзан голын хөндийн газар ашиглалтыг нарийн горимлах шаардлагатай юм. Тус аймгийн хэмжээнд хүн ам суурьшсан Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Баянгол, Тарагт сумдын төвөөр Орхон, Цагаан, Хужирт, Онги, Хүрэмт, зэрэг голууд урсан өнгөрдөг ба эдгээр голын хөндийд “Усны тухай хууль”, “Газрын нэгдмэл сангийн тайлан хөтлөх журам”-ын баримтлан голын эргээс хоёр тийш 50 метрийн өргөнтэйгээр голын усны хамгаалалтын бүсийг тогтоов.

Газрын менежментийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах шаардлагын үүднээс энэ бүсэд гэр хорооллын болон аж ахуйн зориулалтаар газар ашиглахыг хориглох ба зөвхөн дулааны улиралд уламжлалт аргаар малын бэлчээрт ашиглахыг зөвшөөрнө.

Газар ашиглалтын одоогийн байдлаас харвал голын усны хамгаалалтын бүсэд нилээд тооны айл өрх, албан газруудыг суурьшсан байгааг зориулалтын бүсэд даруй нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах.

**Амралт сувиллын бүс :** Энэ бүс нь Хужирт сумын төвийн зүүн хойд хэсгээр ялгаран гарсан бөгөөд рашаан сувиллын газруудын нийт 20.42га талбайг хамруулсан. Энэ бүсийг ариун цэвэр, эрүүл ахуйн үүднээс хамгаалах зорилгоор баруун тийшээ Хужирт гол, урагшаа авто замаар, зүүн тийшээ 100 метр зурвас газраар хязгаарлан хамгаалалтын бүс гаргаж, бусад зориулалтаар ашиглахгүйгээр нөөцлөн үлдээх шаардлагатай.

**Үйлдвэржилтийн бүс:** Энэ бүс нь аль болох суурьшсан хэсгээс зайдуу салхины доод талд, голын ус, болон техникийн аюулгүй бүсэд байршуулах зарчмыг баримталсан бөгөөд хот тосгодын өнөөгийн ба хэтийн хөгжлийн төлөвөөс шалтгаан бүсчлэн тогтоох шаардлагагүй юм. Одоогийн байдлаар хөдөөгийн тосгодын үйлдвэрийн газрын тоонд шатахуун түгээх станц, томоохон уурын зуух, хөнгөн болон хүнсний үйлдвэрийн газрууд багтаж байгаа бөгөөд хүнд үйлдвэрлэлтэй сумд байхгүй байна. Хархорин, Арвайхээр суманд цөөн тооны хөнгөн үйлдвэр хөгжжээ.

**Түүх соёлын дурсгалыг хамгаалах бүс:** Энэ бүс нь түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалах зорилготой бөгөөд энд тухайн сумдад байгаа сүм хийдийн газар, хирэгсүүр, суварга бүхий газрууд орно. Энэ бүс нь Хархорин сумын төвд нилээд ач холбогдолтой бүс бөгөөд Эрдэнэзуу хийдийг дэлхийн өвд бүртгэгдсэнтэй холбоотойгоор түүх соёлын дурсгалыг хамгаалах бүсийг урагшаа болон зүүн тийш төв зам, баруун тийш барилгажсан хэсэг, хойд зүг рүү суурьшлийн бүсийн хил хүртэл өргөтгөн тэлэх боломжтойгоор төлөвлөлөө. Мөн Хархорин сумын төвд Архангай явдаг төв замаас хойш 27.39 га газрыг Их хаадын цогцолбор барихтай холбогдуулан уг бүсэд оруулан төлөвлөв.

**Аялал жуулчлалын бүс:** Хархорин сумын тодорхой хэсэг нь энэ бүсэд хамрагдах ба энэ бүсийн ихэнх хэсэг нь Орхон голын усны хамгаалалтын бүсэд багтаж байна. Одоогийн байдлаар нилээд хэдэн жуулчны баазуудын эдэлбэр газар голын усны хамгаалалтын бүсэд орсныг чөлөөлөх шаардлагатай бөгөөд экологийн хувьд ашиглалтын нарийн дэглэм тогтоож хөрс усны бохирдлоос хамгаалах, хатуу хог хаягдлын менежментийг сайжруулж экологийн хариуцлагын гэрээний нөхцлөөр ашиглуулах нь зүйтэй. Мөн Хархорин сумын төвийн Их хаадын цогцолбор байгуулах талбайн баруун талд 24.2га талбайг аялал жуулчлалын төв болгон уг бүсэд оруулан төлөвлөсөн.

**Хориглон-хязгаарласан буюу тусгай дэглэмийн бүс** нь хорио цээр, аюулгүй байдалтай холбоотой газруудыг хамрах бөгөөд тус аймгийн хувьд Хархорин сумын хорих ангийн эдэлбэр газар багтана.

**Ногооны газрын бүс:** Энэ бүсэд Бат-Өлзий сумын төвийн зүүн урд хэсэгт байгаа ногооны талбайг оруулсан ба тус бүсийн зарим хэсэг голын хамгаалалтын бүсэд байрласан байгаа тул голын эрэг эвдрэх, голын усыг бохирдохоос сэргийлж цаашид ашиглалтаас чөлөөлж, голын усны хамгаалалтын бүсийн гадна уг зориулалтын дагуу ашиглуулах шаардлагатай.

**Тусгай хэрэгцээний газар:** Хот суурингийн эдэлбэрт байгаа цаг уурын ажиглалтын талбай энэ ангилалд хамрагдаж байна.

**Худгийн эрүүл ахуйн бүс:** “Хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийн дагуу гүний худгийн эргэн тойрон 50 метрийн өргөнтэйгээр эрүүл ахуйн бүс татаж одоогийн суурьшлаас чөлөөлөхөөр тусгалаа.

Худгийн эрүүл ахуйн бүсэд дараахь үйл ажиллагааг явуулахыг хориглоно.  
Үүнд:

- Газрын өнгөн хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах
- Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих
- Шатахуун түгээх цэг, автозасварын газар байгуулах
- Хог хаягдал хаях, бохир усны цооног ухах, малын хашаа саравч барих, усалгаатай тариалан эрхлэх

**Үерийн хамгаалалтын бүс:** Арвайхээр суманд үерийн хамгаалалтын далангийн дагуу 100 метрийн өргөнтэйгээр тогтоосон. Энэ бүсэд орсон айл өрхийг тус бүсээс нүүлгэн шилжүүлж цаашид барилгажуулахдаа энэхүү нормыг нарийн баримтлан газар олгох нь зүйтэй.

## 2.2. Хот өргөжин тэлэх бүс

Өвөрхангай аймгийн хувьд одоо байгаа хотжсон газрууд нь газар ашиглалтын нягтралын хувьд сийрэгдүү, барилгын давхаржилт бага бөгөөд цаашид хотыг гадагш тэлэх биш одоо байгаа суурьшлыг нягтруулах байдлаар газрыг зохион байгуулах шаардлагатай юм. Арвайхээр хот болон Хархорин

хотуудад гэр хороолол харьцангуй цэгцтэй суурьшсан боловч зарим хэсэгт төлөвлөлтгүй эмх цэгцгүй суурьшсан байдал ажиглагдаж байна. Суурьшсан хэсгийн функциональ бүсийн байдлаас харахад газар ашиглалтын бүсүүд нь эмх цэгцтэй биш ялгарсан нь цаашид уг хотуудад газар ашиглалтын бодлогод хотын функциональ бүсүүдийг баримталж, оновчтой төлөвлөх, газар ашиглалтыг сайжруулахын тулд барилгын давхаржилт болон амины орон сууцны бүсийн нягтралыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Дээрх томоохон хотуудын хувьд Арвайхээр хот нь тэлэх газар хомс, ус, уулаар хашигдсан, боломжит газар нь өөрийн сумын хилээс давж, Тарагт сумын хилд орсон байдгаас хот тэлэх газар нь хомс юм.

Хүн амын төвлөрөл, бодит өсөлт, хот байгуулалтын ажлын үр ашгийг сайжруулах үүднээс одоогийн байгаа онгоцны буудлыг Арвайхээрийн талд нүүлгэн шилжүүлж, энэ орчмын 1476.42 орчим га газрыг хот тэлэх бүс болгохоор төлөвлөсөн болно.

Хархорин сумын хувьд хот тэлэх нөөц газартай боловч энэ газар нь Дэлхийн шим мандлын өвд орсон, мөн түүх соёлын дурсгал, олдвор ихтэй, мөн тариалангийн бүс байдаг тул тэлэх боломжгүй болсон. Иймээс одоогийн ашиглалтыг нягтруулах замаар хот төлөвлөх нь тохиромжтой юм. Бусад сумын төвүүд нь мөн адил газар ашиглалтын нягтралыг сайжруулж, одоогийн суурьшсан хэсэгт оновчтой газар зохион байгуулалт хийх шаардлагатай.

Хот өргөжин тэлэх бүсэд жишиг Хархорин хотын 3443.8 га газрыг хамруулсан бөгөөд энэ газар нь одоогоор харьцангуй байгалийн унаган төрхөөрөө байгаа газар юм. Баруун талаараа нилээд өндөрлөг бөгөөд зүүн хэсгээрээ Орхон голын хөндийг дамнасан байрлалтай байна. Хот байгуулалтын үүднээс ландшафтын хувьд тохиромжтой боловч голын хөрстэй эмзэг газруудад хөрс ба гүний усны бохирдлоос сэргийлж нэгдсэн шцгам сүлжээний асуудлыг найдвартай шийдэх шаардлагатай. Хөрсний физик элэгдлийг багасгаж хотын агаарын орчныг хамгаалахад хотын доторхи замын трассыг зөв зохион байгуулах, замыг хатуу хучилттай хийж хамгаалалтын зурвасыг ногоон байгууламжтай болгох, хотын нийтийн эзэмшил газрын зам талбайг тохижуулах, зүлэгжүүлэх, моджуулах асуудлыг барилгажилтын явцтай нэг мөр шийдэхээр газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд тусгуулан хэрэгжүүлбэл зохистой.

Шинээр суурьших газар нь хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй, нимгэн ялзмагийн давхаргатай хөрс бүхий хойшоо задгайрсан дундаж ба нам уулс хоорондын хөндий бөгөөд орон нутгийн салхины зонхилох чиглэлийн цохилтын дор байршиж байгаа нь хот байгуулалтанд харгалзах гол нөхцлүүдийн нэг болно.

### **5.3. Зам, шугам сүлжээ, ой, усан сан, уурхайн газрын менежмент**

#### **5.3.1.Зам, шугам сүлжээний газрын менежмент**

Газар зохион байгуулалтын дагуу зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газруудыг хамруулдаг бөгөөд тэдгээрийн үйлдвэрлэлийн технологийн онцлогийг харгалзан олгосон



дэвсгэр болон зурвас газраас гадна хүрээлэн буй орчны таагүй нөлөөллөөс хамгаалахад зориулсан хамгаалалтын зурвасыг ч энэ ангилалд хамруулах шаардлага гардаг. Эдгээр хамгаалалтын зурвас нь тус тусын ангилал, зориулалтын газарт өөр байдаг ба түүн дээр зориулалтын бус үйл ажиллагаа явуулахыг бүрмөсөн хориглодог онцлогтой. /Зураг 26/

**Замын газрыг** төлөвлөхдөө нийслэлийг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүдийг өөр хооронд нь холбодог замд 100 метрээр, засаг захиргааны нэг нэгжийн хүрээнд орших хот тосгон, суурин газрыг холбосон орон нутгийн чанартай замын дагуу 60 метр өргөнтэй газрыг замын байгууламжуудыг байршуулах, засварлах, арчилгаа тордолгоо хийхэд зориулан замын хамгаалалтын бүсийг тогтоодог.

Газрын нэгдмэл сангийн тайлангаас харвал тус аймагт авто замын газар 6343.2 га, шугам сүлжээний газар 3123.9 га, агаарын тээврийн буудлын газар 320.0 га, ус дамжуулах болон үерийн хамгаалалтын далан 355.7 га нийт 10142.8 га зам шугам сүлжээний газар байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд одоо байгаа болон цаашид улс, орон нутгийн байгууллагын бодлого, чиглэл, хөтөлбөр, төслийн хүрээнд төлөвлөгдөж буй авто болон төмөр зам, түүнд шаардагдах газрын хэмжээг тооцож гаргав.

#### Хүснэгт 30. Автозамын газрын хэмжээ

Д/д	Замын төрөл ба чиглэл	Одоо байгаа зам		Төлөвлөж буй зам	
		Замын урт /км/	Эзлэх газрын хэмжээ /га/	Замын урт /км/	Шаардлагатай газрын хэмжээ /га/
1	Улсын чанартай авто зам	340.34	6343.2		
2	Орон нутгийн чанартай зам	3238.79	4858.2		
3	Хээрийн зам	15138.50	12598.1		
4	Хархорин-Арвайхээр-Өмнөговийн чиглэлийн авто зам			413.27	1528.7
5	Нарийнтээл-Баянхонгорын чиглэлийн авто зам			18.24	182.3
6	Сайхан-Овоо-Баянтээг-Баянхонгорын чиглэлийн төмөр зам			217.6	2611.2
7	Баянтээг-Гурвантэсийн чиглэлийн төмөр зам			214.3	2571.6

	19562.82	19167.27	863.41	6893.8
--	----------	----------	--------	--------

Өвөрхангай аймаг нь “Мянганы зам”-ын Улаанбаатар хотыг баруун аймгуудтай холбосон хэвтээ тэнхлэгт холбогдсон бөгөөд энэ зам тус аймгийн Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Арвайхээр, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл зэрэг сумдыг дайран өнгөрнө.

Харин босоо тэнхлэгийн зам нь Хархориноос Хужирт, Зүүнбаян-Улаан, Арвайхээр, Тарагт, Гучин-Ус, Богд сумаар дайран Өмнөговь аймгийн нутагт орно. Босоо тэнхлэг нь тус аймгийн нутгаар 413.3 км замыг туулах юм.

Улсын чанартай замын хамгаалалтын зурваст нийт 1711.0 га газар төлөвлөгдсөн бөгөөд энэ бүсэд замыг эвдэж гэмтээхгүй байх, замын хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, тухайн зурвас газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэд нь замын дагуух сул элсийг бэхжүүлэх, хөрсийг хамгаалах, мод бут өвслөг ургамлыг хадгалан хамгаалах, эвдрэлийн үйл явцыг зогсоох арга хэмжээ авах, зурвас дотор хог хаягдал хаях, овоолох, бохир ус зайлуулах төхөөрөмж байрлуулах, худалдаа үйлчилгээ эрхлэхийг хориглох зэрэг ашиглалтын горимыг баримтална.

Хангайн бүсэд барихаар төлөвлөж буй 922 км төмөр замын Өвөрхангай аймгаар дайран өнгөрөхөөр тусгагдсан бөгөөд тус төлөвлөлтөөр нийт 431.9 км зам дайран өнгөрөх боломжтой байна.

Түлш, эрчим хүчний яамнаас авсан мэдээлэл болон Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу төлөвлөлтийн хугацаанд Арвайхээр-Баянхонгорыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг байгуулах ба Баянтээг-Баянхонгор хүртэл 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, мөн Баянтээг-Баруунбаян-Улаан-Богд хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг тус тус барихаар төлөвлөгдсөн. Тус аймгийн нутагт байгаа нийт цахилгаан дамжуулах шугамын урт болон төлөвлөж буй цахилгаан дамжуулах шугамын урт дараах байдалтай байна. /Хүснэгт 31/

### Хүснэгт 31. Цахилгаан, холбооны дамжуулах шугамд шаардагдах газрын хэмжээ

Д/д	Эрчим хүчний ба холбооны шугамын ангилал	Одоо байгаа шугам		Төлөвлөж буй шугам	
		Урт /км/	Эзлэх газрын хэмжээ /га/	Урт /км/	Шаардагдах газар /га/
1	110 кВ-ын шугам	254.9	569.6	112.5	450.3
2	15 кВ-ын шугам	221.05	442.1		
3	35 кВ-ын шугам	371.48	1114.4	144.8	434.4
4	220 кВ-ын шугам			159.7	1756.8
5	Харилцаа холбооны шугам	987.4			1184.97
6	Нийт дүн	1722.33	2126.1	304.5	3826.47

Эрчим хүчний шугам сүлжээний зурвасын өргөн нь цахилгаан дамжуулах шугамын хүчдлийн хэмжээнээс хамаарах бөгөөд 20 кВ хүртэлх хүчдэлтэй шугамын дагуу 20 метр, 35 кВ-ын шугамын дагуу 30 метр, 110 кВ-ын шугамын дагуу 40 метр, 220 кВ-ын шугамын дагуу 110 метр өргөнтэй хамгаалалтын зурвас тогтоох ба энэ хэмжээг хот суурины дотор 14-28 метр хүртэл багасган төлөвлөдөг. Өвөрхангай аймгийн хувьд зарим сумд руу 15 кВ-ын шугам татсан бол ихэнх сумдад 35 кВ-ын шугам тавьсан ба цаашид томоохон төв суурин газруудад 110 кВ-ын шугам, Баянтээгээс Баянхонгор аймаг хүртэл 220 кВ-ын шугам татахаар төлөвлөжээ. Иймээс цахилгаан дамжуулах шугамуудын хамгаалалтын зурвас газарт зориулан нийт 2641.5 га талбайг бэлчээрээс тус ангиллын газарт оруулахаар төлөвлөсөн.

Харилцаа холбооны шугам сүлжээний хамгаалалтын зурвасын хувьд баганат шугам бол 10 метр, кабелийн шугам бол 5 метр, хүлээн авах станцын орчимд 300 метр голчтой байна. Энэ холбооны шугамын хамгаалалтын зурвас 1184.97 га талбай байхаар тус төлөвлөгөөнд тусгагдлаа.

#### 5.4.Ой ба усан сангийн газрын менежмент

Газрын тухай хуулийн дагуу ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас болон ойг өсгөн үржүүлэхэд зориулсан газар, мөн ой тэлэн ургах боломжийг хангахуйц ойн захын тодорхой хэсгийг хамуулдаг газрын нэгдмэл сангийн тайлангаар тус аймагт нийт 192277.5 га ойн сангийн газар байгаагийн 149991.7 га нь ой бүхий газарт, 42285.8 га ой тэлж ургах газар хамрагдана.

Ой болон усны ашиглалт хамгаалалтын асуудал нь Ойн тухай болон Усны тухай хуулиар зохицуулагдаж, хайгуул судалгааны өөрийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэл бүхий арга зүй, зохион байгуулалтыг шаарддаг. Гэвч газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд ой болон усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд шаардлагатай хамгаалалтын бүсийг тогтоож ашиглалтын горимыг тогтоох шаардлагатай байдаг. Мөн түүнчлэн ой болон усыг хамгаалах зорилго бүхий тогтоогдсон дотоод бүсчлэлийг зураглаж ерөнхий төлөвлөгөөнд тусгасан болно.

Өвөрхангай аймгийн ойн сан нь үндсэндээ Хангайн нурууны БЦГ болон Хөгнө-Тарна, Батхаан БНГ, Хүйсийн найман ДГ зэрэг улсын тусгай хамгаалалттай газруудад хамрагддаг бөгөөд эдгээрийн ойн ашиглалт-хамгаалалтын бүсийн ангиллыг хүснэгт 32, зураг 27-д харуулав.

#### Хүснэгт 32. Ойн ашиглалт-хамгаалалтын ангилал

Ашиглалт-хамгаалалтын бүсийн ангилал	Бүрэлдэхүүнд багтах газар	Талбай	
		га	хувь
Онцгой бүсийн ой	Хангайн нурууны БЦГ-ын онцгой бүсийн ой	14759.69	7.7
Хамгаалалтын бүсийн ой	Хангайн нурууны БЦГ-ын аялал жуулчлалын бүсийн ой	58622.34	30.5

	Хангайн нурууны БЦГ-ын хязгаарлалтын бүсийн ой	1167.94	0.6
	Хөгнө-Тарна болон Батхаан БНГ-ын ой	990.48	0.5
	Хүйсийн найман нуур ДГ-ын ой	3488.77	1.8
	Хориотой зурвасын ой	46354.3	24.1
Ашиглалтын бүсийн ой		24608.45	12.8
Бусад газрын ой		42285.80	22.0

Нийт ойн сангийн газрын 7.7 хувь нь онцгой бүсийн ой, 57.5 хувь хамгаалалтын бүсийн ой, 12.8 хувь нь ашиглалтын бүсийн ой, 22.0 хувь бусад газрын ой эзэлж байна.

Хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор Бат-Өлзий сумын нутагт Орхон голын эх орчмын газруудад ойн хориотой бүсийг тогтоосон бөгөөд түүний төлөвлөлтийг гол горхины эх, нуурын эргэн тойронд 5 км-ээс дотогш, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу, булаг шандын тархины эргэн тойрны 3 км доторхи газрыг хамруулсан ба үүнд нийт 348135.0 га газар хамрагдаж байна.

Ойн нөхөн төлжилтийг хангах ойн захаас 100 метр хүртэлх зай болон ойн цоорхойд даацаас хэтэрсэн мал бэлчээх, сэлгээгүй хадлан бэлтгэх зэргээр ой мод байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг алдагдуулахгүй байх, ашиглалтын явцад зохистой хэмжээний төлбөр ногдуулах арга хэмжээ авбал зохино. Ойн хөнөөлт шавьж хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх зэрэг нийтлэг арга хэмжээ авахаас гадна ойн ашиглалт хамгаалалтын бүсүүдэд ашиглалтын горимыг доорхи байдлаар тогтооно.

**Онцгой бүсийн ойд** газар болоод байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авахаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**Хамгаалалтын бүсийн ойд** тусгай хамгаалалттай газрын ангилал болон усны эхийг хамгаалах хориотой зурвасын ойн ашиглалтын горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулна.

**Ашиглалтын бүсийн ойд** ойн зохион байгуулалтын судалгаа зураг төслөөр зөвшөөрөгдсөн хэмжээнд хэрэглээний мод бэлдэх боломжтой бөгөөд ойн бусад бүсүүдэд модыг хэрэглээний зориулалтаар мод бэлтгэхийг хориглоно. Үүнд орон нутгийн захиргааны зохицуулалт онцгой ач холбогдолтой юм.

**Бусад газрын ойд** ойн тарьц суулгац үржүүлгийн газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн талбай, ойн захаас 100 метр хүртэл өргөнтэй өвслөг ургамалт зурвас тус орно.

### 5.3.3. Усан сангийн газрын менежмент

Хуулийн дагуу усан сан бүхий газарт гадаргуугийн усны эзэлж байгаа газар, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /усны хөвөө/ зурвас газар багтдаг.

Харин олон улсын жишгээр бол нуур, гол горхины эргийн дагуу 50 метр өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойрны 100 метр өргөн зурвас газрыг усны эрэг орчмын бүс гэж зарлан түүн дээр усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавьдаг. Мөн энэ зурваст газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулах зэргээс аль болохоор зайлсхийдэг.

Өвөрхангай аймгийн нийт голуудын урт 2789.0 км, усан сан бүхий газрын нийт талбай 3318.3 га байна. Усан сан бүхий газрын ашиглалт хамгаалалтыг зохицуулах үндсэн 2 бүсийг төлөвлөв. Үүнд:

### **5.3.3.1. Усны эрэг орчмын бүс**

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийн усзүйн сүлжээ нутгийн хойт хэсэгт нилээд сайн хөгжжээ. Сүүлийн үеийн байгаль-цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөнөөс томоохон голуудын цутгалуудын байнгын урсгал татарч, хур тунадас ихтэй жил, эсвэл хавар шар усны үеэр устай болдог болжээ.

Голуудын усны эрэг орчмын бүсийг 50 метрээр татсан бөгөөд энэ нь нийт талбай 6162.2 га газрыг эзэлнэ. Энэ бүсэд усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаа болон энэ зурвас газарт газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх зэрэг үйл ажиллагаа явуулахгүй байх шаардлагатай. Усны түвшинг хэвийн байлгах, эх үүсвэрийг хамгаалахын тулд голын эх, булагны тархи, ойг хамгаалж, модны нягтширлыг 2-2.5 дахин өтгөрүүлэх арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлнэ.

### **5.3.3.2. Усны эрүүл ахуйн бүс:**

Усан сан бүхий газрын менежментэд баримтлах гол бүсийн нэг нь усны эрүүл ахуйн бүсийг тогтоох явдал бөгөөд гол горхи, булаг шанд, худаг, усан сан нь усан хангамжийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж байгаа бол тэдгээрт 100 метрээс доошгүй өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтоодог.

Тус аймгийн гадаргын усан хангамжийн эх үүсвэрт Онгийн гол, Орхон гол, Таацын гол, Улиастайн гол, Өвтийн гол зэрэг нь голлох үүрэгтэй бөгөөд эдгээрийн усны эрүүл ахуйн бүсийг эргээс 100 метрийн зайд татлаа.

Усны эрүүл ахуйн бүсийн нийт талбай 58768.3 га бөгөөд ундны усан хангамжийн эх үүсвэр болдог гэдэг утгаар нь энэ бүсийг эрэг орчмын бүстэй нэг дэглэмээр ашиглаж хамгаалах нь зүйтэй.

### **5.3.3.3. Эрэг орчмын газрын ашиглалт, авах арга хэмжээ**

Барилга байгууламж, жуулчны бааз, хоноглох газар нуур, голын эргээс 100 метрээс гадна байрлавал зохих бөгөөд зоо мал эмнэлгийн ариутгал-боловсруулалтын цэг, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх газрыг усны хамгаалалтын бүсийн гадна, урсгалын доод хэсэгт байрлуулж хаягдал усыг тусгайлан цэвэрлэж зайлуулна.

Гол горхины эх, нуур, тойрмын эргэн тойронд 2км дотор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хуулиар хориглодог. Гол горхины эх,

нуурын эргэн тойрны 5 км доторхи, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу булаг шандын тархины эргэн тойрон 3 км доторхи хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор ойг хамгаална.

Энэ стандартын дагуу Орхон голын эх жижиг гол, булаг шандын эргэн тойрон байгаа ой бүхий газруудад хориотой зурвасыг тогтоосон болно

#### **5.3.4. Газрын хэвлий нөөцийн менежмент**

Газрын хэвлийг ашиглах нь эдийн засгийн хөгжилд зайлшгүй шаардлагатай боловч үүнээс байгаль орчин болон газарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг үйл ажиллагаа юм. /Зураг 30/

Одоогоор аймгийн хэмжээнд нийт 20 орчим ордын 8089.79 га ашиглалтын лиценз бүхий орд ашиглаж байгаагийн 9 нь алт(Au), 2 нь нүүрс, бусад нь барилгын материал болон зарим ховор чулууны ордууд байна. Аймгийн хэмжээнд 1662684.74 га талбай хайгуулын лицензтэй талбай бүртгэлтэй.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж буй бүс нутаг нь Уянга сумын Ар өлт, Буянт, Жаргалант, Нарийн, Цагаан голд, Тарагт сумын Хуурай сайрт, Бат-Өлзий сумын Их бургастай, Хонгилтод, зүүнбаян-Улаан суманд Өртөнт бөгөөд энд алтны уурхай ажиллаж байна. Харин Арвайхээр, Зүүнбаян-Улаан, Баян-Өндөр, Төгрөг зэрэг сумдад барилгын материал болон бусад ашигт малтмалыг олборлодог.

Баянтээгийн нүүрсний уурхайнууд дотроос хамгийн том нь бөгөөд өөрийн аймгийг төдийгүй хөрш зэргэлдээхи аймгуудыг чулуун нүүрсээр хангадаг.

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас авсан мэдээллээр тус аймгийн нутагт нөөц нь тодорсон 20-иод орд байгаа бөгөөд эдгээрийн 25 хувь нь алтны, 10 хувь нүүрсний, 65 хувь барилгын материал болон бусад ашигт малтмалын ордууд байна. Мөн 80 орчим ашигт малтмалын илрэлүүд тэмдэглэгдсний дотор алт ба нүүрсний илрэл тус бүр 8 байна. Одоо ашиглаж байгаа болон нөөц нь тогтоогдсон ордууд, илрэлүүдийг газрын байршлаар нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан бөгөөд аймаг болон бүс нутгийн хөгжлийн үе шаттай нь уялдуулан ашиглахдаа байгаль орчныг хамгаалах, газрыг нөхөн сэргээх асуудлыг газар эзэмших, ашиглах гэрээнд нарийн тусган хяналт тавих нь зүйтэй.

### **5.5. Тусгай хамгаалалттай газрын болон амралт, рашаан, аялал жуулчлал хөгжүүлэх газрын менежментийн бүсүүд**

#### **5.5.1.Тусгай хамгаалалттай газрын менежментийн бүс**

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар нутгийн тодорхой хэсгийг тусгай хамгаалалтанд авах нь газраар дамжуулан байгаль экологийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй юм. /Зураг 28/

**5.5.1.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн газрын менежмент**

Өвөрхангай аймагт Хангайн нурууны байгалийн цогцолборт газар болон Хөгнө-Тарна, Батхаан уулын байгалийн нөөц газар, Хүйсийн найман нуурын дурсгалт газрууд тус тус оршдог бөгөөд нийт нутгийн 5 хувь буюу 295906.0 га газрыг эзэлнэ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ болон дотоод бүсчлэлийн байдлыг дараах хүснэгтэд тусгалааа. /Хүснэгт 33/

**Хүснэгт 33. Улсын тусгай хамгаалалттай газрын хэмжээ ба бүсчлэл**

Д/д	Тусгай хамгаалалттай газрын нэр	Талбай /га/	Дотоод бүсчлэл		
			Онцгой бүс	Аялал жуулчлалын бүс	Хязгаарлалтын бүс
1	Хангайн нуруу БЦГ	249361	33101.52	36193.97	180065.83
2	Хөгнө-Тарна БНГ	26081.23			
3	Батхаан БНГ	8963.46			
4	Хүйсийн найман нуур Дуг	11500.00			
	Дүн	295906.0	33101.52	36193.97	180065.83

Өвөрхангай аймгийн нутагт Хангайн нурууны БЦГ-ын онцгой бүсийн “Б” хэсэг болон аялал жуулчлалын бүсийн “А” хэсэг, хязгаарлалтын бүсүүд орно.

Тус газрын аялал жуулчлалын бүсэд газар, байгаль, экологи, газраас хөдлөшгүй түүх соёлын өв, газар дэлхийн гарал үүсэл, бүрэлдэн тогтолтын мэдээлэл зэрэгт хохирол учруулалгүйгээр хуулиар зөвшөөрсөн зарим үйл ажиллагааг болзолт ашиглалтын хэлбэрээр явуулах бөгөөд хадгалах-ашиглах-хамгаалах ажиллагааг хослуулан явуулах нь зүйтэй юм.

Байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн газрын менежментийн онцлог нь уг газрыг нөөшлөх замаар байгалийн унаган ландшафтын төрх, хэв шинж, информативт чанарыг хадгалан үлдээхийн зэрэгцээ тэнд нутагшсан ургамал, амьтны аймаг болон биологийн бусад төрөл зүйлийн амьдрал жам ёсоороо үргэлжлэх орон зай, орчны чиг үүрэг, нөхцлийг хангах явдал болно. Энэ бүсэд байгалийн зүй тогтлыг танин мэдэхийн үүднээс байгалийн нөөц баялгийг хөндөхгүйгээр шинжлэх ухааны ажиглалт хийх, байгалийн гэнэтийн үзэгдлээс учирсан хохирол, ургамал, амьтны аймгийн амьдралын хэвийн нөхцөлд учирсан саад, бэрхшээлийг арилгахдаа зөвхөн байгальд ивээлтэй технологи, арга хэрэгсэлээр авч явуулах шаардлагатай.

Монгол Улсын байгаль орчны яам, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнээс Хархорин сумыг Дэлхийн өвд бүртгэсэнтэй болсонтой холбогдуулан Хангайн нурууны БЦГ газрыг тэлэх зорилгоор судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд хилийн цэсийг хэрхэн тэлэх талаар нэгдсэн шийдвэр гараагүй байна. Хархорин сумын нутгийн нилээд хэсгийг аймгийн тусгай хамгаалалтанд авсан байдаг бөгөөд энэ хилийн дагуу Хангайн нурууны БЦГ-ыг тэлэх боломжтой юм.

Байгалийн иж бүрдэл, биологи, түүхэн олдвор, геологийн онцлогийг харгалзан байгалийн нөөц болон байгалийн дурсгалт газруудыг төрөлжүүлэн ангилна. Энэ ангиудад горимын бүсүүдийг тогтоох шаардлагагүй бөгөөд байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэх замаар ашиглалтын дэглэм тогтооно.

Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх аливаа үйл ажиллагааг хориглоно.

Байгалийн дурсгалт газарт горимын бүсүүдийг баримтлахгүй боловч байгалийн болон түүх соёлын дурсгалын зүйлсээр нь төрөлжүүлж хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулах зэргээр хамгаалалтын арга хэмжээ авахаас гадна дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуиц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

#### **5.5.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн газрын менежмент**

Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хуулийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан дараах газруудыг авчээ. Үүнд:

1. Аргаль, угалз зэрэг ховор ан амьтныг хамгаалах зорилгоор Өшгөгийн нуруу-Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Гучин-Ус сумдын хил орчмын 191962.9 га газрыг
2. Түүх соёлын дурсгалыг хамгаалах зорилгоор Хархорин сумын нутагт 39733.61 га, Уянга сумын нутагт Баруун гол болон сумын төвийн орчмын 12899.67 га газрыг
3. Ашигт малтмалын нөөцийг хадгалан хамгаалах зоригор Богд, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Нарийн тээл, Гучин-Ус сумдын нутагт 2568820 га газрыг
4. Байгалийн үзэсгэлэнт тогтоцыг хадгалах зорилгоор Есөнзүйл сумын Зүүнхайрхан уул, Гучин-Ус сумын Монголын хоолой, Тарагт сумын нутагт Хүрэмтийн рашаан, Зүүнбаян-Улаан сумын Хүнгийн мухар, Хужирт сумын Битүүхэй зэрэг газрыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтанд авчээ.

Дээрх тусгай хамгаалалттай газруудын талбайг аймгаас авсан тус газруудын координатын дагуу оруулж тодорхойлсон талбай бөгөөд уг мэдээлэлд өгсөн талбайгаас нилээд зөрж байна.

Цаашид орон нутгийн буюу аймгийн тусгай хамгаалалтанд авах :  
**Түүх дурсгалын газрууд нь:**



1. Богд сумын Тэвш ууланд орших сүг зурагтай хад
2. Хархорин сумын нутагт орших Шанхын хийдийн дуганууд
3. Зүйл сумын Есөнзүйл гэдэг газар орших Өндөр гэгээн Занабазарын суварга
4. Хархорин сумын Мойлтын аманд орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
5. Хужирт сумын Шунхлай ууланд орших дөрвөлжин булшнууд
6. Уянга сумын нутагт орших 11 ширхэг хиргэсүүр
7. Хархорин сумын нутагт орших чулуун мэлхий
8. Уянга сумын нутагт орших Эльтрес хааны хөшөө, Онгийн хөшөө болон Баруунбаян-Улаан сумын Хүнхрээ гэдэг газар орших Шаазан толгойн туурь

**Байгалийн үзэсгэлэнт газрууд нь:**

1. Ховор ан амьтанг хамгаалар зорилгоор Есөнзүйл сумын Дөлгөөн уул /нийт 17534.8 га/, Богд сумын нутагт Говь-Алтайн нурууны салбар Арц Богдын нуруу /17624.4 га/, Гучин-Ус сумын Их аргалант уул /8791.1 га/
2. Байгалийн ховор нандин тогтоцыг хадгалах зорилгоор Баянгол сумын Улаан нуурын элс, Зүүнбаян-Улаан сумын Баянзүрх уул /нийт 483.88 га/
3. Байгалийн дурсгалыг хадгалан хамгаалах зорилгоор эртний амьтны чулуужсан яс бүхий Гучин-Ус сумын Гучингийн нурууны ар / 426.3 га./

Аймгийн тусгай хамгаалалттай газруудад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй шинжлэх ухааны ажиглалт, судалгаа явуулах, аялал зугаалга хийх, байгалийн болон түүх дурсгалыг хамгаалах арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг зөвшөөрөх бөгөөд зөвшөөрөлгүй аялал зугаалга хийх, газрын төлөв байдалд ноцтой нөлөөлөх технологиор ашигт малтмал олборлох, экологийн орчин болох агаар, ус, хөрсийг бохирдуулах, түүх соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Харин газрыг сумын тусгай хамгаалалтанд авах асуудал нь тухайн сумын засаг дарга болон иргэдийн хурлын мэдэлд байх бөгөөд хилийн цэс болон хамгаалалтын дэглэмийг иргэдийн хурлаар шийдвэрлэхэд сумдын газрын даамлын ажил үүрэгт хамрагдана.

Одоогийн байдлаар хэд хэдэн сумд газрыг сумын тусгай хамгаалалтанд авсан байдаг. Баян-Өндөр сум Дэлийн нуур, Хомоолын хоолой, Алтан овоо, Эхэн худаг, Баруун арал зэрэг газруудыг бэлчээр отрын нутгаар, Улаан чулууны нуур, Ботгоны нуур, Цайдамын нуур, Хашаатын нуур, Ар цагаан, Хулгар тойром зэрэг газруудыг давс хужиртай, Бэлгэхийн халуун ус, Навчитын халуун ус, Харзтайн гол, Бумбатын булаг, Харзтайн хадан худаг, Сондуултын гол зэргийг эмчилгээ сувилгаа, ундны ус бүхий газар гэж орон нутгийн хамгаалалтанд авсан байна.

### **5.5.1.3 Амралт, рашааны газрын бүс**

Тус аймгийн нутагт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Хужирт, Хүрэмтийн рашаануудаас гадна Эмт, Могойт, Үүртийн тохой, Гятрууны халуун рашаан, Хүрэн хадны рашаан, Хустын рашаан, Могойтын рашаан зэрэг рашаануудад нутгийн иргэд байнга ирж эмчилгээ сувилгаа хийж байна.

Эдгээр рашаанууд нь Монгол орны рашааны мужлалын хувьд азотын рашааны мужид орших бөгөөд эмчилгээний шавар нь шаварлаг-лагийн төрөлд багтдаг.

Монгол улсын рашааны каталогид орсон рашаануудын шинж чанарыг доорхи хүснэгтэд харуулав. /Хүснэгт 34/

### Хүснэгт 34. Өвөрхангай аймгийн рашаанууд

Д/д	Рашааны нэр	Солбицол		Температур °C	Анги, төрөл
		Х	У		
1	Хужиртын халуун рашаан	102° 56' 00"	46° 54' 00"		C <sup>Na</sup>
2	Орхонсайхан булгийн рашаан	102° 30' 00"	46° 56' 00"		
3	Могойтын халуун рашаан	102° 15' 00"	46° 45' 00"	67	C <sup>Na</sup>
4	Хамрын халуун рашаан	102° 08' 00"	46° 43' 00"	12	
5	Гятрууны халуун рашаан	102° 00' 00"	46° 36' 00"	50	C <sup>Na</sup>
6	Эмтийн халуун рашаан	102° 41' 00"	46° 26' 00"	52	
7	Хүрэмтийн халуун рашаан	102° 47' 00"	46° 16' 00"	58.8	C <sup>Na</sup>
8	Шаргын халуун рашаан	101° 40' 00"	45° 50' 36"	29	
9	Таацын халуун рашаан	101° 38' 00"	46° 07' 36"	65	Cl <sup>Na</sup>
10	Харзтайн рашаан	101° 38' 00"	45° 15' 00"	6.5	C <sup>Na</sup>
11	Таац Далан түрүү рашаан	101° 16' 00"	46° 21' 00"	2	
12	Хүрэн хадны рашаан	101° 40' 00"	44° 55' 00"	6	C <sup>Ca</sup>
13	Мойлтын рашаан	102° 46' 30"	47° 11' 00"	6	C <sup>Ca</sup>
14	Мөстийн рашаан	102° 47' 00"	46° 42' 30"	0.5	C <sup>Ca</sup>
15	Цагаан хадны рашаан	103° 29' 00"	46° 45' 00"	4.5	

C<sup>Ca</sup> –гидрокарбонат кальцийн ус

C<sup>Na</sup> –гидрокарбонат натрийн ус

Cl<sup>Na</sup> –хлорын ангийн натрийн ус

Рашааны чанар, найрлага ялангуяа ууссан хийнүүд, хувирамтгай нэгдлүүдийн найрлага амархан өөрчлөгддөг учраас үндсэн шинж чанарыг өөрчлөхгүй, бохирдуулахгүйн тулд тохижилтыг сайжруулж, ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай. Энэхүү бүсийн хэмжээ хязгаар, хэлбэрийг усны эх булаг болон хөрсөн дэх уст давхраа оршиж буй хэсгийн ариун цэврийн нөхцөл байдал, геологийн тогтоц, гидрогеологийн шинж, хөрсний бүтэц, газар доорхи усны урсгалын чиглэл, салхины зонхилох чиглэл, бохирдлын эх үүсвэр зэргийг харгалзан байгаль орчны мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг харгалзан мэргэжлийн байгууллага тогтоох бөгөөд ариун цэврийн хамгаалалтын бүсийг дараах хэмжээг баримтлан тогтооно.

Үүнд:

-Хатуу дэглэмтэй ариун цэврийн бүс 20-50 метр

-Эрүүл ахуйн бүс 100-150 метр

-Хамгаалалтын бүс 150-500 метр байхаар тооцно.

Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд дараах дэглэмийг баримтлана.

Үүнд:

- Байгалийн эмчилгээний хүчин зүйлийг ашиглахтай шууд холбоогүйгээр худаг гаргах, засварлах, рашаан түгээх, хадгалах систем, эмчилгээний шавар олборлох
- байр, бусад барилга байгууламж барих
- Хог хаягдлын болон бохир ус зайлуулах байгууламж байгуулах
- Химийн хорт бодис бусад бохирдуулах зүйлсийг ил задгай хадгалах, хаях
- Байгальд сөрөг нөлөөлөл үзүүлэх үйлдвэрлэл үйлчилгээ явуулах
- Газрын хөрсийг гэмтээх, эвдрэлд оруулах
- Рашааны эргэн тойрон дахь газраас хадлан өвс бэлтгэх, мал бэлчээх
- Мөнгө болон бусад хүнд металл, хог болох зүйлийг рашаан усанд хаях
- Аливаа бохирдол үүсэх шинж чанар бүхий эм, урвалж болон химийн бодисыг хадгалах, хэрэглэх
- Төрөл бүрийн бордоо хэрэглэх ногооны талбайг байршуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байршуулах
- Машин техник угаах газар, бохир усны нүх, бие засах газар барих гэх мэт үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Дээрх бүстэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа болон ашиглахаар төлөвлөж байгаа рашаан, сувиллын газруудад байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай.

Цаашид рашаануудыг хамгаалах зорилгоор тодорхой эзэмшилтэй болгож, нэгдсэн журмаар хүн хүлээн авдаг, хамгаалалтын бүсийн дэглэмтэй тогтоох нь зүйтэй юм.

Төлөвлөлтөөр аймгийн нутаг дэвсгэрт байгаа рашаануудыг түшиглэн амралтын газруудыг байршуулахаар төлөвлөсөн бөгөөд энд нийт 15 га газар төлөвлөгдсөн.

#### 5.5.1.4. Аялал жуулчлалын бааз, тэдгээрийн бүс

Өвөрхангай аймаг нь Монгол орны төв хэсэгт байрладаг бөгөөд газарзүйн байрлал болон байгалийн тогтоцын хувьд байгалийн аялал жуулчлал хөгжих боломжтой ба аялал жуулчлал нилээд хөгжсөн аймгийн нэг юм. Тус аймгийн тусгай хамгаалалттай газар Хангайн нурууны байгалийн цогоцлбор газрыг түшиглэн аялал жуулчлал түлхүү хөгжсөн бөгөөд энд гадаад дотоодын олон жуулчид ирдэг. Томоохон төвүүдийн нэг нь Хархорин сум юм. Одоогоор тус аймагт 18 жуулчны бааз үйл ажиллагааг явуулдаг бөгөөд эдгээрийн олонхи нь Хархорин, Бат-Өлзийн сумдын нутаг Орхон голын хөндийгөөр байрладаг. /Хүснэгт 35, зураг 28/

**Хүснэгт 35. Жуулчны баазуудын байршил, хүчин чадал**

№	Жуулчны баазын нэр	Хаяг	Хүчин чадал		Жуулчны баазын зэрэглэл	Үйлчлүүлсэн жуулчдын тоо	
			Гэр	Ор		Гадаад	Дотоод
		Байршил					

1	Баянговь	Бүрд сум Шилүүстэй гол	35	120	2 цэцэгтэй	2800	550
2	Хархорин тур	Хархорин сум Эрдэнэтолгой баг	11	44		600	250
3	Хубилай хаан	Хархорин сум Вангийн овоо	15	30		400	50
4	Номин	Хархорин сум Орхон голын зүүн эрэгт	7	25	1 цэцэгтэй	250	50
5	Өргөө	Хархорин сум Орхоны хөндий	40	112	2 цэцэгтэй	1600	460
6	Өгөөдэй	Хархорин сум Орхоны хөндий	18	56	1 цэцэгтэй	257	15
7	Хужирт	Хужирт сумын төвд	20	70	1 цэцэгтэй	300	20
8	Анар	Хархорин сум, Орхон голын боомт	39	100		3000	650
9	Мөнгөн мод	Хархорин Өлийн хөтөл	30	61		1200	140
10	Цэнгүүн хүрээ	Хархорин сум, Эрдэнэзуугийн дэргэд	8	35		400	54
11	Мөнгөн хүрхрээ	Бат-Өлзий, Орхоны хүрхрэний дэргэд	20	76		300	190
12	Тэнгэрийн хишиг	Бат-Өлзий Орхоны Бага хүрхрээд	10	20			150
13	Төвхөн трейд	Бат-Өлзий сум, Төвхөн хийд	6	24			140
14	Сангийн далай	Өлзийт сум 1-р баг	5	12			20
15	Хуст амралт	Бат-Өлзий Хуст рашаан	12	36			420
16	Хүрэмт	Тарагт 4-р баг	8	24			150
17	Хужирт амралт	Хужирт сумын төвд		300			3772
18	Сүүн далай трейвел	Бат-Өлзий		8			1750
	<b>Нийт</b>		<b>284</b>	<b>1153</b>		<b>11107</b>	<b>8831</b>

Аймгийн аялал жуулчлалын бодлогод баримталж буй одоогийн жуулчлалын зам нь Дэлхийн цутгамал урлагийн хаан монголын шашны тэргүүн их Богд өндөр гэгээн Занабазарын өлгий нутгаар болон Орхоны хөндий, Түүх дурсгал, мөргөл буян, Сайн ноён хан Намнансүрэнгийн төрсөн нутаг байгалийн үзэсгэлэнт түүх соёлын өлгий нутгаар, үзэсгэлэнт говь нутгаар гэх мэт маршрутаар явах бөгөөд дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Баянговь жуулчны баазаас 26 км явж Ширээт цагаан нуур хүрнэ.
- Ширээт цагаан нуураас 41 км явж, Хүйс буюу Монгол орны газар нутгийн төв цэг Өвөрхөшөөтөд газар байрладаг.
- Хүйсээс 72 км явж, Өндөр гэгээн Занабазарын төрсөн газар Өвгөн суваргад очно.
- Өвгөн суварга-Сангийн далай нуур хүртэл 52 км. Сангийн далай нуур усны шувууд олноор цуглардаг нууруудын нэг юм.
- Сангийн далай нуураас Шанхын хийд хүртэл 65.0 км. Монголын эртний нийслэлийн суурь.
- Шанхын хийд-Хужирт хүртэл 28.0 км бөгөөд Хужиртын халуун рашаанд орох боломжтой.
- Хужиртын рашаан-Үүртийн тохой хүртэл 30.6 км. Байгалийн үзэсгэлэнг үзэх, мөн Үүртийн тохойд байрлах рашаанд орох боломжтой.
- Үүртийн тохой-Хустын рашаан хүртэл 5.3 км. Байгалийн хүйтэн рашаануудын нэгийг үзнэ.

- Хустын рашаан-Төвхөн хийд хүртэл 21.5 км. Өндөр гэгээн Занабазарын байгуулсан түүний бүтээлийн сүмүүд байдаг.
- Төвхөн хийд-Улаан цутгалан хүртэл 39.9 км. Улаан гол Орхон гол нийлэх үед байдаг томоохон хүрхрэнүүдийн нэг юм.
- Улаан цутгалангаас Бага хүрхрээ болон Могойтын рашаанаар дайрч Хархорин суманд очно.

Мөн өөр нэг маршрут нь :

- Арвайхээр сумаас Хүрэмтийн халуун рашаан хүртэл 28 км явж Тарагт сумын төв орно.
- Тарагт сумаас Уянга сумын төвөөр дайрч Хүйсийн найман нуур хүрнэ.
- Мөн Тарагтаас 20 км явж Уянга сумын нутагт байх түрэгийн хөшөө дурсгалыг үзээд 17 км явж, Эльтрес хааны хааны хөшөө зэргийг үзэж болно.
- Уянга сумын төвд Онгийн хүрээний хийд, хадан хошууны номхон цагаан Уувшгай зэргийг үзнэ.
- Уувшгай-Шурангын цохио хүртэл 29.2 км явж, 33.7 км яваад Хүйсийн найман нуур хүрж буцаад Уянга суманд ирнэ.
- Уянга сумын төв-Жаргалант багийн төв хүртэл 51.7 км.
- Жаргалант-Нарийнтээл хүртэл 37.8 км.
- Нарийнтээл-Гарьдын хад 11.1 км. Байгалийн өвөрмөц тогтоцтой сэнжит хадтай.
- Гарьдын хад-Хайрхандулаан сумын төв хүртэл 23.9 км явж, Хайрхандулаан суманд байх сүсэг бишрэлтэй Уушгай хэмээх хад чулууг үзэж болно.
- Нарийнтээл-Баянтээгийн уурхай хүртэл 37.8 км.
- Баянтээгийн нүүрсний уурхай-Өшгөгийн нуруугаар дамжин Таацын цагаан нуур хүртэл 70.6 км. Нууруудын хөндийн нууруудын нэг Таацын цагаан нуурыг үзэх боломжтой. Мөн элсэн манхан харна.
- Таацын цагаан нуур-Гарьдын хад хүртэл 30.6 км явж, автомашины төв замд нийлнэ.
- Таацын цагаан нуур-Шаазан толгойн туурь хүртэл 56.5 км явж, түүх соёлын дурсгал үзэж болно.
- Шаазан толгойн туурь-Богд сумын төв хүртэл 44.0 км.
- Богд-Харганад хүртэл 69.1 км. Арц богдын нуруугаар дамжин Харганадын түр амрах замын буудалд буун цааш Өмнөговь аймгийн нутаг руу орно.
- Богд-Гучин Ус сумын төв хүртэл 90.2 км.
- Гучин-Ус-Арвайхээр хүртэл 75.2 км явж аймгийн төвд хүрнэ.
- Богд-Хонгорын тал хүртэл 116.5 км.
- Хонгорын тал-Төгрөг сумын төв хүртэл 63.7 км.
- Төгрөг-Арвайхээр хүртэл 90.3 км явахдаа говь нутагт тариалалт хийж байгаа Мазарын услалтын систем болон тариаланг сонирхож болно.
- Төгрөг-Баянгол сумын төв хүртэл 48.8 км.
- Баянгол-Арвайхээр хүртэл 76.0 км.
- Арвайхээр-Эмтийн рашаан хүртэл 23.7 км. Эмтийн халуун рашаан орж болно.
- Эмтийн халуун рашаан-Зүүнбаян-Улаан сумын төв хүртэл 11.2 км.
- Зүүнбаян-Улаан-Хужиртын халуун рашаан хүртэл 56.6 км явах замууд орно.

Дээрх маршрутын дагуу Өвгөн хийд, Ногоон нуур, Ширээт нуурын хөвөө, Шуранганы цохио, Дулаан богд уул, Хүрэн хад, Нугын элс, Таацын цагаан нуур зэрэг газруудад жуулчны бааз болон түр амрах байруудыг төлөвлөсөн.

Зам тээвэр, аялал жуулчлалын яам Өвөрхангай аймгийн Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга сумын нутаг болон Орхон голын хөндийд аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх бодлого баримталж байна.

Өвөрхангай аймаг нь Улаанбаатар хотыг баруун аймгуудтай холбосон “Мянганы зам”-ын тэнхлэгт байрладаг, хар замаар нийслэлтэй холбогдсон, эрчим хүчний нэгдсэн системд ихэнх сумын төвүүд холбогдсон, говь, хангай, тал хээр хосолсон, ургамал, ан амьтан элбэгтэй, чийг дулааны хангамж тэнцвэртэй байдаг зэрэг давуу талууддаа түшиглэн Орхон, Онги зэрэг голууд, Сангийн далай, Таацын цагаан нуур, Найман нуур зэрэг газруудад усан болон агнуурын спортыг хөгжүүлэх боломжтой.

Хангайн нуруу, Гятрууны нуруу, Өшгөгийн нуруу, Орхон, Онги, Хан хөгшин, Богдын нуруу зэрэг байгалийн өвөрмөц тогтоцтой, Хархорум, Шанх, Эрдэнэ зуу, Төвхөн, Хар балгас, Эльтрес хааны цогцолбор зэрэг түүх соёлын дурсгал элбэгтэй зэрэг нь аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

## ЗУРГАА. ГАЗРЫН ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

### 6.1. Газрын экологийн чадавхи, түүний үнэлгээ

Газрын нөхцөл, нөөц, төлөв байдал, чанар нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд түүний хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс ба ургамлан бүрхэвч, амьтны аймаг зэрэг байгалийн хам бүрдэл хүчин зүйлсээс хамаарах учраас тодорхой орон зайн хүрээнд ижил төстэй байдлаар нэгтгэн ангилж, газрын менежментийн бодлогыг тодорхойлох нь илүү үр дүнтэй байдаг.

Иймээс тус аймгийн газрын экологийн чадавхийг газрыг геоэкологийн ижил төстэй нөхцлөөр нь нэгтгэсэн ландшафт-типологийн зарчимд тулгуурлах ангилж, ашиглалтыг чиглэлийг горимыг тогтоов. /Хүснэгт 36, зураг 29/

### Хүснэгт 36. Өвөрхангай аймгийн газрын ангилгаа

Зураг дээрх индекс	Газрын ангилал	Ландшафтын ерөнхий тодорхойлолт	Эзлэх талбай /га/	Ашиглалтын үндсэн чиглэл
11	Өндөр уул-уул дотоодын хавцал маягийн	Уулын тундрын ширэгт ба ширэгт-ялзмагт, глейрхэг, хүлэрлэг хөрст хаг хөвдөт өндөр уулын царам	6535.5	Экологийн байдлыг алдагдуулалгүй хадгалан хамгаалах, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглана.

12	хөндийн нуга ба хээр	Уулын нугын хүлрэнцэр ялзмагт болон нугын хар шороорхуу хөрстэй өвслөг болон сөөгт ургамалтай өндөр уулын орой, өмнөд хажуу налуу	62735.7	Экологийн байдлыг алдагдуулалгүй хадгалан хамгаалах, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглана.
13		Өндөр уулын нугат хээрийн бүдүүн ялзмагт болон уулын хүрэн ба уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрст өвслөг ургамалтай өндөр уулын таг, налуу хажуу	133683.1	Экологийн байдлыг алдагдуулалгүй уламжлал аргаар дулааны улиралд МАН-д ашиглах
14		Цэвдэгт нуга-намгийн ялзмагт хөрстэй, голдуу өвслөг ургамалтай, /заримдаа сөөг оролцсон/ өндөр уул хоорондын нарийн ам хөндий	19249.1	Экологийн байдлыг алдагдуулалгүй уламжлал аргаар дулааны улиралд МАН-д ашиглах, гар аргаар хадлан бэлтгэх
21		Уулын тайгын цэвдэгт ба ширэгт хар бараан ба хар шороон маягийн хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай дундаж ба нам уулын ар өвөр хажуу налуу, хормой	273297.9	Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамал зэрэгт мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах
22	Ойт хээрийн дундаж ба нам уулс- уулсдотооды н нугачаат хөндий	Уулын хар хүрэн ба сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой дээд налуу хажуу	170237.7	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглагдана. Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэхдээ мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах
23		Нугын гүндээ цэвдэгтэй хар шороон ба нугын хар хүрэн хөрстэй голлон сөөг оролцсон өвслөг ургамалтай дундаж уулсын хоорондохи нуга, хөндий	66225.6	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр, боломжтой газраас хадлан бэлтгэнэ. Өрхийн тариаланд түүвэрлэн ашиглах

31	Нугархаг хээрийн дундаж ба нам уулсуулс хоорондын тэгшивтэр хөндий	Уулын хар хүрэн ба хүрэн хөрстэй өвслөг ургамалтай дундаж ба нам уулсын хажуу налуу, хормой	393013.2	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглана. Уулын налуу хажуугийн доод хэсгээс тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой.
32		Шавранцар хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын тэгшивтэр хөндий	25287.2	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
41	Хуурай хээрийн дундаж ба нам уулсуулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий, ухаа гүвээт тал	Гүйцэт бус хөгжилтэй хүрэн ба цайвар хүрэн хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай ухаа гүвээт тал хөндий	328662.0	Бүх төрлийн зориулалтаар ашиглах боломжтой бөгөөд газар тариаланд ашиглахдаа хөрс хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай.
42		Уулын хүрэн ба сул хөгжилтэй хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой, хажуу налуу	312213.0	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглана
43		Шавранцар хүрэн, заримдаа хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий	390920.8	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
44		Элсэнцэр хүрэн заримдаа цайвар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай тэгшивтэр ба сулавтар долгиорхог өргөн хөндий	165167.8	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт ашиглана
45		Элсэнцэр хүрэн, заримдаа цайвар хүрэн хөрстэй сөөг бүхий тэгшивтэр ба сулавтар долгиорхог өргөн хөндий	19218.3	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт ашиглана, Сөөгт ургамлыг хамгаалах, эмийн ургамлыг мэргэжлийн байгууллагын хяналтын дор бэлтгэх



46		Сул бэхжсэн хөрстэй сийрэг өвслөг ургамалтай элсэн тарамцаг	11491.3	Нарийн горим тогтоож, эрчимтэй бус хэлбэрээр ашиглах. Газар нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах
51		Чулуурхаг гадаргатай , цайвар хүрэн хөрстэй, сөөг бүхий сийрэг өвслөг ургамалтай нам уулсын орой, хажуу налуу	324539.9	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
52	Цөлөрхөг хээрийн нам уулс, цав толгодот	Хайргархаг бор хөрстэй нам уулс, цав толгодын орой, хажуу налуу	466420.5	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
53	гүвээрхэг ба тэгшивтэр хөндий	Хайргархаг гадаргатай цайвар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай гүвээрхэг ба тэгшивтэр тал хөндий	722641.8	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
54		Хайргархаг бор хөрстэй, сөөг бүхий өвслөг ургамалтай гүвээрхэг ба тэгшивтэр тал хөндий	836440.3	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
61	Цөлийн нам уулс, цав толгод,	Уулын бор хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай нам уулс, цав толгодын орой, хажуу налуу	28372.6	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
62	хужир марзат хотос бүхий гүвээрхэг ба	Уулын бор саарал хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай нам уулс, цав толгодын орой, хажуу налуу, хормой	31870.5	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
63	тэгшивтэр тал хөндий	Бор саарал хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай тэгшивтэр хөндий	295754.0	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах

64		Бор саарал хөрстэй сөөг бүхий сулавтар долгиорхог болон тэшивтэр хөндий	46169.8	Ихээхэн хязгаарлагдмал нөхцлөөр мал болон ан амьтны бэлчээрт ашиглана. Эмийн ургамал бэлтгэх боломжтой боловч мэргэжлийн байгууллагын хяналтын дор гүйцэтгэнэ.
65		Тачир сийрэг өвслөг ургамалтай сул бэхжсэн хөрстэй довцог, бөөрөг элс	8251.5	Хязгаарлагдмал хэлбэрээр малын бэлчээрт ашиглана. Зарим ашигт ургамлыг ашиглахдаа мэргэжлийн байгууллагын хяналтын дор явуулах
66		Сул бэхжсэн хөрстэй сөөг, сөөгөнцөр ургамалтай довцог, бөөрөг элс	18219.7	Экологийн тэнцвэрийг хадгалах зорилгоор ашиглалтаас чөлөөлөх, элсний нүүлтээс сэргийлэх, хөрсжүүлэх арга хэмжээ авах
71		Голын хөндий, нуурын захын аллювийн нуга-намгийн хөрстэй гидрофит ургамал бүхий нойтон нуга	9347.8	Малын бэлчээрт ашиглах, мелорацийн арга хэмжээ авсны үндсэн дэр газар тариаланд хэсэгчлэн ашиглах
72	Бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй, нам хотсууд	Аллювийн нугын хээржсэн ба үелсэн сулавтар хөгжилтэй хөрст өвслөг ургамалтай татмын нуга	99461.7	Ихэнхдээ малын бэлчээрт ашиглагдах ба боломжтой газраас хэсэгчлэн газар тариалан, түүний дотроос усалгаатай тариаланд ашиглах боломжтой.
74		Голын хөндий, нам хотсын хужирлаг мараалаг хээржсэн хөрстэй галофит ургамал бүхий нуга	343437.2	Малын бэлчээр, хадлан бэлтгэл
75		Хээржсэн нугын хужир, мараат хөрстэй галофит өвслөг ба сөөгт ургамалтай нам хотос	73526.9	Голлон малын бэлчээрт ашиглах ба усных үүсвэрийг харгалзан зарим хэсгийг газар тариаланд ашиглаа.
76		Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэл	28250.6	Хязгарлагдмал ашиглалттай
80		Нүцгэн газар	372942.1	Ашиглалтанд тохиромжгүй газар

Хүснэгтээс харвал тус аймгийн нийт нутаг дэвсгэр нь үндсэн 8 ангид хуваагдах ба анги бүрийг ландшафтын нөхцлөөр нь 33 дэд ангид хуваалаа. Эдгээр нь байгалийн бүсийн хувьд уулын тайгаас цөлийн бүсийг хүртэл, босоо бүсшлийн хувьд өндөр уулаас цөлийн нам уулс, цав толгод, хужир марзат нам хот хотсыг хамрах ба цаашдын ашиглалтын хувьд ан амьтан голдуу нутаглах хязгаарлагдмал ашиглалттай газраас нийгмийн бүх төрлийн үйлчилгээнд тохиромжтой үржил шимт хөрс газрууд, байнгын чийгийн дутагшилтай түүндээ зохицсон цөөн тооны фаун бүхий онгон зэлүүд цөлийг багтаажээ. Экологийн чадавхи иймэрхүү ялгаатай байгаа нь нутаг дэвсгэрийн ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх шаардлага гарч байна.

Газар зохион байгуулалтанд 1800-2000 метрээс дээш үнэмлэхүй өндөртэй уулсыг өндөр уул гэж үздэг бөгөөд ийм уулсыг тэдгээрийн хоорондохи гүн атриажилт бүхий 800-1000 метрийн харьцах өндөртэй, хөрсний тогтворжилт муутай, хажуугийн элэгдэлд байнга өртдөг, мөсдөлтийн үеэс үлдсэн сул асарга чулуу бүхий бүтцүүдийг **өндөр уул-уул дотоодын хавцал маягийн хөндийн нуга ба хээр** гэсэн ангид хамрууллаа. Энэ анги нийтдээ 222203.4 га газар буюу аймгийн нутаг дэвсгэрийн 3.5 хувийг эзэлнэ.

Уулын тогтоц нь хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамааран өндөр уулын таг, царам, орой, хажуу налуу болон уулс хоорондын нарийн ам хөндийнүүд нь экологийн нөхцөл, ашиглалтанд тохирох байдлаараа 4 дэд ангид хуваагдана. Энэ ангийн газрыг экологийн нөхцлийг нь алдагдуулалгүй хадгалан хамгаалж, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглахаас гадна аялал жуулчлал, уулын спорт хөгжүүлэхэд нэн тохиромжтой.

Мөн өндөр уулын бүс нь экологийн өвөрмөгц тогтоцыг хадгалсан, ховор нандин биологийн төрөл зүйлийг агуулсан байдаг тул байгалийн унаган тогтоцыг хадгалан үлдээх шаардлагатай.

1500-1800 метрийн өндөртэй дундаж, 1200-1500 метрийн өндөртэй уулс, тэдгээрийн хоорондохи дунд зэргийн атираажилт бүхий уулт тогтоцыг **ойт хээрийн дундаж ба нам уулс-уулсдотоодын нугачаат хөндий** хэмээн ангилсан ба аймгийн нийт нутгийн 8.2 хувийг эзэлнэ.

Гадаргын тогтоц нь хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамаарах бөгөөд дундаж ба нам уулын орой, ар өвөр хажуу налуу ба хормой, уулс хоорондохи нуга, хөндийн экологийн нөхцөл, ашиглалтанд тохирох байдлаараа 3 дэд ангид хуваагдана. Энэхүү уулт бүтэц нь Хангайн нурууны үргэлжлэл болон салбар уулсын аядуу зөөлөн чийглэг сэрүүн уур амьсгалтай, өтгөн, ургац сайтай, зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг нугархаг шинжийн ургамалжилттай, хар шороон бо хар бараан хөрстэй дундаж уулсын орой, баруун ба ар хажуу налуу, хормой, уул хоорондын нарийн ам хөндийг багтаасан нэгэн цогц бүлэг газрууд юм. Уулс хоорондын нарийн хөндийд цэвдэгшлийн овойлтын дов, хүйтний хагаралтай, гадаргын болоод гүний усны хангамж сай, томоохон голын эхүүд энэ газруудаас үүдэлтэй.

Уулсын оргил нь тэгш хавтгай, эсвэл бөмбөгөрдүү хэлбэртэй, налуу хажуу нь алгуур, хөрс нь харьцангуй сайн тогтворжсон, үе давхаргын ялгарал сайтай, үржил шимээр сайн боловч тархалтын хувьд алаг цоог, бага талбай эзлэх учраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад үр ашиг багатай, өрхийн аж ахуй, жижиг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан түүвэрлэн ашиглах

боломж хэдийг ч цэвдэгшлийн нөлөөг бууруулах зорилгоор шим бордоогоор бордож хөрсний дулааны горимыг зохицуулах шаардлагатай.

Энэ ангийн газрыг экологийн нөхцлийг нь алдагдуулалгүй биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамлыг мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглах, аялал жуулчлал, уулын спорт хөгжүүлэх, зэрлэг ан амьтан, бүх төрлийн малын бэлчээрт ашиглахад тохиромжтой. Нуга хөндийгөөр нь хадлан бэлтгэх, өрхийн тариаланд түүвэрлэн ашиглах боомжтой юм.

Өндөр уулын бүсийн адил экологийн өвөрмөгц тогтоцыг хадгалсан, ховор нандин биологийн төрөл зүйлийг агуулсан байдаг тул байгалийн унаган тогтоцыг хадгалан үлдээх зорилгоор тусгай хамгаалалтанд авах шаардлагатай.

Аймгийн нутаг дэвсгэрийн хот хэсгийн ойт хээрийн бүсийн залгаанд орших завсарын бүсийн уулс, тэдгээрийн хоорондохи өргөвтөр тэгшитэр хөндий бүхий нугачаат тогтоцыг **нугархаг хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр хөндий** хэмээн ангилсан ба аймгийн нийт нутгийн 6.7 хувийг эзэлнэ.

Гадаргын тогтоц нь хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамаарч дундаж ба нам уулын орой, ар өвөр хажуу налуу, уулс хоорондохи тэгшивтэр хөндий гэсэн 2 дэд ангид хуваагдана.

Эндэхийн уулс нь бөмбөгөр оройтой, налуу хажуутай, хад чулуу багатай, харьцангуй сайн тогтворжсон хөрсөн бүрхэвчтэйгээс гадна уулс хоорондын хөндий нь өргөн тавиу ашиглалтанд тохиромжтойгоос гадна хөрс нь үржил шим сайтай, гол төлөв шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй учраас ашиглалт даах чадвар нь харьцангуй сайн. Харин элсэнцэр хөрс алаг цоог тааралдана.

Энэ ангийн газар агроүйлдвэрлэлийн нилээд сайн чанартай газарт тооцогддог бөгөөд бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглахаас гадна уулын хормой, хөндийг тариаланд ашиглах боломжтой. Гэхдээ хөрс хамгаалалтын болон хөрсний үржил шимийг дээшлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

**Хуурай хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий** анги нь тус аймгийн нутаг дэвсгэрийн төв хэсгээр баруунаас зүүн тийш нарийн зурвас газарт тархаж нутаг дэвсгэрийн 39.6 хувийг эзэлнэ. Эндэхийн дундаж ба нам уулс нь хавтгай ба бөмбөгөрдүү оройтой, хажуу налуу нь ихээхэн мөлгөр, атриажилт багатай, харьцангуй сайн тогтворжсон хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй хөрстэй, уур амьсгал харьцангуй дулаан боловч хуурай байдаг. Үүнтэй холбоотойгоор ухаа гүвээ, толгодын орой, хажуу налуугаар гүйцэд бус хөгжилтэй хүрэн хөрстэй, нам ба дундаж уулсын хажуу налуу, хормойгоор уулын хүрэн ба уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрс, тал хөндийгөөр нь шавранцар ба элсэнцэр хүрэн хөрс, сул бэхжсэн элсэн хөрс бүхий багахан хэсэг газар энэ ангид хамрагдана. Хүрэн хөрс нь гол төлөв бэлчээрт ашиглагддаг ба агроүйлдвэрлэлийн дунд зэргийн чанартай хөрс юм.

Усны эх үүсвэрийг түшиглэн усалгаатай тариаланг хөгжүүлэх боломжтой. Хүрэн хөрсийг ашиглахад ус чийгийн горимоос гадна хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй учраас салхины эвдрэлээс хамгаалах арга хэмжээг эрчимтэй авах шаардлагатай.

Газрын гадаргын тогтоц, хөрсний ялгаагаараа нийт 6 дэд ангид хуваагдаж байна.

Хээрийн болон говийн бүсийг заагаар тархсан **цөлөрхөг хээрийн нам уулс, цав толгодот гүвээрхэг ба тэгшивтэр хөндийн ангид хамрагдах газрууд нь** Хангайн нуруунаас урагш хээрийн бүсийн өмнөд залгаанд уулс, цав толгодорр хэрчигдсэн харьцангуй өргөн хөндийнүүдийг багтаана. Цөлийн уур амьсгалын нөлөөгөөр ургамлан бүрхэвч нь сийрэгжин, хад асга ихсэж, сайрын хэрчигдэл нэмэгдэнэ. Уулс, цав толгодын хоорондохи гүвээ бүхий талархаг гадарга нь өнгөндөө нилээд хайргархаг, үржил шим муутай цөлөрхөг хээрийн бор хөрстэй. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд монгол өвс голлосон хазаар өвс, боролзой, шаваг, баглуур, бударгана зэрэг ургамал оролцоно. Бэлчээрийн ургац тийм ч өндөр биш боловч ургамлын шимт чанар сайтай учир малд олон талын ач холбогдолтой. Гадаргын усан хангамж муутай, харин хөрсний усны нөөц нилээд сайн учир гол төлөв худаг гаргах замаар усжуулах боломжтой. Цөлөрхөг хээрийн бүсийн хойт ба урд захад хээрээс цөлөрхөг хээрт шилжих, өмнөд захаар цөлөрхөг хээрээс цөлд шилжих завсрын бүсэд хээрийн цайвар хүрэн хөрс, цөлийн бор саарал хөрс цөлөрхөг хээрийн бор хөрстэй, цөлөрхөг хээрийн ба цөлийн ургамал ихээхэн холимог байдалтай тархжээ.

Энэ анги нь нийт нутаг дэвсгэрийн 37.6 хувийг эзлэх бөгөөд гадаргын ба хөрс ургамлын шинж төрхөөрөө 4 дэд ангид хуваагдаж байна.

**Цөлийн нам уулс, цав толгод, хужир марзат хотос бүхий гүвээрхэг ба тэгшивтэр тал хөндийн анги** нь тус аймгийн нутаг дэвсгэрийн өмнөд захаар цухасхан түрэн орж ирдэг ба нийт нутаг дэвсгэрийн 6.9 хувийг эзэлнэ. Гадаргын тогтоц, ургамлан ба хөрсөн бүрхэвч, чийгийн хангамжаараа ялгарах 6 дэд ангид хуваагдана. Цөлийн бор саарал хөрстэй бүх төрлийн малын бэлчээрт ашиглагддаг, агроүйлдвэрлэлийн доод чанарын газрууд юм.

Сул бэхжсэн хөрстэй сөөг, сөөгөнцөр ба тачир сийрэг өвслөг ургамалтай сул бэхжсэн хөрстэй довцог, бөөрөг нь экологийн хувьд ихээхэн эмзэг тул хязгаарлагдмал ашиглалттай байх бөгөөд зарим ашигт ургамлыг мэргэжлийн байгууллагын хяналтын дор явуулах, зарим хэсэгт ашиглалтаас чөлөөлж, элсний нүүлтээс сэргийлэх, хөрсжүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

Байгаль нутаг дэвсгэрийн аль ч бүсэд тохиолдох газруудыг **бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй нам хотсуудын** ангид хамруулсан бөгөөд энэ нь аймгийн нуьтаг дэвсгэрийн 8.9 хувийг эзэлж байна.

Энэ газрын онцлог нь усны байнгын болон түр зуурын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч бага орон зайд эрс ялгаатай, ургамлан нөмрөгт чийгсүү ба давссуу ургамал зонхилдог явдал юм.

Гадаргын ба гүний усны байнгын нөлөөгөөр үүссэн аллювийн нуга-намгийн хөрс болон аллювийн нугын хээржсэн, мөн үелсэн тогтоцтой сулавтар хөгжилтэй хөрст өвслөг ургамалтай татмын нуга нь малын бэлчээрт ашиглах, мелорацийн арга хэмжээ авсны үндсэн дэр газар тариаланд хэсэгчлэн ашиглахад тохиромжтой байхад түр зуурын усны нөлөөнд байдаг хужирлаг мараалаг болон нугын хужир, мараат хөрстэй галофит өвслөг ба сөөгт ургамалтай нам хотсууд малын сайн чанарын бэлчээр болдог. Гэхдээ усны эх үүсвэрийг харгалзан зарим

хэсгийг газар тариаланд түүний дотор дулааны нөөц их шаарддагддаг жимс ногоонд зориулан ашиглах боломжтой.

Нам хотсыг хүрээлсэн өндөрлөгөөс буусан хурын усны нөлөөгөөр үүссэн гуу жалгууд энэхүү ангид хамрагдах ба энэ ашиглалтын хувьд хязгарлагдмал байна.

Нутаг дэвсгэрийн нилээд хэсэгт нүцгэн элс, хайрга чулуугаар хучигдсан, сайраар хэрчигдсэн, хад, цохио, чулуун асарга, шал тойром тааралдах ба эдгээрийг **нүцгэн газрын** ангид хамруулав. Ийм газар 6 орчим хувийг эзэлнэ.

Довцог, молцог, зоо сэвхүүл манхан зэрэг янз бүрийн хэлбэрээр тогтсон элс ургамлан бүрхэвчгүй тул ХАА-д ашиглах боломжгүй юм. Гэвч барилгын болон эмчилгээний чиглэлээр ашиглахад боловчтой. Гэвч тогтоц султай учраас ашиглалтын явцад салхины нөлөөгөөр байнга зөөгдөж, байгаль экологи болон улс ардын аж ахуйд хөнөөл учруулдаг.

## 6.2. Газрын эдийн засгийн үнэлгээ, удирдлага, зохион байгуулалт

### 6.2.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр тус аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт дараахи байдалтай байна. /Хүснэгт 37/

#### Хүснэгт 37. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн байдал

Д/д	Өөрчлөлттэй он	Төлөвлөлтийн өмнө	Төлөвлөлтөөр	Зөрүү+-
	<b>Газрын ангилал</b>			
	Нийт нутгийн хэмжээ	6289533	6289533	
	ХАА-н газар бүгд	5767846.9	5745743.9	-22103.0
1	Үүнээс: Бэлчээр	5716954.7	5692895.8	-24058.9
	Хадлан	5821.8	8729.8	2908.0
	Тариалан	6949.5	42664.3	35714.8
	Атаржсан газар	36981.7	314.9	-36666.8
	ХАА-н барилга	1139.1	1139.1	0.0
	2	Хот тосгон бусад суурин газар	18997.5	22441.3
	Зам шугам сүлжээний газар	9787.1	19322.4	9535.3
3	Үүнээс: Эрчим хүчний	1761.9	4403.4	2641.5
	Холбооны	1006.3	1006.3	0.0
	Авто зам	6343.2	8054.2	1711
	Төмөр зам	0.0	5182.8	5182.8
	Бусад	675.7	675.7	0.0
4	Ойн сан бүхий газар	192278.0	196124.0	3846.0
5	Усан сан бүхий газар	3318.3	3318.3	0.0
6	Тусгай хэрэгцээний газар	297305.0	302583.0	5278.0
	Үүнээс: Тусгай хамгаалалтай	290628.0	295906.0	5278.0
	Бусад	6677.0	6677.0	0.0

Дээрх хүснэгтээс харахад уламжлалт мал аж ахуйн зориулалтаар дундаа чөлөөтэй ашигладаг бэлчээрийн хэмжээ ихээхэн багасаж түүнийг төрөлжсөн үйлдвэрлэлийн эрчимжсэн аж ахуйнуудад эзэмшүүлэх, одоо байгаа атаржсан талбайнуудыг нөхөн сэргээж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлснээр одоо байгаа тариалангийн талбай нэмэгдэж байна.

Зам, шугам сүлжээний газар болон төлөвлөгдсөн төмөр зам, авто замуудад хамгаалалтын бүс татсанаар эдгээр ангиллын газар нэмэгдэж бэлчээрийн газар хасагдана.

Усан сан бүхий газрын экологийн хамгаалалтын бүс, ундны усны хамгаалалтын бүсийг газар нөөшлөх бүсэд хамрууллаа. Усны хамгаалалтын буюу усны эрэг орчмын бүсийг ширгэсэн болон байнгын урсгалтай голуудыг оролцуулсан ба нийт 58768.3 га газрыг хамарсан.

Газар болон ховор ландшафтыг хадгалах бүсийн хувьд аймгийн хэмжээнд сум болон аймгийн хамгаалалтанд авсан 18 тусгай хамгаалалттай газар байдаг бөгөөд төлөвлөлтөөр 12 орчим түүх соёлын болон байгалийн дурсгалт газруудыг аймгийн хамгаалалтанд авахаар нийт 5278.0 га газрыг төлөвлөсөн.

Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүдэд бэлчээр, хадлан, тариалангийн газрууд орж байна. Төлөвлөлтийн өмнө бэлчээрийн газар нь 5716954.7 га байсан бол төлөвлөлтөөр 5692895.8 га болсон. Бэлчээрийн талбайгаас хасагдсан хэмжээ нь хадлангийн болон тариалангийн талбай, зам, шугам сүлжээний газар, усан сангийн газарт нэмэгдэж байна. Бэлчээрийг 4 бүс болгон төлөвлөж байгаа бөгөөд эдгээрт хуваарьт эдлэнтэй эрчимжсэн аж ахуйн бүс 75928.26 га, хуваарьт эдлэн, нийтийн ашиглалтын газар хосолсон аж ахуйн бүс 177387.42 га, өрхийн аж ахуйн суурьшлын бүс 9530.0 га, чөлөөт ашиглалтын болон отрын нөөц бэлчээр, бусад бэлчээрийн газрууд 4893387.39 га байна.

Хадлангийн газрын хувьд одоо байгаа 5821.8 га, цаашид 8729.7 га талбайгаас хадлан бэлтгэх боломжтой юм. Төлөвлөлтөөр 2907.9 га талбайг хадлан нэмж ашиглах боломжтой байна. Өөрөөр хэлбэл энэ нь хадаж болох бэлчээр юм.

Тариалангийн газрын эзэмшилт-ашиглалтын 3 бүсийг төлөвлөгдөж байгаагийн 36086.35 га нь аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил-ашиглалтад олгогдож байна. Энэ нь төлөвлөгөөний өмнөх үеийнхээс 36666.84 га талбайгаар нэмэгдсэн буюу энэ талбай нь атаржсан тариалангийн талбайнуудыг эргэн ашиглана. Шинээр атар газрыг зөвхөн өрхийн тариалангийн зориулалтаар багахан талбайг энд тэнд төлөвлөж байна. Зайн хувьд алслагдсан, услалт ашиглах боломжгүй 314.86 га атаршсан талбайг цаашид бэлчээрт шилжүүлж ашиглана.

Ойн сан бүхий газрын хэмжээ нь 192278.0 га бөгөөд төлөвлөлтөөр тус ангиллын газар 196124.0 га болж өөрчлөгдсөн нь Богд суманд байгуулах Ногоон хэрмийн зурвас юм.

**6.2.2. Газрын эдийн засгийн үнэлгээ**

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр газрын нэгдмэл сангийн хүрээнд, ашиглалтын зориулалт, хэмжээ нилээд өөрчлөгдлөө. Үүнтэй холбоотойгоор газрын төлбөр нийлээд нэмэгдэж байна.

Газарт ногдуулах төлбөрийн доод болон дээд хэмжээ, бүсчлэлийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтад заасны дагуу авч тооцсон болно.


**Хүснэгт 38. Газрын төлбөрийн өөрчлөлт**

ДД	Газрын менежментийн бүсүүд	төлөвлөлтийн өмнөх үе		төлөвлөлтийн 1-р үед		төлбөрийн өөрчлөлт /мян.төг/
		талбай /га/	төлбөр /мян.төг/	талбай /га/	төлбөр /мян.төг/	
1	Хот суурины барилга байгууламжийн дэвсгэр газар	290.65	24323.7	331.7	27755.8	3432.1
	ШТС, авто машины зогсоол	12.45	996	31.13	2490.0	1494.0
	Гэр хороолол	714.7	8942.8	860.3	10765.0	1822.2
2	Аялал жуулчлалын бүс	12.6	2521.9	31.254	6255.5	3733.6
3	Усан сан бүхий газрын экологийн хамгаалалтын бүс			58768.3	23507.3	23507.3
4	Хуваарьт эдлэнтэй эрчимжсэн аж ахуйн бүсийн бэлчээр			141816.6	108842.8	108842.8
5	Хуваарьт эдлэн, нийтийн ашиглалтын газар хосолсон аж ахуйн бүсийн бэлчээр			20272.5	15558.9	15558.9
6	Бэлчээр			1423224.0	811237.7	811237.7
6.1.	Бэлчээрээс усны эрүүл хамгаалалтын бүсэд орох газар			16232.625	13107.8	13107.8
6.2.	Бэлчээрээс зам, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд орох газар			2680.0675	2164.2	2164.2
7	Хадлангийн газар			2182.425	539.1	539.1
8	Тариалангийн газар	5912.8	2607	10753.5	4741.3	2134.3
9	Уурхайн дэвсгэр газар	2221.6	12748	5261.7	30192.7	17444.7
<b>Нийт дүн</b>			<b>52139.4</b>		<b>1057158.2</b>	<b>1005018.8</b>

Хүснэгт 24-ээс харвал эрчимжсэн аж ахуйн газрын төлбөрийн орлого 2020 оны түвшинд давамгайлсан хэвээр байх болно. Мөн хот суурин газарт 26993.4 мян.төгрөгөөр нэмэгдэх боломжтой бол ХАА-н бүс газарт 3753251.1 мян.төгрөгөөр төлбөр нэмэгдэх бөгөөд үүнээс бэлчээрийн газарт 3742557.6 мянган төгрөг, хадлангийн газарт 2156.2 мянган төгрөг, тариалангийн газарт 8537.25 мянган төгрөг нэмэгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан.



**Диagramм 6. Газрын төлбөрийн бүтэц**



Тайлбар: 1-хотжсон бүс, 2-ШТС, автомашины зогсоол, 3-Гэр хороолол, 4-Аялал жуулчлалын бүс, 5-Усан сан бүхий газар, 6-Эрчимжсэн аж ахуйн бүс, 7-Хосолмол аж ахуйн бүс, 8-БЧөлөөт ашиглалтын бэлчээр, 9-хадлангийн газар, 10-тариалангийн газар, 11-Уурхайн дэвсгэр газар

Газрын сангийн өөрчлөлттэй холбоотойгоор түүнээс авч болох ашгийг тооцож үзвэл: Тариалангийн газрын хэмжээ одоогийн байгаа атаржсан талбайг эргэлтэнд оруулснаар 36086.0 га-гаар нэмэгдэх ба үүний 566.0 га-г иргэний хувийн хэрэгцээнд төмс, хүнсний ногоо тариалах зорилгоор олгох бөгөөд иргэд үүний үр дүнд 4406.0 тн төмс, хүнсний ногоо шинээр хураан авч зах зээлийн үнээр 88.0 сая орчим төгрөгийн цэвэр ашиг жилд хуримтлагдана.

36086.35 га талбайг тариалангийн талбайд нэмж элдэншүүлэн аж ахуйн нэгж байгууллагад олгосноор жилд 7.7 сая төгрөгийн төлбөр авдаг байснаа 38.7 сая төгрөг хүргэх боломжтой.

Хадлангийн талбайг 2907.9 га-гаар нэмэгдүүлж 1 га хадлангийн талбай ашигласны төлбөрийг 250 төгрөгөөр тооцвол 2156.2 мянган төгрөг нэмж орон нутгийн төсөвт орно.

Зарим газруудын ашиглалтын горимын бүсүүдтэй холбоотойгоор бэлчээрээс ашиглах тухайн бүсийн газрын төлбөрийг тооцсон бөгөөд бэлчээрээс тухайн горимын бүсийн талбайг ашигласан тохиолдолд төлбөр тооцох механизм байж болох юм.

**Газрын сангийн удирдлага, зохион байгуулалт.** Орон нутгийн газрын харилцааг сайжруулж өнөөгийн шаардлагын түвшинд хүргэхийн тулд доорхи ажлыг нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1. Аймгийн газрын алба, сумдын газрын даамлыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж давтан сургах, мэргэшүүлэх

2. Сумдын даамлыг бие даасан орон тоогоор ажиллуулж, хүн амын төвлөрөл ихтэй Хархорин ба Арвайхээр сумдад газрын даамлын орон тоог нэмэгдүүлэх
3. Аймаг, сумын газрын мэдээллийн санг байгуулж, холбогдох тоон мэдээллээр хангах
4. Газрын зураглал, хэмжилтийн багаж тоног төхөөрөмж, байрзүйн болон кадастрын зургаар хангах
5. Сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шаардлагын түвшинд боловсруулж ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол механизм болгох
6. Газрын нэгдмэл сангийн ангилал тогтоох, тоо бүртгэлийн судалгаа болон өмчлүүлэх газрын хянан баталгааг нэн даруй хийлгүүлэх
7. Газрын төлбөрийн жилийн орлоготой нь уялдуулан газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газрын менежментийг сайжруулах ажлын зардлыг төлөвлөн жил бүрийн төсөвт тусгуулан хэрэгжүүлэх
8. Газрын менежментийн бодлогоор тодорхойлогдсон арга хэмжээг тухайн ангиллын газар эзэмшигч, ашиглагчдын газар эзэмших, ашиглах гэрээнд нарийн тусган хэрэгжилтэнд хяналт тавих
9. Газрын төлөв байдлыг хянах “газрын мониторингийн сүлжээ”г байгуулах, шаардлагатай хөрөнгийг газрын дуудлага худалдаа, болон бусад орлогоос төвлөрүүлэх

## ДҮГНЭЛТ

Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд аймгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн ба ирээдүйн чиглэлийг нутаг дэвсгэрийн экологи-орон зайн багтаамжид түшиглэн 4 жилийн шатлалтай 2020 он хүртэлхи хугацааг хамруулав.

Энэхүү газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь судалгаагаар нь тус аймгийн нутаг дэвсгэрийн экологи-орон зайн багтаамж, даацыг тодорхойлж, түүнд зохицсон газар ашиглалтын төлөвлөлтийг орон зайн шийдлээр хангаж, аймгийн газрын мэдээллийн сангийн орон зайн мэдээллийг дунд масштабын зураглалын нарийвчлалаар иж бүрдүүлж, газарзүйн мэдээллийн системийг ашиглаж боловсруулалт хийснээрээ онцлог бөгөөд ерөнхий төлөвлөгөөд газрын үндсэн 6 ангилалын газрын менежментийн бүс, газрыг хадгалан хамгаалах зураг, хот суурингийн зураг хийгдэж тоон мэдээлэлд хөрвөсөн нь цаашид газар зохион байгуулалтын болон газрын кадастрын үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн голлох салбар нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл бөгөөд цаашид ч энэ чиглэлээ төлөвлөлтийн үе шатуудад хадгалах боловч улс орны хөгжлийн түвшин, зах зээлийн хэрэгцээ, газар болон байгалийн бусад баялгийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын үүднээс ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, түүнд зохицсон нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг шийдвэрлэсэн болно. Иймээс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн бааз бэлчээр ашиглалтын уламжлалт хэлбэрийг өөрчлөн 4 хувилбартай ашиглалтын бүтцийг зөвлөж байна. Ингэснээр эрчимжсэн аж ахуйн бүсэд бэлчээр ашиглалтын 4 хувилбарыг харин чөлөөт ашиглалтын бүсэд улирлын сэлгээт хувилбарыг зөвлөж байна.

Эрчимжсэн мал ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлэх, дотоодын хүнсний хэрэгцээг хангахад газар тариалангийн үйлдвэрлэл чухал үүрэгтэй бөгөөд 2020 оны түвшинд тариалангийн талбайг бараг 20 дахин нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

Голлох нэрийн бүтээгдэхүүн болох гурилын хэмжээ аймгийн хүн амын хэрэглээнд харьцуулбал маш хангалтгүй байгаа бөгөөд цаашид ч дотоод гадаадын гурилыг импортлохшаардлага гарна.

Усны эх үүсвэрүүдийг түшиглэсэн усалгаатай хүнсний ногооны тариалангийн хэмжээ 300 гаруй га-гаар нэмэгдэх шаардлагатай.

Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд аж үйлдвэрлэлийн салбарт дэд бүтцийн хангамж сайжрах ба одоо байгаа болон цаашид ашиглах орд илрэлүүдийг нэмж ашиглах, Хархорины УЦС-ыг сэргээх бодлогууд тусгасан болно.

Ойн болон усан сангийн газрын менежментэд төлөвлөлтийн стандарт нормыг баримтлан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоосноор өгөөнийн газар эзэмшигч ашиглагчдын тодорхой хэсэг газар чөлөөлөх шаардлага гарч байна.

Хот суурин газарт шинээр баригдах болон одоо байгаа улс, аймгийн зэрэглэлтэй хотуудад газрын хүрэлцээг харгалзан өнөөгийн суурьшлыг

нягтшруулах, хот тэлэх бүсийг тогтоолоо. Жижиг суурин тосгодын тоонд сумын төвүүдийг хамруулж зөвхөн дотоод бүсчлэлийг тодруулах замаар төлөвлөлтийг хийв.

Газрын харилцаа нь нэг талаас газар ба байгаль орчныг хамгаалах, нөгөө талаас газрын харилцаанд оролцогчдын эрх ашгийг хуулийн хүрээнд тогтвортой баталгаажуулах үндэслэлийг бүрдүүлдэг ба газрын менежментийг бүс тус бүрт ашиглалт хамгаалалтын горимыг зөвлөсөн болно.

Газар эзэмшилт ашиглалтын өнөөгийн байдлыг боловсронгуй болгосноор газрын эдийн засгийн харилцаанд өөрчлөлт орж газрын төлбөрийн орлого бараг 10 дахин өсч байна.

Энэхүү газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь судалгаагаар нь тус аймгийн нутаг дэвсгэрийн экологи-орон зайн багтаамж, даацыг тодорхойлсон ба төлөвлөлтийг орон зайн нэгдсэн шийдлээр хангаж, орчин үеийн газарзүйн мэдээллийн системийг ашигласан болно.

Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд үндсэн 6 ангийн газруудын бүсийн зураг, газрыг хадгалан хамгаалах болон томоохон хот суурин орчмын газрын нарийвчлалыг нэмэгдүүлэн том масштабын зургаар хангав.

**Ашигласан ном, бүтээлийн жагсаалт****Ном, бүтээл**

1. Э.М. Мурзаев. “ К физикогеографическому районированию МНР” . Проблемы физической географий. Вып. 13.1948.
2. Ш.Цэгмид. Монгол орны физик газар зүй УБ-1967
3. Өвөрхангай аймгийн хөрс судалгааны материал 1986 он
4. В. Каромышева, Д.Банзрагч кн. “Растительный и животный мир Монголий” П. 1977.
5. Г. Цолмон “Монгол орны бэлчээр хадлангийн ангилал”ГБХ.1993
6. Ч.Гончигсумлаа.Хөрс судлалын үндсүүд УБ-1995
7. Дикорастующие полезные растения флоры МНР. т. XXIII “Наука”
8. Ш.Баясгалан Д.Даваадорж . Монгол орны ХАА-н уур амьсгалын лавлах.1996.
9. Г.Пүрэвцэрэн., Ж.Наранцацралт. Газрын менежментийн онолын үндэс. 2000 он
- 10.Г.Пүрэвцэрэн Газрын сангийн менежмент 2000 он
- 11.Д.Доржготов.Монгол орны хөрс УБ-2003
- 12.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан. ГХГЗЗГ. 2002, 2003, 2004
- 13.Өвөрхангай аймгийн цаг уурын станцын мэдээ. 2003 он
- 14.Өвөрхангай онол практикийн бага хурлын илтгэлүүд 2004 он
- 15.Бэлчээрийн биобүтээмж” МААЭШХ. ШУТ-ийн төслийн э/ш тайлан 2000он.УБ.
- 16.Улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан 2003 он
- 17.Л.Уранбилэг “Нийслэл орчимд сүүний эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн агроэкологийн үнэлгээ” сэдэвт магистрын ажил 2003 он
- 18.Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2004 он.
- 19.Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2003 он
- 20.Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. 2003 он
- 21.“Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр.
22. Өвөрхангай аймгийн статистикийн эмхтгэл. 2004 он
- 23.Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээ, түүний үнэлгээ. 2003 он.

**Хууль тогтоомж :**

Газрын тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль.

Газрын хэвлийн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он

Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он

Төрөөс экологийн талаар баримтлах бодлого

Ойн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он

Усны тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он

Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хууль. Ардын эрх сонин. 1994 он

Автозамын тухай хууль. Ардын эрх сонин. 1998 он.

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хууль. Ардын эрх сонин. 1996 он.

Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралт

Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэм. 2004 он

Бүсчилсэн хөгжлийн тухай хууль

“Мянганы зам” төсөл

Монгол Улсын аялал жуулчлалын мастер төлөвлөгөө.